
МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

Дугаар №12

Улаанбаатар хот
2018 оны 12 дугаар сар

**НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:
САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА**

ГАРЧИГ	
ӨМНӨХ ҮГ	7
ТОЙМ	8
1. МАКРО-САНХҮҮГИЙН ОРЧИН	10
1.1 Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн тойм	10
Дэлхийн эдийн засаг	10
Дэлхийн санхүүгийн зах зээл	13
1.2 Монгол Улсын макро эдийн засгийн тойм	16
Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал	16
Гадаад сектор	19
Бодит сектор	30
Мөнгө санхүүгийн сектор	33
Улсын төсөв	47
2. САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ДАРХЛАА	52
2.1 Банкны салбарын төлөв байдал	52
Банкны салбар	52
Макро зохистой бодлого, түүний хэрэгжилт	58
Хадгаламжийн даатгал	53
2.2 Банкны бус санхүүгийн салбарын төлөв байдал	61
Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо	61
Хөрөнгийн зах зээл	67
Даатгалын салбар	69
Зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэгч байгууллага	73
Хөдөө аж ахуйн бирж ба түүхий эдийн арилжаа	73
3. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИ	74
3.1 Хууль, эрх зүйн орчинд гарсан өөрчлөлт	74
3.2 Төлбөр тооцооны систем	77
3.3 Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаа	81

ДҮРСЛЭЛҮҮД

Дүрслэл 1.1	Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	10
Дүрслэл 1.2	АНУ-ын эдийн засгийн зарим гол үзүүлэлтүүд	11
Дүрслэл 1.3	Евро бүсийн ажилгүйдлийн түвшин	12
Дүрслэл 1.4	БНХАУ-ын нүүрсний импорт (сая тонн)	13
Дүрслэл 1.5	Зарим түүхий эдийн үнэ	13
Дүрслэл 1.6	Зарим хөрөнгийн захын индекс	13
Дүрслэл 1.7	Хөгжингүй улс орнуудын бодлогын хүү	14
Дүрслэл 1.8	Зарим хөгжингүй орнуудын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж	14
Дүрслэл 1.9	Голлох валютуудын ам.доллартай харьцах ханш	15
Дүрслэл 1.10	Импортын жилийн өсөлт	16
Дүрслэл 1.11	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	17
Дүрслэл 1.12	Монгол Улсын улирлын ДНБ-ий жилийн өсөлт	17
Дүрслэл 1.13	Гадаад, дотоод цэвэр актив болон M2 мөнгө	17
Дүрслэл 1.14	Монгол Улсын санхүүгийн мөчлөг	18
Дүрслэл 1.15	Инфляцийн задаргаа (УБ хот)	18
Дүрслэл 1.16	Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл	19
Дүрслэл 1.17	Урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл	19
Дүрслэл 1.18	Урсгал тэнцлийн санхүүжилт	20
Дүрслэл 1.19	Санхүүгийн дансны бүтэц	20
Дүрслэл 1.20	Гадаад худалдааны нөхцөлийн индекс	21
Дүрслэл 1.21	Нийт экспорт	21
Дүрслэл 1.22	Нийт импорт	21
Дүрслэл 1.23	Гадаад худалдааны нөхцөлийн индекс, уул уурхайн түүхий эдийн бүтээгдэхүүний үнэ	22
Дүрслэл 1.24	Гадаад валютын ханш	22
Дүрслэл 1.25	Валютын захын дарамтын ЕМР индекс	22
Дүрслэл 1.26	Гадаад өрийн үлдэгдэлд суурилсан үзүүлэлт	24
Дүрслэл 1.27	Гадаад валютын албан нөөц	24
Дүрслэл 1.28	Гадаад валютын албан нөөц/Богино хугацаат гадаад өр	24
Дүрслэл 1.29	Эдийн засгийн өсөлтийн задаргаа	30
Дүрслэл 1.30	Бодит ДНБ, нийт зээлийн өсөлт, нийт зээлийн чанар	30
Дүрслэл 1.31	Өрхийн хэрэглээ, нийт хэрэглээний зээл, хэрэглээний импортын өсөлт	31
Дүрслэл 1.32	Хөрөнгө оруулалт, бизнесийн зээл, хөрөнгө оруулалтын импортын өсөлт	31
Дүрслэл 1.33	Уул уурхайн салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар	31
Дүрслэл 1.34	Боловсруулах салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар	32
Дүрслэл 1.35	Барилгын салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар	32
Дүрслэл 1.36	Худалдааны салбарын үйлчилгээ, зээлийн өсөлт, зээлийн чанар	32
Дүрслэл 1.37	Бусад салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар	32
Дүрслэл 1.38	Өрхийн орлого, зарлагын харьцаа	33
Дүрслэл 1.39	Өрхийн орлого зарлагын зөрүү, хэрэглээний зээлийн өсөлт	33
Дүрслэл 1.40	Өрхийн өрийн дарамт	33
Дүрслэл 1.41	Иргэдийн зээлийн ДНБ-д эзлэх хувь	34
Дүрслэл 1.42	Иргэдийн зээлийн үлдэгдэл, чанар	35
Дүрслэл 1.43	Иргэдийн чанаргүй зээлийн хувь, валютын төрлөөр	35

Дүрслэл 1.44	Орон сууцны үнэ, ипотекийн зээлдэгчдийн тооны өсөлт	35
Дүрслэл 1.45	Орон сууцны үнэ, ипотекийн зээлдэгчдийн жилийн өөрчлөлт	36
Дүрслэл 1.46	Өрхийн өр, орлогын харьцаа	36
Дүрслэл 1.47	Шокуудын нөлөөлөх суваг	38
Дүрслэл 1.48	Зээлийн хүүний шокийн нөлөө	38
Дүрслэл 1.49	Хэрэглээний зардлын шокийн нөлөө	38
Дүрслэл 1.50	Ажилгүйдлийн шокийн нөлөө	39
Дүрслэл 1.51	Нийлмэл шокийн нөлөө	39
Дүрслэл 1.52	Аж ахуйн нэгж байгууллагын нийт өр төлбөр ба ДНБ-ий харьцаа	40
Дүрслэл 1.53	Өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа	40
Дүрслэл 1.54	Активын өгөөж	40
Дүрслэл 1.55	Хүү төлөх чадварын харьцаа	41
Дүрслэл 1.56	Хувийн хэвшлийн зээл, зээлийн чанар	41
Дүрслэл 1.57	Хувийн салбарын өрийн дарамт	41
Дүрслэл 1.58	Мөнгөний үзүүлэлтүүд (жилийн өсөлтийн хувь)	44
Дүрслэл 1.59	M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа	44
Дүрслэл 1.60	Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц ба хандлага	44
Дүрслэл 1.61	Мөнгөний нийлүүлэлт болон мөнгөний үржүүлэгч	45
Дүрслэл 1.62	Банкнудын хадгаламж болон зээлийн хүү	45
Дүрслэл 1.63	Банк хоорондын захын хүү	45
Дүрслэл 1.64	Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх интервал	46
Дүрслэл 1.65	Нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн жилийн өөрчлөлт	48
Дүрслэл 1.66	Нэгдсэн төсвийн тэнцлийн гүйцэтгэл	49
Дүрслэл 1.67	Бондын эргэн төлөлт	50
Дүрслэл 2.1	Банкны салбарын активын бүтэц	52
Дүрслэл 2.2	Банкны салбарын пассивын бүтэц	52
Дүрслэл 2.3	Банкны салбарын актив, пассивт гарсан өөрчлөлт	53
Дүрслэл 2.4	Банкны салбарын эх үүсвэрийн жилийн өсөлт	53
Дүрслэл 2.5	Зээлийн өсөлтөд иргэдийн, байгууллагын зээлийн өсөлтийн эзлэх хувь	54
Дүрслэл 2.6	Банкны салбарын актив, зээлийн жилийн өсөлт	54
Дүрслэл 2.7	Олгосон зээлийн жилийн өсөлт	54
Дүрслэл 2.8	Салбаруудын зээлийн төвлөрөл	54
Дүрслэл 2.9	Зээлийн чанарын үзүүлэлт, салбараар	55
Дүрслэл 2.10	Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн жилийн өсөлт	55
Дүрслэл 2.11	Чанаргүй зээлийн харьцаа, валютын төрлөөр	56
Дүрслэл 2.12	Өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд	56
Дүрслэл 2.13	Банкны салбарын ашигт ажиллагаа	57
Дүрслэл 2.14	Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	57
Дүрслэл 2.15	Хөрвөх чадварын үзүүлэлтүүд	57
Дүрслэл 2.16	Даатгалын хураамжийн орлого	59
Дүрслэл 2.17	Бүртгэлтэй банк бус санхүүгийн байгууллагын тоо	61
Дүрслэл 2.18	Банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн бүтэц	62
Дүрслэл 2.19	Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн чанар	62
Дүрслэл 2.20	Банк ба ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү	63
Дүрслэл 2.21	Байгуулбал зохих болон байгуулсан эрсдэлийн сан /хувиар/	64
Дүрслэл 2.22	Z индекс ба өгөөжийн стандарт хазайлт	64

Дүрслэл 2.23	Хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдийн тоо	65
Дүрслэл 2.24	Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар	65
Дүрслэл 2.25	Хадгаламж, зээлийн хоршоодын өр төлбөр ба өөрийн хөрөнгө	65
Дүрслэл 2.26	Нийт хөрөнгө болон зээлийн эрсдэлд орох үзүүлэлт	66
Дүрслэл 2.27	Хөрвөх чадварын харьцаа	66
Дүрслэл 2.28	ТОП-20 индекс болон зах зээлийн үнэлгээ	67
Дүрслэл 2.29	Хөрвөх чадвар, хувьцааны арилжааны үнийн дүн	67
Дүрслэл 2.30	Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт	68
Дүрслэл 2.31	Арилжааны төлбөр тооцоо	69
Дүрслэл 2.32	Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч	71
Дүрслэл 2.33	Батлан даалт гаргасан байдал болон санхүүжилтийн эх үүсвэр	73
Дүрслэл 3.1	Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт	78
Дүрслэл 3.2	Бага дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт	78
Дүрслэл 3.3	Картын гүйлгээний нэг өдрийн дундаж үзүүлэлт	79

ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт 1.1	Төсвийн орлогын гүйцэтгэл	17
Хүснэгт 1.2	Урсгал тэнцлийн алдагдлын санхүүжилт	20
Хүснэгт 1.3	Монгол Улсын нийт гадаад өр	23
Хүснэгт 1.4	Монгол Улсын зээлжих зэрэглэлийн өөрчлөлт	25
Хүснэгт 1.5	Улс орнууд дахь хөрөнгийн урсгалын хязгаарлалт	28
Хүснэгт 1.6	Бодит ДНБ-ий өсөлт (салбаруудаар)	30
Хүснэгт 1.7	Иргэдийн өр, орлогын харьцаа	34
Хүснэгт 1.8	Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба урьдчилсан гүйцэтгэл	47
Хүснэгт 1.9	Нэгдсэн төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэл	47
Хүснэгт 1.10	Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл	48
Хүснэгт 1.11	Засгийн газрын өр (тэрбум төгрөг)	49
Хүснэгт 1.12	Гадаад зээлийн өрийн үлдэгдэл (тэрбум төгрөг)	50
Хүснэгт 2.1	Нийт харилцах, хадгаламжийн даатгагдсан байдал	59
Хүснэгт 2.2	Сангийн хөрөнгийн бүтэц (2018 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар)	60
Хүснэгт 2.3	Банк бус санхүүгийн байгууллагын голлох статистик үзүүлэлтүүд	61
Хүснэгт 2.4	Банк бус санхүүгийн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл	62
Хүснэгт 2.5	Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн голлох үзүүлэлтүүд	63
Хүснэгт 2.6	Орлого, зарлага, ашигт ажиллагаа	63
Хүснэгт 2.7	ББСБ-ын зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хангасан байдал	63
Хүснэгт 2.8	Хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик үзүүлэлтүүд	65
Хүснэгт 2.9	Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо	70
Хүснэгт 2.10	Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ	70
Хүснэгт 2.11	Даатгалын компаниудын хөрөнгө балансын зүйлээр	70
Хүснэгт 2.12	Даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөр, бүтээгдэхүүнээр	71
Хүснэгт 2.13	Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн арилжааны үнийн дүн	73

ШИГТГЭЭ

Шигтгээ 1:	Хөрөнгийн урсгалын хязгаарлалт	27
Шигтгээ 2:	Монгол Улсын өрхийн секторын микро стресс тест	37
Шигтгээ 3:	Монгол Улсын аж ахуй нэгжүүдийн бизнес хүлээлтийн түүвэр судалгаа	42

ӨМНӨХ ҮГ

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-өөс хэлэлцэж шийдвэрлэсний дагуу “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г хагас жил тутам боловсруулан олон нийтэд танилцуулдаг бөгөөд энэ удаа 12 дахь дугаарыг СТБЗ-өөс Та бүхэнд өргөн барьж байна.

2018 он гарсаар Монгол Улсын нүүрсний экспорт нэмэгдэж, түүхий эдийн үнэ өссөний зэрэгцээ ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн эерэг нөлөөгөөр хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, улмаар эдийн засгийн гүйцэтгэл сайжран сүүлийн 3 улирал дараалан бодит ДНБ-ий өсөлт 6 хувийг даваад байна.

2018 оны 10 дугаар сард ОУВС-гийн гүйцэтгэх захирлуудын зөвлөлөөс Монгол Улсад хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн 5 дахь шатны үнэлгээг дүгнэж, улмаар 26.2 сая зээлжих тусгай эрх (SDR) буюу 36.2 сая ам.долларын санхүүжилтийг Монгол Улсад олгохоор шийдвэрлэсэн. Ингэснээр хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс ОУВС-гаас хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш нийт 157.2 сая зээлжих тусгай эрх буюу 217.3 сая ам.долларын санхүүжилтийг хүлээн авч, энэ хэмжээгээр гадаад валютын орох урсгал нэмэгдэж, албан нөөцийг өсгөх боломж бүрдэж байна. Түүнчлэн хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой банкны салбарын активын чанарын үнэлгээ (АЧҮ)-г олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу гадаадын хөндлөнгийн аудитын компаниар амжилттай гүйцэтгүүлсэн. Үнэлгээний үр дүнд банкны салбарын нийт өөрийн хөрөнгийн дутагдал 2017 оны эцсийн байдлаар ДНБ-ий 1.9 хувьтай тэнцүү гарсан

бөгөөд Монголбанкнаас 9 сарын дотор (2018 оны 12 дугаар сард багтаан) өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх үүргийг арилжааны банкнуудад өгөөд байна. Цаашид ОУВС-гийн хөтөлбөрт туссан зорилт, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэх, төсвийн болон мөнгөний бодлогын харилцан уялдааг хангах, мөчлөг сөрсөн макро зохистой бодлого хэрэгжүүлэх нь Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Санхүүгийн салбар нь итгэлцэл дээр оршин тогтнох бөгөөд түүний тогтвортой байдал нь санхүүгийн зах зээлд оролцогчдын үнэн зөв мэдээлэлд үндэслэсэн бодитой хүлээлтээс ихээхэн хамааралтай байдаг. Энэ ч утгаараа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь Монгол Улсын санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд санхүү, эдийн засгийн бодлогын асуудлыг тогтмол авч хэлэлцэхийн зэрэгцээ, олон нийтэд хүргэж буй мэдээллийн чанарыг сайжруулах, санхүүгийн талаарх иргэдийн суурь мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г тогтмол боловсруулан нийтэлсээр байна. Тус тайланг боловсруулахдаа албан ёсны эх сурвалж, статистикт үндэслэсэн нийт макро эдийн засаг, санхүүгийн салбарын нөхцөл байдал, хандлагын талаар харилцан уялдаа бүхий мэдээлэл өгөх зарчмыг баримталж байна.

Энэхүү тайлангийн агуулгыг цаашид сайжруулахад уншигч таны оролцоо, хувь нэмэр ихээхэн чухал тул энэхүү тайлантай холбогдох аливаа саналаа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын албанд хаяглан, fsc@mongolbank.mn цахим шуудангаар ирүүлэхийг хүсье. Таны саналыг хүлээж авахдаа бид үргэлж таатай байх болно.

ТОЙМ

Хөгжиж буй орнуудын эдийн засгийн идэвхжил 2018 оны эхний хагаст 2017 онтой харьцуулахад саарсан, түүнчлэн улс хоорондын гадаад худалдааны бодлогын асуудал болон аж үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт буурсан зэргээс шалтгаалан ОУВС-гийн шинжээчид дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх төсөөллөөс 0.2 нэгж хувиар бууруулж, 2018 болон 2019 онд 3.7 хувиар өснө гэж үзжээ.

Хятадын жижиглэн худалдаа болон нийт хөрөнгө оруулалт нэмэгдэж, тайлант хугацаанд эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол Евро бүсийн дотоод эрэлт мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогын нөлөөгөөр өсч, хөдөлмөрийн зах сайжирч, өрхийн хэрэглээ нэмэгдэж бүсийн өсөлтийг дэмжлээ.

АНУ-ын эдийн засаг 2018 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 хувиар өссөн бол 2018 оны 3 дугаар улиралд хүлээлтээс өндөр гарч, 3.0 хувь буюу өмнөх улирлын өсөлтөөс 0.2 нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байлаа. АНУ-ын Холбооны Нөөцийн Банк (ХНБ) 2018 оны 1, 2 болон 3 дугаар улиралд бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар тус тус нэмэгдүүлж 2-2.25 хувьд хүргэв.

2017 оны сүүлч болон 2018 оны эхэн үед дэлхийн голлох хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байсан бол 2018 оны 2 дугаар улиралд индексүүд огцом буурч, харин 4 дүгээр улиралд эргээд өссөн дүр зураг ажиглагдлаа. Хөрөнгийн захын индексүүд 2018 оны 2-3 дугаар улиралд огцом буурахад АНУ болон БНХАУ-ын хооронд үүссэн худалдааны дайн (импортын татвар, тарифын өсөлт) болон ХНБ-наас бодлогын хүүгээ шат дараалуулан өсгөсний нөлөөгөөр томоохон компаниудын үйл ажиллагааны болон

санхүүгийн зардал нэмэгдэж, эдгээрийн ашигт ажиллагаа буурсан нь нөлөөлжээ.

Дэлхийн томоохон эдийн засагтай орнуудын төв банкууд 2018 онд мөнгөний бодлогын төлөвөө харилцан адилгүй өөрчилсөн байна.

АНУ-ын бодлогын хүүний өсөлт нь хөрөнгийн урсгалыг АНУ-руу чиглүүлж, улс орнуудын хөрөнгийн гарах урсгал нэмэгдсэнээр ам.долларын ханш голлох валютуудын эсрэг чангарсан байна.

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2018 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 51.2 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 334.4 сая ам.доллараар өсчээ.

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн данс 2018 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 1275.9 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 717.4 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Санхүүгийн данс 2018 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 1396.4 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 289.8 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

2018 оны 3 дугаар улиралд бодит секторын идэвхжил нэмэгдэж, улирлын бодит ДНБ өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өслөө.

М2 мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2016 оны 1 дүгээр улирлаас эхлэн эерэг дүнтэй болж өссөөр 2018 оны 10 дугаар сарын байдлаар 26.3 хувь байна. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 20.6 нэгж хувийг бусад хадгаламжийн өсөлт, 4.5 нэгж хувийг М1 мөнгөний өсөлт бүрдүүлж байна.

2018 оны 10 дугаар сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Монгол Улсын

нэгдсэн төсвийн нийт орлого 8268.1 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн хэмжээнээс 25.0 хувь буюу 1656.0 тэрбум төгрөгөөр өссөн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 7519.5 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн хэмжээнээс 23.5 хувиар буюу 1431.8 тэрбум төгрөгөөр давж биелжээ. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого төлөвлөгөөнөөс ийнхүү давахад ААН-ийн орлогын албан татвар 556.3 тэрбум төгрөг, НӨАТ 528.1 тэрбум төгрөг, импортын гаалийн албан татвар 103.2 тэрбум төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 100.6 тэрбум төгрөгөөр тус тус давсан нь голлон нөлөөллөө.

Банкны салбарт 2018 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар 14 банк 1509 салбар нэгж, 15925 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо давхардсан тоогоор 8.9 сая, зээлдэгчдийн тоо 1.2 саяд хүрлээ.

2018 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ 2.1

их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.1 дахин, өмнөх улирлаас 85.4 хувиар өслөө. Банкны салбарын зээлийн чанар муудсантай холбоотойгоор өөрийн хөрөнгийн хэмжээ буурч, эрсдэл даах чадварыг харуулдаг өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүд буурч байна.

2018 оны 3 дугаар улирлын байдлаар 540 Банк бус санхүүгийн байгууллага, 288 Хадгаламж зээлийн хоршоо, 18 Даатгалын компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа хэдий ч банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын санхүүгийн салбарт эзлэх хувь бага хэвээр байгаа юм.

Санхүүгийн салбарын үндсэн дэд бүтэц болох төлбөр тооцооны системийн хэвийн үйл ажиллагаа хангагдаж байгаа бөгөөд төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт жил бүр өсөн нэмэгдэж байна.

МАКРО-САНХҮҮГИЙН ОРЧИН


1.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

Хөгжиж буй орнуудын эдийн засгийн идэвхжил 2018 оны эхний хагаст 2017 онтой харьцуулахад саарсан, түүнчлэн улс хоорондын гадаад худалдааны бодлогын асуудал болон аж үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт буурсан зэргээс шалтгаалан ОУВС-гийн шинжээчид дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх төсөөллөөс 0.2 нэгж хувиар бууруулж, 2018 болон 2019 онд 3.7 хувиар өснө гэж үзжээ. Хятадын жижиглэн худалдаа болон нийт хөрөнгө оруулалт нэмэгдэж, тайлант хугацаанд эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол Евро бүсийн дотоод эрэлт мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогын нөлөөгөөр өсч, хөдөлмөрийн зах сайжирч, өрхийн хэрэглээ нэмэгдэж бүсийн өсөлтийг дэмжлээ.

Дүрслэл 1.1

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл, "Дэлхийн эдийн засгийн хандлага (World economic outlook update)" тайлан, 2018 оны 10 дугаар сар

АНУ-ын эдийн засаг 2018 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад


2.8 хувиар өссөн бол 2018 оны 3 дугаар улиралд хүлээлтээс өндөр гарч, 3.0 хувь буюу өмнөх улирлын өсөлтөөс 0.2 нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байлаа. Харин 2018 оны 3 дугаар улиралд Засгийн газрын хэрэглээний зардлын өсөлт 2.4 хувь, дотоод эрэлтийн өсөлт 3.3 хувь, хувийн хэрэглээний өсөлт 3.0 хувь /өмнөх улирлын өсөлттэй харьцуулахад харгалзан 1.1 нэгж хувь, 0.6 нэгж хувь, 0.4 нэгж хувиар өндөр/ байсан нь эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөв. Үүний зэрэгцээ хөдөлмөрийн зах идэвхжиж, ажилгүйдлийн түвшин 3.7 хувьд хүрч, хувийн салбар дахь хөрөнгө оруулалт өмнөх улирлын түвшинтэй харьцуулахад 12.3 хувиар өссөн нь 2018 оны 3 дугаар улирлын өсөлтийг голлон тайлбарлаж байна. Харин экспорт 2018 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.7 хувиар өсч байсан бол 3 дугаар улиралд 3.9 хувь болж, импорт 2 дугаар улиралд 4.2 хувь байсан бол 3 дугаар улиралд 5.7 хувь болж, тогтмол хөрөнгө оруулалт өмнөх улиралд 5.8 хувь байсан бол 5.0 хувь болж тус тус буурсан байна.

АНУ-ын Холбооны Нөөцийн Банк (ХНБ) 2018 оны 1, 2 болон 3 дугаар улиралд бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар тус тус нэмэгдүүлж 2.25 хувьд хүргэв. Энэ оны 11 дүгээр сарын байдлаар тус улсад 155 мянган ажлын байр нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин 3.7 хувь, хөдөлмөрийн оролцооны түвшин 63 хувьд хүрсэн, хувийн хэрэглээ тогтворжсон, инфляци нэмэгдэх төлөвтэй байгаа зэрэг нь ХНБ бодлогын хүүгээ нэмэх шалтгаан болсон.

Цаашид АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын татварын шинэчлэлийн хүрээнд хувийн болон өрхийн хэрэглээ нэмэгдэж, энэ нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, инфляци дунд хугацаанд зорилтот түвшин буюу 2 хувь руу ойртохоор хүлээгдэж байгаа тул Холбооны Нөөцийн банк 2018 оны 12 дугаар сарын хурлаараа бодлогын хүүг нэмэгдүүлэх, цаашлаад 2019 онд гурван ч удаа нэмэгдүүлэх магадлал өндөр байна.

Дүрслэл 1.2

АНУ-ын эдийн засгийн зарим гол үзүүлэлтүүд



Эх сурвалж: Блүмберг

Евро бүсийн эдийн засаг 2018 оны 2 дугаар улиралд 2.2 хувиар өсч байсан бол 3 дугаар улиралд 1.7 хувиар өссөн нь хүлээлтээс доогуур өсөлт байв. Хөдөлмөрийн зах зээл сэргэж, өрхийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар өсч, энэ нь Евро бүсийн эдийн засгийн өсөлтийг дэмжсэн байна. Европын Төв банкны мөнгөний уламжлалт бус тэлэх бодлого нь дотоод эрэлтийг дэмжихийн зэрэгцээ еврогийн ханш харьцангуй сул байгаа нь бүсийн эдийн засгийн өсөлтөд голлон нөлөөлж байна. Гэвч БНХАУ, АНУ хоорондын худалдааны зөрчилдөөн, хөгжиж буй орнуудын өсөлт удааших төлөв, газрын тосны үнийн өсөлт зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр тайлант хугацаанд бодит цалин, худалдааны эргэлт нэмэгдээгүй тул Евро бүсийн хувийн хэрэглээ өмнөх улирлын


түвшнээс буурч, өсөлт нь удааширсан гэж “Bloomberg” агентлагийн шинжээчид онцолж байна. Бүс нутгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин тайлант хугацаанд 8.1 хувьд хүрч буурсан хэдий ч худалдан авагч менежерийн индекс (PMI) 51.8 буюу 2016 оны 8 дугаар сараас хойших хамгийн доод түвшинд хүрчээ. Жижиг эдийн засгуудын хувьд ажилгүйдлийн түвшин өндөр, улсын өрийн дарамт их, төсвийн хатуу бодлогын нөлөөгөөр цалин хөлс төдийлөн нэмэгдээгүй байна. Цаашид өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлс хадгалагдахааргүй байгаа тул тус бүсийн 2018-2020 оны өсөлтийн төсөөллийг олон улсын шинжээчид бууруулаад байна.

Евро бүсийн нийт ДНБ-ий 29 хувийг эзэлдэг Герман улсын эдийн засгийн өсөлт энэ оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар буурсан нь 2015 оны 1 дүгээр улирлаас хойших хамгийн доод үзүүлэлт байв. Тус улсын үйлдвэрлэлийн салбар, ялангуяа автомашины үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 24 хувиар, шинэ машины бүртгэл 31 хувиар буурсан нь тус улсын эдийн засгийн өсөлт удаашихад голлон нөлөөлөв. Түүнчлэн Евро бүсийн ДНБ-ий 16 хувийг эзлэх Италийн эдийн засгийн өсөлт өмнөх улирлын өсөлтөөс буурсан бол тус бүсийн үйлдвэрлэлийн 21 хувийг эзэлдэг Францын эдийн засгийн өсөлт бага зэрэг нэмэгджээ. Харин ДНБ-ий 11 хувийг эзлэх Испани улсын эдийн засгийн өсөлт хэвээр байлаа.

Харин инфляци Европын Төв банкны уламжлалт бус мөнгөний бодлого болон газрын тосны өндөр үнээс голлон хамаарч 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 2.1 хувьд хүрч өмнөх улирлаас 0.4 нэгж хувиар нэмэгджээ. Өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс 2018 оныг дуустал хадгалагдах төлөвгүй байгаа тул инфляци Европын төв банкны тэлэх бодлогоос үл хамааран зорилтот түвшин (2%)-д хүрэхээргүй байна.

Дүрслэл 1.3

Евро бүсийн ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: Блүмберг

Хятадын эдийн засаг 2018 оны 2 дугаар улиралд 6.7 хувиар өссөн бол 3 дугаар улиралд хүлээлтийн орчимд буюу 6.5 хувиар өсөв. Жижиглэн худалдаа өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар, нийт хөрөнгө оруулалт 5.4 хувиар өссөн нь эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлжээ. Статистик мэдээгээр аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлт энэ оны 1 дүгээр улиралд 6.6 хувь байсан бол дараах улиралд 6 хувь, эрчим хүчний үйлдвэрлэл өмнөх улиралд 7.9 хувиар өсч байсан бол тайлант хугацаанд 6.2 хувь болж тус тус буурчээ. Харин хувийн хэрэглээ 2018 оны 3 дугаар улирлын өсөлтөд нийт ДНБ-ий 80 орчим хувийг эзэлж, эдийн засгийн өсөлтөд түлхэц боллоо. Түүнчлэн аж үйлдвэрийн салбарын идэвхжлийг илтгэх Caixin PMI индекс 2018 оны 11 дүгээр сарын байдлаар 51.9-т хүрсэн нь хэрэглэгчид, бизнес эрхлэгчдийн итгэл нэмэгдсэнийг илэрхийлж байна. Улс хоорондын худалдааны зөрчилдөөн болон дотоод эрэлт саарах хандлагаас шалтгаалан Хятадын Ардын Банк, Хятадын Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор 2019-2020 онуудад төсөв, мөнгөний сул бодлого явуулах төлөвтэй байна. Цаашид зээлийн өсөлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилгоор Хятадын Ардын Банк

банкнуудад тавих заавал байлгах нөөцийн хувь хэмжээг энэ онд 4 удаа буурууллаа.

АНУ-ын Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүгээ 2018 онд дахин нэг удаа нэмэгдүүлэх хүлээлт, хоёр улсын хоорондын худалдааны маргаан, Ерөнхийлөгч Дональд Трампын татвар бууруулах бодлогын шинэчлэлттэй холбоотойгоор юанийн ханш ам.долларын эсрэг 2018-2019 онуудад сулрах хандлагатай байна.


Хятадын эдийн засгийн байдал нь өр болон санхүүгийн тэнцлийн алдагдлаас ихээхэн хамааралтай хэвээр байна. Тус улсын хувийн салбарын өрийн хэмжээ 2017 оны эцэст ДНБ-ий 219 орчим хувьд хүрсэн нь тус улсын эдийн засаг дахь эрсдэл нэмэгдсээр байгааг илтгэж байна. ОУВС болон “EIU” агентлагийн шинжээчдийн тооцоолсноор Хятадын өрх, компани болон Засгийн газрын зээл 2022 он гэхэд ДНБ-ий 260-320 хувьд хүрч нэмэгдэхээр байгаа тул өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагатайг анхааруулсаар байна. Энэ нь тус улсын дунд хугацааны эдийн засгийн төлөвийг бууруулахад голлон нөлөөлж байна.

Австралийн сайн чанарын коксжих нүүрсний гэрээний жишиг үнэ 2018 оны эхний хагаст 173 ам.доллар/тн-д хүрч буураад байсан бол 2018 оны 10 дугаар сарын эцэст 215 ам.доллар/тн орчимд арилжаалагдаж, оны эхний түвшинд хүрч өссөн байна. БНХАУ-ын зүгээс тус улсын 2018 оны нүүрсний импортын төлөвлөгөөт хэмжээ бүрэн хангагдсан гэж үзэж, улмаар нүүрсний импортын хэмжээгээ бууруулах арга хэмжээг авч эхлүүлээд байна.

2018 оны 10 дугаар сард Монгол улс нийт 6.1 тонн коксжих нүүрсийг БНХАУ-д экспортолсон нь тус улсын нийт коксжих нүүрсний импортын 51 хувийг бүрдүүлж байна.

Дүрслэл 1.4

БНХАУ-ын нүүрсний импорт (сая тонн)



Эх сурвалж: Блүмберг.

Нэг унц алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2018 оны эхэнд 1317 ам.доллар байсан бол энэ оны 10 дугаар сарын эцэст 1214 ам.долларт хүрч оны эхнээс 7.8 хувиар буурав. Цаашид ХНБ 12 дугаар сард бодлогын хүүгээ нэмэгдүүлнэ гэсэн зах зээлд оролцогчдын хүлээлт болон гадаад худалдааны тогтворгүй байдлын асуудлаас шалтгаалан алтны ханш 2018 оныг дуустал буурах хүлээлттэй байна.

2018 оны эхэнд 67 ам.долларын түвшинд нээгдсэн нэг баррель Брент төрлийн газрын

ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ


2017 оны сүүлч болон 2018 оны эхэн үед дэлхийн голлох хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байсан бол 2018 оны 2 дугаар улиралд индексүүд огцом буурч, харин 4 дүгээр улиралд эргээд өссөн дүр зураг ажиглагдлаа.

Хөрөнгийн захын индексүүд 2018 оны 2-3 дугаар улиралд огцом буурахад АНУ болон БНХАУ-ын хооронд үүссэн худалдааны дайн (импортын татвар, тарифын өсөлт) болон ХНБ-наас бодлогын хүүгээ шат дараалуулан өсгөсний нөлөөгөөр томоохон компаниудын үйл ажиллагааны болон санхүүгийн зардал нэмэгдэж, эдгээрийн ашигт ажиллагаа буурсан нь нөлөөлжээ.

тосны үнэ 10 дугаар сарын эцэст 75 ам.долларт хүрч оны эхнээс 14 хувиар өсөөд байна.

Дүрслэл 1.5

Зарим түүхий эдийн үнэ




Эх сурвалж: Блүмберг.

Саудын Араб болон ОХУ-ын газрын тосны нийлүүлэлт нэмэгдсэнээр ОПЕК-ийн гишүүн орнуудын газрын тосны гарц 9 дүгээр сарын байдлаар 32.8 сая баррель болж өссөн хэдий ч АНУ-ын Иран улсын эсрэг авч буй хориг арга хэмжээнээс үүдэн газрын тосны зах зээлд тодорхой бус байдал бий болсон юм.

Дүрслэл 1.6

Зарим хөрөнгийн захын индекс



Эх сурвалж: Блүмберг

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн статистик болно.


Харин ХНБ нь 2018 оны 12 дугаар сард бодлогын хүүгээ өсгөх эсэх шийдвэртээ

ажилгүйдлийн түвшин, инфляци, төсвийн тэлэлт, хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлыг харгалзаж үзэх талаар ХНБ-ны Ерөнхийлөгч Жером Повел 11 дүгээр сард мэдэгдэл хийсний дараа хөрөнгө оруулагчдын хүлээлт өөрчлөгдөж, улмаар хөрөнгийн зах зээлийн индексүүд аажмаар өсч эхэлсэн байна.

2018 оны эхнээс MSCI World индекс 1.6 хувиар, MSCI Emerging market индекс 12.2 хувиар, MSCI Europe индекс 7.6 хувиар, Hang Seng индекс 11.1 хувиар, Nikkei 225 индекс 1.6 хувиар тус тус буурсан бол S&P 500 индекс 3.5 хувиар өсчээ.

Дүрслэл 1.7

Хөгжингүй улс орнуудын бодлогын хүү



Эх сурвалж: Блүүмберг


Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн статистик болно.

Дэлхийн томоохон эдийн засагтай орнуудын төв банкууд 2018 онд мөнгөний бодлогын төлөвөө харилцан адилгүй өөрчилсөн байна. Тухайлбал, ХНБ 2015 оноос хойш бодлогын хүүгээ нийт 8 удаа, 2018 он гарсаар 3 удаа (2018 оны 3, 6 болон 9 дүгээр сард) тус бүр 0.25 нэгж хувиар өсгөж 2.25 хувьд хүргээд байна. Шинжээчдийн үзэж байгаагаар ХНБ ирэх жилүүдэд ч мөнгөний хатуу бодлого баримтлах төлөвтэй байгаа бол Европын төв банк, Японы төв банк бодлогын хүүгээ урт хугацаанд бага түвшинд хадгалах хүлээлттэй байгаа юм.

2018 онд Англи, Герман, Япон зэрэг улсуудын Засгийн газрын бондын өгөөж бага зэрэг өссөн хэдий ч, харьцангуй тогтвортой байлаа. Харин Итали улсын 2019 оны төсвийг Европын холбооны удирдамжид нийцээгүй, хэт тэлсэн зэрэг шалтгааны улмаас Европын холбоо дэмжээгүйгээс үүдэлтэйгээр тодорхойгүй байдал үүсч, улмаар тус улсын Засгийн газрын бондын өгөөж өсч 3.58 хувьд хүрсэн юм. Харин тус улсад өрнөсөн Европын холбооны эсрэг хөдөлгөөнүүдийг аажмаар намжаасны зэрэгцээ Европын холбоо тус улсын төсвийн тэлэлтийг тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрснөөр эдийн засгийн байдал нь тогтворжиж, улмаар ЗГ-ын бондын хүү эргээд аажмаар буурч эхэлсэн байна.

Дүрслэл 1.8

Зарим хөгжингүй орнуудын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж



Эх сурвалж: Блүүмберг

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн статистик болно.


АНУ-ын Засгийн газрын төсвийн тэлэлт, ХНБ-наас хэрэгжүүлж эхэлсэн мөнгөний хумих бодлогын нөлөөгөөр АНУ-ын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж 3.2 хувьд хүрч өссөн боловч, 11 сард аажмаар буурч 2.9 хувьд хүрээд байна.

АНУ-ын бодлогын хүүний өсөлт нь хөрөнгийн урсгалыг АНУ-руу чиглүүлж, улс орнуудын хөрөнгийн гарах урсгал нэмэгдсэнээр ам.долларын ханш голлох

валютуудын эсрэг чангарсан байна. Тухайлбал, 2018 оны эхнээс ам.долларын ханш еврогийн эсрэг 5.4 хувиар, Английн фунт стерлингийн эсрэг 6.0 хувиар, Швейцарь франкийн эсрэг 2.2 хувиар, БНХАУ-ын юанийн эсрэг 5.2 хувиар, ОХУ-ын рублийн эсрэг 15.0 хувиар, Туркийн лирийн эсрэг 38.0 хувиар тус тус чангарчээ.

Дүрслэл 1.9

Голлох валютуудын ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: Блүүмберг

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаарх статистик болно.

Дэлхийн санхүүгийн зах зээлийн орчны нөлөөгөөр Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдалд дараах эрсдэлүүд учирч болзошгүй байна. Үүнд:

- ◆ ХНБ-ны бодлогын хүүний өсөлтийг дагаж улс орнуудын ЗГ-ын үнэт цаасны хүү, бусад үнэт цаасны хүү, санхүүжилтийн хүү өссөнөөр Монгол улсын санхүүжилтийн зардал нэмэгдэх;
- ◆ Худалдааны дайн (татвар, тарифын өсөлт) нь томоохон компаниудын үйл ажиллагааны зардлыг өсгөж, улмаар бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг нэмэгдүүлэх сөрөг нөлөөтэй байна. Ялангуяа татварын нэмэгдлийн нөлөөгөөр БНХАУ-ын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөх

хандлагатай байгаа ба үнэ өссөнөөр эрэлт багасч, үйлдвэрлэл буурч, улмаар төлбөрийн тэнцэл, худалдааны тэнцэл, хөдөлмөрийн зах зээлээр дамжин санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй юм.

1.2 МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ


МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Гадаад секторын төлөвийг илэрхийлэгч гол үзүүлэлт болох төлбөрийн тэнцэл нь 2013 оноос хойш 4 жил алдагдалтай байсан бол урсгал дансны алдагдал буурч, хөрөнгө санхүүгийн тэнцлийн ашиг нэмэгдсэнээр 2017 оны эцэст 1460 сая ам.долларын ашигтай гарсан. Харин 2018 оны 10 сарын урьдчилсан гүйцэтгэлээр санхүүгийн данс ашигтай гарсан хэдий ч урсгал тэнцлийн алдагдал өсч, төлбөрийн тэнцэл 51.2 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

Гаалийн статистик мэдээгээр гадаад худалдааны тэнцэл 2018 оны эхний 10 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 589 сая ам.доллараар буурч 1069 сая ам.долларын ашигтай гарсан. Үүнд экспорт 15 хувиар буюу 756 сая ам.доллараар өссөн хэдий ч, импорт 38 хувиар буюу 1345 сая ам.доллараар өсч экспортын өсөлтөөс давсан нь нөлөөлөв.

Дүрслэл 1.10

Импортын жилийн өсөлт



Эх сурвалж: Гааль, татварын ерөнхий газар.

Тэмдэглэл: Жил бүрийн эхний 10 сарын гүйцэтгэлийг ашиглав.

2018 оны эхний 10 сарын байдлаар гадаад худалдааны нийт эргэлт өмнөх оны мөн үеэс 24 хувийн өсөлттэй буюу 2101 сая ам.доллараар өсч 10820 сая ам.долларт хүрсэн нь төсвийн орлого бүрдэлт, цаашлаад эдийн засгийн идэвхжилд эерэгээр нөлөөлсөн байна.


2018 оны эхний 10 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 49 хувиар, нефтийн бүтээгдэхүүний импорт 37 хувиар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 28 хувиар тус тус өссөн байна. Эдгээрээс хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импортын өсөлт нь нийт импортын өсөлтийн 19 нэгж хувийг бүрдүүлжээ.

Нийт экспортыг голлох бүрэлдэхүүнээр авч үзвэл 2018 оны эхний 10 сард өмнөх оны мөн үеэс уул уурхайн экспорт 15 хувиар, мал аж ахуйн экспорт 25 хувиар, аж үйлдвэрлэлийн экспорт 1 хувиар тус тус өсч, харин газар тариалангийн экспорт 36 хувиар буурчээ. Эдгээрээс уул уурхайн бүтээгдэхүүний экспортын өсөлт нь нийт экспортын өсөлтийн 13 нэгж хувийг бүрдүүлж экспортын өсөлтөд голлох нөлөөг үзүүлсэн байна.

2018 оны 10 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс 26 хувиар өсч 1396 сая ам.долларт хүрлээ. Санхүүгийн дансны гол үзүүлэлтийн нэг болох гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2018 оны 10 дугаар сарын байдлаар 1444 сая ам.долларт хүрчээ.

Дүрслэл 1.11

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (цэвэр дүнгээр)



Эх сурвалж: Монголбанк.


Тэмдэглэл: Томоохон компаниудын хөрөнгө оруулагчаас авсан зээлийн эргэн төлөлт хийгдсэн тул гадаадын шууд хөрөнгө оруулалт /цэвэр дүнгээр/ 2016 онд -4170.9 тэрбум ам.долларт хүрсэн.

*-2018 оны эхний 10 сарын урьдчилсан гүйцэтгэл болно.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2015 онд 2.4 хувь, 2016 онд 1.2 хувь, 2017 онд 5.1 хувийн өсөлттэй байсан бол 2018 оны эхний 3 улиралд 6.4 хувийн өсөлттэй гарлаа.

Дүрслэл 1.12

Улирлын ДНБ-ий жилийн өсөлт, 2010 оны үнээр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Уул уурхайн салбарын өсөлт эхний улиралд 0.6 хувьтай гарав. Харин уул уурхайн бус салбар мөн хугацаанд 8.1 хувиар өссөн ба үүний дотор бүтээгдэхүүний цэвэр татвар 22.9 хувь, боловсруулах үйлдвэрлэл 10.1 хувь, тээвэр ба агуулах 9.3 хувь, цахилгаан хий, уур,

агааржуулалт 9.3 хувийн тус тус өсөлттэй байв.

2018 оны 10 дугаар сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 7519,5 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 23.5 хувиар давж биеллээ.

Хүснэгт 1.1

Төсвийн орлогын гүйцэтгэл (2018 оны 10 дугаар сар, тэрбум төгрөг)


Татварын төрөл	Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	6 088	7 519	1 432	124%
Татварын орлого	5 202	6 719	1517	129%
Үүнээс:				
Хувь хүний орлогын албан татвар	656	668	11	102%
ААН-ийн орлогын албан татвар	570	1 126	556	198%
Нийгмийн даатгалын орлого	1 155	1 285	130	111%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1 228	1 756	528	143%
Татварын бус орлого	886	801	-85	90%

Эх сурвалж: Сангийн яам.

Харин төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 82.4 хувийн гүйцэтгэлтэй буюу 7177.6 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 341.9 тэрбум төгрөгийн ашигтай гарав.

Дүрслэл 1.13

Гадаад, дотоод цэвэр актив болон M2 мөнгө



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 10 дугаар сарын статистик болно.


M2 мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2018 оны 10 дугаар сарын байдлаар 26.3 хувиар өсч 18.3 их наяд төгрөгт хүрлээ. Харин M1 мөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.1 хувиар буюу 817.7 тэрбум төгрөгөөр өсч,

мөнгөний нийлүүлэлтийн 18.8 хувь буюу 3.4 их наяд төгрөгтэй тэнцэж байна.

Санхүүгийн системийн эрсдэлүүдийг цаг хугацааны (time dimension) болон системийн оролцооны (cross-sectional) гэсэн хоёр хэсэгт ангилж үздэг. Цаг хугацааны санхүүгийн эрсдэлүүд нь санхүүгийн мөчлөг дагаж үүсдэг бөгөөд санхүүгийн мөчлөгийг таньж мэдэх нь санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, макро зохистой бодлого хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг.

Дүрслэл 1.14

Монгол Улсын санхүүгийн мөчлөг



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 3 дугаар улирлын статистик болно.

2013 оны 4 дүгээр улирлаас хойш уналтын төлөвт шилжээд байсан Монгол Улсын санхүүгийн мөчлөг¹ 2016 оны 2 дугаар улирлаас сэргэж эхэлсэн бөгөөд энэ хандлага үргэлжилсэн хэвээр байна. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүгийн мөчлөг 2.4 хувь, зээл ба ДНБ-ий харьцааны урт хугацааны трендээсээ зөрөх зөрүү 3.7 хувь

¹ Монгол Улсын санхүүгийн мөчлөгийг зээл ба ДНБ-ий харьцааны зөрүү (gap), бодит зээлийн мөчлөг, орон сууцны үнийн мөчлөг зэрэг үзүүлэлтүүдийг нэгтгэж тооцсон болно. Санхүүгийн мөчлөгийн талаар дэлгэрүүлэн Санхүүгийн тогтвортой байдлын тайлан №6-н 27 дугаар хуудаснаас танилцах боломжтой.


² Олон улсад санхүүгийн системийн цаг хугацааны эрсдэлийг бууруулах зорилгоор ашигладаг макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийн нэг нь мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн шаардлага юм. ОУТБ (BIS)-наас санал болгосон аргачлалын дагуу зээл, ДНБ-ий

байгаа нь санхүүгийн салбарт цаг хугацааны эрсдэл нэмэгдэх хандлагатай байгааг илтгэж байна².

2018 оны 10 дугаар сард улсын хэрэглээний үнийн индекс жилийн 6.3 хувиар, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс жилийн 6.8 хувиар тус тус өссөн байна. Дээрх хугацаанд Улаанбаатар хотын жилийн инфляцийг бүтцээр нь задлан авч үзвэл 0.9 нэгж хувийг мах, 0.5 нэгж хувийг махнаас бусад хүнсний бараа, 0.2 нэгж хувийг хувцас, бөс бараа, 2.6 нэгж хувийг орон сууц, ус, түлшний үнийн өөрчлөлт тайлбарласан бол үлдсэн 2.6 нэгж хувийг бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт бий болгожээ.

Дүрслэл 1.15

Инфляцийн задаргаа (УБ хот)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 10 дугаар сарын статистик болно.

зөрүү нь тогтоосон доод хилийн (lower threshold) утгаас бага байх үед мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлага тэгтэй тэнцүү байна. Харин дээрх зөрүү доод хилийн утгаас давах үед өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлага дагаад өсөх ба дээд хилийн утга (upper threshold) хүртэл өсч болно. Дээд, доод хилийн утга нь улс орнуудын онцлогоос шалтгаалан харилцан адилгүй байх боломжтой ч ОУТБ-наас банкны хямралын түүхэн өгөгдөлд үндэслэн судалж, доод хилийн утгыг 2 хувь, дээд хилийн утгыг 10 хувиар авахыг санал болгосон байдаг.

Нийт төлбөрийн тэнцэл

Дүрслэл 1.16


Figure 1 is a combined bar and line chart showing the quarterly percentage change in the total population and the population of the capital city of Mongolia from 2013 to 2019. The Y-axis represents the percentage change, ranging from -2500 to 1500. The X-axis shows the quarters from I 2013 to IV 2019. The red bars represent the total population change, and the black line with circles represents the capital city population change. The total population change is generally negative, with a significant drop in IV 2017. The capital city population change is generally positive, with a significant peak in IV 2017.

Quarter	Урсгал ба хөрөнгийн дансыг тэнцэл (%)	Санхүүгийн дансыг тэнцэл (%)
I 2013	-1000	-100
II 2013	-1200	-100
III 2013	-1000	-100
IV 2013	-1200	-100
I 2014	-1000	-100
II 2014	-1000	-100
III 2014	-1000	-100
IV 2014	-1000	-100
I 2015	-1000	-100
II 2015	-1000	-100
III 2015	-1000	-100
IV 2015	-1000	-100
I 2016	-1000	-100
II 2016	-1000	-100
III 2016	-1000	-100
IV 2016	-1000	-100
I 2017	-1000	-100
II 2017	-1000	-100
III 2017	-1000	-100
IV 2017	-2000	1200
I 2018	-1000	-100
II 2018	-1000	-100
III 2018	-1000	-100
IV 2018	-1000	-100
I 2019	-1000	-100
II 2019	-1000	-100
III 2019	-1000	-100
IV 2019	-1000	-100

Урсгал ба хөрөнгийн данс

Ийнхүү урсгал ба хөрөнгийн тэнцлийн алдагдал өсөхөд барааны худалдааны ашиг 708.8 сая ам.доллараар буурч 636.9 сая ам.долларт, үйлчилгээний худалдааны дансны алдагдал 209.0 сая ам.доллараар өсч 1110.9 сая ам.долларт түс түс хүрсэн нь голлон нөлөөлөв.


Урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл



Эх сурвалж: Монголбанк.

Урсгал дансны алдагдал өндөр хэвээр байна. Урсгал тэнцлийн алдагдал сүүлийн жилүүдэд нэмэгдэж, 2018 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 1.35 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан нь өмнөх оны мөн үеэс 2.2 дахин өссөн үзүүлэлт юм. Түүнчлэн урсгал тэнцлийн алдагдлыг ДНБ-ий хэмжээнд харьцуулбал 2017 оны 3 дугаар улиралд 6.9 хувьтай тэнцэж байсан бол 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 12.2 хувь болж эрс өссөн байна. Хэдийгээр 2014 оноос эхлэн худалдааны данс ашигтай гарч урсгал дансны алдагдлыг бууруулах хүчин зүйл болж байгаа хэдий ч нийт тэнцэл алдагдалтай хэвээр байна. Үүнд экспортын бүтээгдэхүүний 90 орчим хувийг бүрдүүлж буй уул уурхайн түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзлээс хамаарч экспортын орлого тогтвортой өсөх боломж бүрдээгүй, импортын бүтээгдэхүүн эдийн засгийн идэвхжлээс хамаарч байгаа нь голлон нөлөөлж байна. Энэхүү алдагдал одоогийн байдлаар ДНБ-ий 10 орчим хувьтай тэнцэж байгаагаас үзэхэд тогтворгүй байдалд орох эрсдэл хуримтлагдаж буйг илтгэж байна.

Урсгал тэнцлийн санхүүжилт



Урсгал дансны алдагдлыг 2013-2016 онд гадаад зээл³ болон гадаад валютын нөөцийн эх үүсвэрээр голлон санхүүжүүлж байсан бол 2017-2018 оны гүйцэтгэлээр шууд хөрөнгө оруулалтын орох урсгал тус алдагдлыг нөхсөн байна. Гэсэн хэдий ч энэхүү урсгал тогтвортой биш байна. Манай улс төрийн орчин тогтворгүй, асуудал ихтэй байгаа өнөө үед гадаад хөрөнгө оруулалт татрах эрсдэлтэйгээс гадна гадаад зээл, өр төлбөрүүд хугацаанаасаа өмнө татагдах тохиолдолд валютын нөөцөөр санхүүжилт хийх шаардлага үүснэ.


Урсгал тэнцлийн алдагдлын санхүүжилт

*: 2018 оны эхний 10 сарын гүйцэтгэл.

Эх сурвалж: Монголбанк.

Санхүүгийн данс 2018 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр 1396.4 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 289.8 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох үрсгал нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Санхүүгийн дансны бүтэц (сая ам.доллар)⁴



2018 оны 10 дугаар сард экспортын үнийн индекс 20 хувиар, импортын үнийн индекс 4 хувиар тус тус өссөнөөр Монгол Улсын гадаад

⁴ 2016 оны 2 дугаар улирлын гүйцэтгэл дээр Оюутолгойн далд уурхайн санхүүжилттэй холбоотойгоор тухайн компанийн авсан арилжааны зээл, тус компанийн хөрөнгө оруулагчдаа төлсөн зээлийн цэвэр дүнгээр засвар хийсэн болно.

худалдааны нөхцөлийн индекс (2012 оны 12 сарын суурьтай) 1.939 нэгж болж, өнгөрсөн оны мөн үеэс 15 хувиар сайжирсан байна.

Дүрслэл 1.20

Гадаад худалдааны нөхцөлийн индекс




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 10 дугаар сарын статистик болно.

2018 оны эхний 10 сарын байдлаар экспорт өнгөрсөн оны мөн үеэс 15 хувиар өссөн бөгөөд гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмал 28 хувиар (4.5 нэгж хувь), чулуун нүүрс 41 хувиар (4.6 нэгж хувь) тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Дүрслэл 1.21

Нийт экспорт (жил бүрийн эхний 10 сарын байдлаар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.

Импорт өнгөрсөн оны мөн үеэс 38 хувиар өссөн бөгөөд гол нэрийн бүтээгдэхүүний

ангиллаар авч үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 49 хувиар (3 нэгж хувь), аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүн 34 хувиар (4 нэгж хувь), нефтийн бүтээгдэхүүн 36 хувиар (4 нэгж хувь), хэрэглээний бүтээгдэхүүн 28 хувиар (5 нэгж хувь) тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 1.22

Нийт импорт (жил бүрийн эхний 10 сарын байдлаар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.

Гадаад зах зээлийн орчин таатай бус байна.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс сүүлийн 2 жилийн хугацаанд өссөн хэдий ч өсөлтийн хурд нь саарах, эргээд буурах хандлага ойрын саруудад ажиглагдаж байна. Тодруулбал 2018 оны 3 дугаар улирлаас эхлэн зэс, алтны үнэ буурч эхэлсэн бөгөөд Хятад улс нүүрсний импортын хэмжээг хязгаарласантай холбоотойгоор эрдэс бүтээгдэхүүний экспортод тодорхойгүй байдал улам нэмэгдсээр байна. Мөн, АНУ болон БНХАУ-ын хоорондох худалдааны зөрчилдөөн, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, АНУ-ын ХНБ бодлогын хүүгээ нэмэгдүүлэх эсэх шийдвэрүүд дэлхийн зах дээрх түүхий эдийн болон гадаад худалдаанд тодорхойгүй, таагүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Дүрслэл 1.23

Гадаад худалдааны нөхцөлийн индекс, уул уурхайн түүхий эдийн бүтээгдэхүүний үнэ (2011/1=100)




Эх сурвалж: Монголбанк, ГЕГ, Bloomberg.

Гадаад валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан дундаж ханш 2018 оны 10 дугаар сард 2564.1 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар чангарсан бол гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон нэрлэсэн ханш (NEER) 2018 оны 10 дугаар сарын байдлаар 0.4 хувиар, бодит үйлчилж буй ханш (REER) 2018 оны 9 дүгээр сарын байдлаар 7.5 хувиар тус тус чангарсан байна⁵.

Дүрслэл 1.24

Гадаад валютын ханш (жилийн өөрчлөлтийн хувь)*



Эх сурвалж: Монголбанк.


Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 10 дугаар сарын статистик болно. (+) Чангаралт (-) Сулралт

Валютын ханшийн дарамт хэлбэлзэл ихтэй, цаашдын хандлага нь тодорхойгүй байна. Үндэсний валютын ханшийн өөрчлөлт нь гадаад валютын захын дарамтыг бүрэн илэрхийлж чаддаггүй тул бодлого боловсруулагчид нэг талаас үндэсний валютын ханшийн чангаралт/сулралт хандлагыг, нөгөө талаас дотоодын мөнгөний захын тэнцвэрт байдлыг харуулдаг ЕМР индексийг тооцож ашигладаг. Энэхүү индекс нь валютын зах дээрх дарамтыг нэрлэсэн ханш чангаралт/сулралт эсвэл гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх/хорогдуулах, эсвэл хүүгийн түвшнийг өсгөх/бууруулах зэргээр ямар байдлаар шингээснийг тайлбарладаг.

Манай улсын гадаад валютын захын дарамтын ЕМР индекс 2018 оны дунд үеэс эхлэн төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн сулралтаас үүдэлтэйгээр нэмэгдсэн бол сүүлийн 9, 10 дугаар саруудад ГВАН-ийн өсөлттэй холбоотойгоор буурсан. Эндээс харахад валютын ханшийн дарамт одоогийн байдлаар төдийлөн их биш байгаа хэдий ч хэлбэлзэл ихтэй, цаашдын хандлага нь тодорхойгүй байна.

Дүрслэл 1.25

Валютын захын дарамтын ЕМР индекс



Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 10 дугаар сарын статистик болно

⁵ Жигнэсэн дунджаар тооцсон нэрлэсэн болон бодит ханшийг гадаад худалдааны түнш орнуудтай хийсэн худалдааны жингээр жинлэж тооцдог болно.

Гадаад өр⁶

Гадаад өрийн дарамт өндөр хэвээр байна. Монгол Улсын нийт гадаад өр (улсын болон хувийн секторыг нийтэд нь оруулснаар) сүүлийн 7 жил тасралтгүй өсч 2018 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 6 хувиар буюу 1695 сая ам.доллараар нэмэгдэж, 27.9 тэрбум ам.долларт хүрсэн байна.

Хүснэгт 1.3

Монгол Улсын нийт гадаад өр (сая ам.доллар)

Үзүүлэлт	2015	2016	2017Q3	2018Q3	Өөрчлөлт	
					Дүн	Хувь
Нийт гадаад өр	22 718	24 625	26 216	27 911	1 695	6%
I. Засгийн газар	3 760	4 869	6 241	7 024	783	13%
II. Төвбанк*	1 960	1 791	1 914	1 996	82	4%
III. Банк	2 129	2 417	2 231	2 299	68	3%
Богино хугацаат	407	469	721	770	49	7%
Урт хугацаат	1 721	1 948	1 510	1 529	19	1%
IV. Бусад сектор	3 749	8 121	7 967	7 753	- 213	-3%
Богино хугацаат	326	394	697	529	- 168	-24%
Урт хугацаат	3 423	7 727	7 269	7 224	- 45	-1%
V. Шууд хөрөнгө оруулалт	11 121	7 426	7 864	8 840	976	12%

Эх сурвалж: Монголбанк.

Гадаад өрийн бүтцийн хувьд Төв банкны гадаад өр өнгөрсөн оны мөн үеэс 82 сая ам.доллараар, Засгийн газрын гадаад өр⁷ 783 сая ам.доллараар, хувийн хэвшлийн гадаад өр 830 сая ам.доллараар тус тус өссөн байна. Ингэснээр Засгийн газрын гадаад өр 7.0 тэрбум ам.долларт буюу ДНБ-ий 60 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

ОУВС, Дэлхийн банкны хамтарсан судалгаагаар бага орлоготой улсын хувьд «өрийн дарамтын шалгуур үзүүлэлт»-ийг тогтоосон байдаг (IMF DSF, 2017). Манай улсын хувьд дараах үзүүлэлтүүд бүгд босго утгаас өндөр байгаа нь улс төр ба институцийн


бодлогын хувьд сул гэсэн ангилалд хамаарагдахад нөлөөлж байна.

- ♦ Нийт гадаад өр/ДНБ-ий харьцаа нь тухайн улсын өрийн эргэн төлөх чадварыг нийт эдийн засгийн үйл ажиллагааны цар хүрээнд хэмждэг үзүүлэлт юм. МУ-ын нийт гадаад өр/ДНБ-ий харьцаа тайлант хугацааны эцэст 217 хувь байгаа нь өрийн дарамтын босго үзүүлэлт 50 хувиас өндөр байна.
- ♦ Нийт гадаад өр/экспорт харьцаа нь өрийн дарамтыг тухайн улсын гадаад орлогын үндсэн эх үүсвэрт нь харьцуулдаг чухал үзүүлэлт юм. МУ-ын нийт гадаад өр/экспорт харьцаа тайлант хугацааны эцэст 369 хувьд хүрч өрийн дарамтын босго үзүүлэлт 200 хувиас давсан байна.
- ♦ Нийт гадаад өр/төсвийн орлогын харьцаа нь Засгийн газрын (ялангуяа төсөвт гадаад өрийн дарамт өндөр байгаа үед) дотоодоосоо орлого бий болгох чадамжийг харуулдаг чухал үзүүлэлт юм. Тайлант хугацааны эцэст МУ-ын нийт гадаад өр/төсвийн орлогын харьцаа 827 хувь байгаа нь босго утга 300 хувиас давсан үзүүлэлт боллоо.

Дүрслэл 1.26-с харахад гадаад өрийн хэмжээ тодорхой хэмжээнд буурч байгаа хэдий ч цаашид төлөх ихээхэн хэмжээний өр төлбөртэй холбоотойгоор гадаад өрийн эрсдэл өндөр түвшинд байсаар байна.

⁶ Энэхүү гадаад өрийн статистик мэдээллийг дэлхийн улс орнуудын Төв банкны жишгээр ОУВС-гийн "Гадаад секторын статистик боловсруулах 6 дугаар аргачлал"-д үндэслэн судалгаа, шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулсан статистик болно. Монгол улсын гадаад өрийн статистик нь Засгийн газар, Төв банк, Хадгаламжийн байгууллагууд, Бусад салбарын нийт гадаад өр болон Хөрөнгө оруулагчийн зээлийн нийлбэр дүн юм. Монголбанк нь дээрх аргачлалын шаардлагын дагуу өрийн үлдэгдлийн тооцоололд зах зээлийн үнэлгээний болон аккреуль суурийн зарчмуудыг ашигладаг тул бусад байгууллагуудаас бэлтгэн гаргаж буй тоон мэдээллүүдээс зөрж болно.


⁷ Засгийн газрын баталгаа бүхий гадаад зээлийг оруулаагүй болно.

Дүрслэл 1.26**Гадаад өрийн үлдэгдэлд суурилсан үзүүлэлт**

Эх сурвалж: Монголбанк.

Гадаад валютын албан нөөц (ГВАН)

2018 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар ГВАН өмнөх оны мөн үеэс 101 хувиар буюу 1719.4 сая ам.доллараар өсч 3413.6 сая ам.долларт хүрлээ. Гадаад валютын улсын нөөцөөр импортын хэрэгцээг хангах түвшин⁸ 6.9 сард хүрсэн байна.


Дүрслэл 1.27**Гадаад валютын албан нөөц**

Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 10 дугаар сарын статистик болно.

Гадаад валютын нөөц болзошгүй эрсдэлийг даах хангалттай түвшинд хүрээгүй байна.

2014 оноос хойш ГВАН-ийн богино хугацаат өр төлбөрийг барагдуулах хүрэлцээ хангалтгүй, эрсдэлтэй түвшинд хэвээр байна.

Дүрслэл 1.28**Гадаад валютын албан нөөц/Богино хугацаат өр**

Эх сурвалж: Монголбанк.

ГВАН-ийн импортын хэрэгцээг хангах түвшин 6.9 сар байгаа хэдий ч Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжид заасан 12 сарын импортын хэрэгцээг хангах түвшинд хүрэхгүй байна.

- ♦ 2018 оны 10 дугаар сарын валютын шууд төлбөртэй импортын барааны дүнгээр авч үзвэл, 7.01 сарын импортын хэрэгцээг,
- ♦ Монгол Улсын валютын шууд төлбөртэй импортын барааны сүүлийн 12 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд, 7.75 сарын импортын төлбөр тооцооны хэрэгцээг тус тус хангахаар байна.

Эдгээр нөхцөл байдлаас харахад ГВАН болзошгүй эрсдэлийг даах хангалттай түвшинд хүрээгүй байгаа тул цаашид ГВАН-ийг улам бүр нэмэгдүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн ГВАН нэмэгдэх нь гадаад зах зээлээс дотоодын эдийн засгийг хамгаалах, дархлааг бэхжүүлэх чухал ач холбогдолтой.

⁸ ГВАН-ийг валютын төлбөртэй импортын сүүлийн 3 сарын дундаж үзүүлэлтэд харьцуулж тооцсон.

Монгол Улсын зээлжих зэрэглэл

Монгол Улсын зээлжих зэрэглэлийг олон улсын зэрэглэл тогтоогч Фитч, Стандарт энд пүүрс, Мүүдиз агентлагуудаас тогтоож байна. Манай улсын зээлжих зэрэглэл⁹ болон төлөв¹⁰ сүүлийн жилүүдэд буурч хөрөнгө оруулалтын хувьд өндөр эрсдэлтэй орны ангилалд багтаад байсан бол 2018 онд Мүүдиз, Фитч, Стандарт энд пүүрс агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг нэг шат ахиулаад байна.

Мүүдиз агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр “Caa1”-ээс “B3” болгон дээшлүүлж, төлөвийг “тогтвортой” хэвээр үнэлсэн. Түүнчлэн тус агентлаг улсын төсвийн үзүүлэлтүүд, тэдгээрийн төлөв харьцангуй сайжирсан, нийт өрийн хэмжээ буурах хандлагатай, түүхий эдийн үнийн савлагаанаас хамаарах мэдрэмж тодорхой хэмжээгээр буурах төлөвтэй байгаа бөгөөд Монгол Улсын эдийн засаг сэргэж байгаа нь зээлжих зэрэглэлийг сайжруулах хүчин зүйл болсныг онцолжээ. Мүүдиз агентлагийн үзэж байгаагаар түүхий эдийн үнэ буурсан хэдий ч макро эдийн засгийн тогтвортой байдлыг ханган, төсвийн мөчлөг дагасан эмзэг байдлыг бууруулж, төсвийн алдагдал болон өрийн дарамт эрчимтэйгээр багасч, бүтцийн өөрчлөлтийн бодлогыг үр дүнтэй, тогтвортой хэрэгжүүлж байгаа нь зээлжих зэрэглэлийг сайжруулахад чухал нөлөөтэйг онцлов. Түүнчлэн тус агентлагийн үнэлгээгээр төлөв “тогтвортой” байгаа нь Монгол Улсын эрсдэлийн хүчин зүйлс тэнцвэртэй байгааг илтгэж байна.

Хүснэгт 1.4

Монгол Улсын зээлжих зэрэглэлийн өөрчлөлт

Огноо	Moody's		Fitch		S&P	
	Үнэлгээ	Төлөв	Үнэлгээ	Төлөв	Үнэлгээ	Төлөв
2005	VII/18		B+	•		
	X/4	B1			B	•
	XI/1				B	(+)
2006	XII/29				B+	▲
	XII/26				BB-	▲
2007	XII/13		B+	(+)		
	IX/20		B+	•		
2008	VI/2		B+	(-)		
	XII/9				BB-	(-)
	XII/19					
2009	I/18		B	▼		
	VI/10	B1	(-)			
	X/30	B1	•			
	X/11		B	•		
	XI/20				BB-	•
2010	XI/23		B+	▲		
2011	XII/19				BB-	(+)
2012	X/29				BB-	•
2013	IV/16				BB-	(-)
	XII/13		B+	(-)		
2014	IV/29				B+	▼
	V/26	B1	(-)			
	VII/17	B2	▼	(-)		
	XII/11		B+	(-)		
2015	IV/29				B+	(-)
	XI/03				B	▼
	XI/04		B	▼		
	XI/24		B	•		
2016	I/14	B2	(-)	B	•	
	III/31	B2	(-)			
	IV/28				B	•
	VII/21		B	•		
	VIII/19				B-	▼
	VIII/26	B3	▼			
	XI/18	Caa1	▼			
2017	XI/21		B-	▼		
	II/15	Caa1	•			
	II/20		B-	•		
	III/30	Caa1	•			
	IV/18		B-	(+)	B-	•
2018	XI/17					
	XI/30	Caa1	•			
	I/18	B3	▲	•		
2018	IV/20				B-	•
	VII/9		B	▲		
	XI/9				B	▲

Зэрэглэлийн өөрчлөлт ▲▼

Төлөв: (+)-ээрэг, •-тогтвортой, (-)-сөрөг

Эх сурвалж: Moody's, Fitch, S&P's, Монголбанк.

Фитч агентлаг нь 2018 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээг “B-” байсныг “B” болгон дээшлүүлж, төлөвийг “тогтвортой” гэж үнэлэв. Үүнд төсвийн гүйцэтгэл, тоон үзүүлэлтүүд 2017 оны 11 дүгээр сараас хойш тогтмол сайжирсан,

⁹Тухайн улсын Засгийн газрын зээлийн чадварыг илэрхийлдэг ба худалдааны нөхцөлтэй авсан өр төлбөрөө хугацаанд нь, бүтнээр эргэн төлөх чадвартай эсэх мөн тус үүргээ биелүүлэх бэлэн байдлыг харуулдаг.

¹⁰ Зээлжих зэрэглэлийн хандлагыг илтгэх бөгөөд “ээрэг” төлөв нь зэрэглэл сайжрах боломжтойг, “сөрөг” төлөв нь зэрэглэл буурч болзошгүй эрсдэлтэйг илэрхийлнэ.

Засгийн газрын нийт өрийн хэмжээ буурах хандлагатай байгаа, уул уурхайн салбартай холбоотой хөрөнгө оруулалтууд нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлт сайжирсан, Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр нийтдээ 5.5 тэрбум ам.долларын санхүүжилтийг ОУВС болон донор орнуудаас татах нөхцөл бүрдсэн зэрэг нь голлон нөлөөлснийг онцолжээ.

Стандард энд пүүрс агентлаг хамгийн сүүлд 2018 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг “В-” байсныг “В” болгон дээшлүүлж, хэтийн төлөвийг “тогтвортой” гэж үнэлсэн. Тус агентлагийн тайланд дурдсанаар Монгол Улсад тулгамдаад байсан хөрвөх чадварын дарамт буурсан, эдийн засгийн болон төсвийн суурийг сайжруулах зорилгоор өргөн хэмжээний реформууд хийгдэж буй нь зэрэглэлийг дээшлүүлэхэд голлон нөлөөлөв.

Түүнчлэн зээлжих зэрэглэлийн төлөв “тогтвортой” байгаа нь эрсдэлийн хүчин зүйлс тэнцвэртэй байгааг онцлоод, цаашид Монгол Улс бодлогын шинэчлэл хийснээр дэлхийн зах зээл дээрх түүхийн эдийн үнийн мөчлөг дагасан мэдрэмж буурч, төсвийн чадамж, гадаад төлбөрийн чадвар сайжрах боломжтойг дурджээ.

Зээлжих зэрэглэлийн агентлагуудын хувьд Монгол Улсын эдийн засгийг богино хугацааны эрсдэл, сорилтуудтай тулгарч буй боловч ирэх жилүүдэд ОУВС-гийн хөтөлбөр үргэлжилж, уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэнээр эдийн засаг сэргэх, улсын төсөв, гадаад төлбөрийн чадвар сайжрах хүлээлттэй буюу Монгол Улсын дунд болон урт хугацааны эдийн засгийн төлөвийг эерэгээр үнэлсэн хэвээр байна.

Шигтгээ 1: Хөрөнгийн урсгалын хязгаарлалт

Хөрөнгийн хязгаарлалт (Capital control) гэдэг нь эдийн засгийн харьяаллаас хамааруулж хил дамнасан хөрөнгийн урсгалд хязгаарлалт тогтоох арга хэмжээнүүдийг хэлнэ. Үүнд татвар болон бусад хууль эрх зүйн зохицуулалтын арга хэрэгслүүд хамаарна.¹¹

Дараах үндсэн зорилгын хүрээнд улс орнууд хөрөнгийн урсгалд хязгаарлалт тавьдаг.¹² Үүнд:

- ♦ **Санхүүгийн зах зээлийн төгс бус байдлыг багасгаж, нийт эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд.** Энэ нь мэдээллийн ил тод байдал бий болж, хөрөнгийн урсгалд илүү нарийн зохицуулалт, стандарт тогтож байгаагаараа ач холбогдолтой.
- ♦ **Тогтвортой эсвэл хатуу удирдлагатай (валютын) ханшийн дэглэмтэй улс орнуудад** мөнгөний бодлогын бие даасан байдлыг алдахгүй байх, мөн мөнгөний бодлогын валютын ханшид учруулах дарамтыг багасгах зорилгоор хөрөнгийн урсгалд хязгаарлалт тавьдаг.
- ♦ **Ихээхэн хэмжээний хөрөнгийн дотогшлох урсгалтай улс орнуудад** i) үүнээс үүдсэн инфляцийн дарамттай тулгарсан, ii) валютын ханшийн эрсдэлээс үүдэн хувийн сектор, банк санхүүгийн салбарт эрсдэл, эмзэг байдал үүссэн гэсэн 2 тохиолдолд **санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор** тус хязгаарлалтыг хэрэгжүүлдэг.
- ♦ **Засгийн газрын төсвийн хямд санхүүжилтийг бий болгож, тэргүүлэх салбаруудыг дэмжих зорилгоор** мөн хөрөнгийн урсгалд хяналт, хязгаарлалт тавих туршлага байдаг.
- ♦ Бусад улс төрийн шалтгаанууд.

Хөрөнгийн урсгалын хязгаарлалтын арга хэмжээнүүд нь бүх салбарыг хамарсан, эсвэл тухайн нэг секторыг хамарсан байж болно. Түүнчлэн хязгаарлалт үйлчлэх хөрөнгийн урсгалын хувьд бүх төрлийн урсгал эсвэл тухайлсан урсгал (орох эсвэл гарах урсгал, өрийн, үнэт цаасны, ГШХО гэх мэт) байж болох бол хугацааны хувьд богино хугацаат, урт хугацаат зэргээр ялгаж хязгаарлалт тавьж болдог.

Тухайлбал улс орнууд хэт тогтворгүй богино хугацааны орох урсгалтай үед үүнд хязгаарлалт тогтоох нь түгээмэл байдаг бол хямрал тохиолдсон үед тухайн улс орноос хөрөнгө гадагшлах үзэгдлээс сэргийлэхийн тулд хөрөнгийн гадагшлах урсгалд хязгаарлалт тогтоодог. Үүний жишээ нь 2008-2009 оны хямралаар Исланд улсын эрх баригчид хөрөнгийн гадагшлах урсгалаас сэргийлэх, санхүүгийн хямралаас гарах зорилгоор i) арилжааны банкнуудад орж ирсэн гадаад валютаа зөвхөн импортын зорилгоор зарахыг зөвшөөрч, хөрөнгийн гадагшлах урсгалд зориулахыг хориглосон ба улмаар дотоодын харьяатууд хөрөнгөө гадаад улс оронд гаргах боломжгүй болсон, түүнчлэн ii) дотоодын харьяатын гадаад улс оронд оруулах багцын хөрөнгө оруулалтад хязгаарлалт тогтоох, iii) гадаадын харьяатын дотоодод үндэсний мөнгөн тэмдэгтээр санхүүгийн хэрэгсэл гаргахыг хориглох зэрэг олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

Хөрөнгийн хязгаарлалт (Capital control)-ын үндсэн 2 ангилал болох i) “administrative” буюу шууд арга хэмжээ, ii) “market based” буюу шууд бус арга хэмжээнүүдийг дэлгэрүүлѐе:¹³

¹¹ Эх сурвалж: IMF (2012). *The Liberalization and Management of Capital Flows: An Institutional View*, Washington DC: International Monetary Fund.

¹² Ariyoshi, M.A., Kirilenko, M.A., Ötoker, M.I., Laurens, M.B., Kriljenko, M.J.I.C. and Habermeier, M.K.F., 2000. *Capital controls: country experiences with their use and liberalization* (No. 190). International Monetary Fund. p.5

¹³ Ariyoshi, M.A., Kirilenko, M.A., Ötoker, M.I., Laurens, M.B., Kriljenko, M.J.I.C. and Habermeier, M.K.F., 2000. *Capital controls: country experiences with their use and liberalization* (No. 190). International Monetary Fund. p.6

- ♦ **“Administrative” буюу шууд хязгаарлалтын арга хэмжээнүүд** – Энэ нь тодорхой хил дамнасан санхүү, хөрөнгийн гүйлгээ, шилжилт, түүнтэй холбогдох төлбөр тооцоог бүрэн хориглох, түүнд тоон хязгаарлалт тавих, эсвэл зөвшөөрлийн дагуу хийдэг болгох зэрэг арга хэмжээг хэлнэ. Ингэснээр тухайлсан хөрөнгийн урсгалын хэмжээнд шууд нөлөөлж чаддаг.
- ♦ **“Market based” буюу шууд бус хязгаарлалтын арга хэмжээнүүд** – Энэ нь тухайлсан хөрөнгийн урсгалын зардлыг нэмэгдүүлэх замаар сонирхлыг нь бууруулж, хөрөнгийн шилжилтийг хязгаарладаг. Үүнд багтах түгээмэл арга хэмжээнүүдээс дурдвал:
 - Хил дамнасан хөрөнгийн урсгалд шууд болон шууд бус татвар ногдуулах. Тодруулбал шууд татвар ногдуулах замаар дотоодын эдийн засгийн харьяат (resident)-ын гадаадад эзэмших санхүүгийн хөрөнгийн өгөөжийг бууруулах, эсвэл гадаадын эдийн засгийн харьяатын дотоодод эзэмшиж буй хөрөнгийн өгөөжийг бууруулах арга хэмжээ авдаг.
 - Ялгаатай ханшийн систем (multiple exchange rate system) тогтоох. Өөр өөр төрлийн санхүүгийн гүйлгээ, урсгалд ялгаатай ханш тооцдог байх ханшийн системийг хэлнэ.
 - Хүүгүй заавал байлгах нөөц (unremunerated reserve requirement)-ийн шаардлага тавих. Энэ нь гадаадаас авсан зээллэгэд хүүгүй заавал байлгах нөөцийн шаардлага тавих замаар хөрөнгийн урсгалыг хязгаарладаг.
 - Арилжааны банкнуудын гадаад валютын нээлттэй цэвэр позицод хязгаарлалт тавих, богино болон урт позиц, эдийн засгийн харьяатаас нь хамааруулж ялгавартай тогтоох, хөрөнгийн урсгалыг хянах зорилгоор тайлагналын шаардлагыг тодорхой төрлийн урсгалд тавих зэрэг бусад арга хэмжээнүүд багтана.

Хүснэгт 1.5

Улс орнууд дахь хөрөнгийн урсгалын хязгаарлалт

High (42)		Upper Middle (26)		Lower Middle & Low (32)	
Australia	Gate	Algeria	Wall	Bangladesh*	Gate
Austria	Open	Angola	Wall	Bolivia	Gate
Bahrain	Gate	Argentina	Gate	Burkina Faso*	Gate
Belgium	Open	Brazil	Gate	Cote d'Ivoire	Wall
Brunei Darussalam	Open	Bulgaria	Gate	Egypt	Open
Canada	Open	China	Wall	El Salvador	Open
Chile	Gate	Colombia	Gate	Ethiopia*	Gate
Cyprus	Gate	Costa Rica	Open	Georgia	Open
Czech Republic	Gate	Dominican Republic	Gate	Ghana	Gate
Denmark	Open	Ecuador	Gate	Guatemala	Open
Finland	Open	Hungary	Gate	India	Wall
France	Open	Iran	Gate	Indonesia	Gate
Germany	Gate	Jamaica	Gate	Kenya*	Gate
Greece	Open	Kazakhstan	Gate	Kyrgyz Republic	Gate
Hong Kong	Open	Lebanon	Gate	Moldova	Gate
Iceland	Gate	Malaysia	Wall	Morocco	Wall
Ireland	Open	Mauritius	Open	Myanmar*	Gate
Israel	Gate	Mexico	Gate	Nicaragua	Open
Italy	Open	Panama	Open	Nigeria	Gate
Japan	Open	Peru	Open	Pakistan	Wall
Korea	Gate	Romania	Gate	Paraguay	Open
Kuwait	Gate	South Africa	Gate	Philippines	Wall
Latvia	Open	Thailand	Gate	Sri Lanka	Wall
Malta	Gate	Tunisia	Wall	Swaziland	Wall
Netherlands	Open	Turkey	Gate	Tanzania*	Wall
New Zealand	Open	Venezuela	Gate	Togo*	Wall
Norway	Open			Uganda*	Gate
Oman	Open			Ukraine	Wall
Poland	Gate			Uzbekistan	Wall
Portugal	Gate			Vietnam	Gate
Qatar	Open			Yemen	Open
Russia	Gate			Zambia	Open
Saudi Arabia	Gate				
Singapore	Open				
Slovenia	Gate				
Spain	Open				
Sweden	Open				
Switzerland	Gate				
U.A.E.	Gate				
United Kingdom	Open				
United States	Open				
Uruguay	Open				
Open (36) / Gate (48) / Wall (16)					
24 / 18 / 0		4 / 17 / 5		8 / 13 / 11	

* = Low Income rather than Lower Middle Income

Эх сурвалж: Fernández, A., Klein, M.W., Rebucci, A., Schindler, M. and Uribe, M., 2015. Capital control measures: A new dataset (No. w20970). National Bureau of Economic Research. p.15

Fernández ба бусад (2015) нар дэлхийн 100 улс орныг орлогын түвшнээр нь ангилж, хөрөнгийн хязгаарлалтын хувьд нээлттэй (OPEN), хязгаарлалттай (GATE), хатуу хязгаарлалттай (WALL) гэж 3 ангилжээ. Ингэхдээ судалгаанд авч үзсэн хугацаанд (1995-2013) дунджаар санхүүгийн үйл ажиллагааны ангиллуудын 10-аас бага хувьд хөрөнгийн хязгаарлалт тавигддаг, 20-иос дээш хувьтай байсан жил байхгүй улс орнуудыг нээлттэй (OPEN) орон гэж тодорхойлсон. Харин энэхүү хугацаанд дунджаар санхүүгийн үйл ажиллагааны ангиллуудын 70-аас их хувьд хөрөнгийн хязгаарлалт тавигддаг, 60-аас бага хувьтай байсан жил байхгүй улс орнуудыг хөрөнгийн урсгалын хатуу хязгаарлалттай (WALL) орон гэж тодорхойлсон.

Тус судалгааны үр дүнгээс (Хүснэгт 1.5) харахад өндөр орлоготой орнууд нь хөрөнгийн хязгаарлалт багатай бөгөөд ялангуяа хатуу хязгаарлалттай (WALL) орон байхгүй байгаа бол бага орлоготой орнуудын хувьд хөрөнгийн хязгаарлалт өндөр байх хандлагатай байна. Тухайлбал Хятад, Энэтхэг, Филиппин зэрэг томоохон орнууд хөрөнгийн урсгалын хувьд хатуу хязгаарлалттай байдаг.

Монгол улсад зарим хил дамнасан санхүүгийн гүйлгээ, хөрөнгийн урсгалд тодорхой хязгаарлалт, хяналт тавьдаг байна. Эдгээрээс дурдвал:¹⁴

- ♦ **Хөрөнгийн зах зээлийн үнэт цаасанд тавих хяналт, хязгаарлалт** – Монгол улсад үнэт цаас худалдан авсан гадаадын харьяат нь хувьцааны хяналтын багцын хэмжээ нь 5 хувиар нэмэгдсэн, буурсан тохиолдол бүрд ажлын 5 өдрийн дотор СЗХ, Хөрөнгийн биржид мэдэгдэх ба нийтэд өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх үүрэгтэй. Бонд, өрийн бичиг худалдан авах тохиолдолд тухайн брокер дилерийн компанид бүртгүүлэх үүрэгтэй. Түүнчлэн гадаадын харьяат нь МУ-д бонд, өрийн бичиг гаргах нь хориотой.¹⁵
- ♦ **Хамтын хөрөнгө оруулалтын үнэт цаас** – гадаадад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сан нь МУ-д хувьцаагаа олон нийтэд санал болгож, зарах нь хориотой.¹⁶
- ♦ **Санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон бусад төрлийн хэрэгслүүд** – банк болон банкнаас бусад санхүүгийн байгууллагууд нь МБ, СЗХ-ноос тавьдаг гадаад валютын нээлттэй цэвэр позицын хязгаарлалтыг хангах ёстой ба дээрх санхүүгийн хэрэгслийг тус тооцоонд оруулдаг.
- ♦ **Үл хөдлөх хөрөнгө** – дотоодын харьяат нь гадаадад үл хөдлөх хөрөнгө худалдан авах, гадаадын харьяат нь дотоодод үл хөдлөх хөрөнгө худалдан авах тохиолдолд улсын бүртгэлд зайлшгүй бүртгүүлэх ёстой.
- ♦ **Хөрөнгийн хувийн шилжүүлэг** – гадаадын харьяат нь дотоодын харьяатад зээл олгох тохиолдолд зээлийн гэрээ хийснээс 15 хоногийн дотор Монголбанкинд бүртгүүлэх ёстой.

¹⁴ Эх сурвалж: AREAER Country Report – Mongolia 2017

¹⁵ “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн дагуу


¹⁶ “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль”-ийн дагуу

БОДИТ СЕКТОР

2018 оны 3 дугаар улиралд бодит секторын идэвхжил нэмэгдэж, улирлын бодит ДНБ өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өслөө.

Дүрслэл 1.29

Эдийн засгийн өсөлтийн задаргаа



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Төмрийн хүдрийн экспорт өсч, дотоодын тээвэр нэмэгдсэнээр тээвэр ба агуулахын салбарын өсөлт 21.7 хувьд хүрч, энэ нь ДНБ-ий өсөлтөд хамгийн өндөр хувь нэмрийг (1.3 нэгж хувь) оруулсан байна.

Хүснэгт 1.6

ДНБ-ий бодит өсөлт (салбаруудаар)

	2017		2018 III	
	Жилийн өсөлт	Эзлэх хувь	Жилийн өсөлт	Эзлэх хувь
1 ДНБ-ий өсөлт	5.1	5.1	6.7	6.7
2 Зээлийн багцад дийлэнх хувийг эзэлдэг	1.6	0.8	0.2	0.1
Уул уурхай	-6.9	-1.7	-1.0	-0.2
Боловсруулах	22.8	1.3	4.0	0.3
Барилга	-0.8	0.0	-8.9	-0.3
Худалдаа	9.7	1.2	2.7	0.3
3 Бусад салбарууд	6.1	2.8	12.0	4.1
Бусад үйлчилгээ	5.1	1.0	8.5	1.8
Хөдөө аж ахуй	2.3	0.3	4.1	0.6
Тээвэр ба агуулах	16.7	1.2	21.7	1.3
Эрчим хүч	4.2	0.1	11.1	0.1
Мэдээлэл, холбоо	7.9	0.2	12.9	0.3
4 Бүт. цэвэр татвар	18.6	1.6	26.1	2.5

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.


Түүнчлэн бусад үйлчилгээний салбарууд¹⁷ нийлбэр дүнгээрээ 1.8 нэгж хувийн эерэг нөлөөг өсөлтөд үзүүлсэн бөгөөд

үүнд санхүүгийн зуучлалын өсөлт голлон нөлөөлжээ.

2018 оны 3 дугаар улиралд хөдөө аж ахуй, боловсруулах болон худалдааны салбарын өсөлт харьцангуй бага байсан бол барилга болон уул уурхайн салбар агшилттай байлаа. Зэсийн баяжмалаас бусад үйлдвэрлэл буурснаар уул уурхайн салбарын өсөлт эдийн засгийн өсөлтөд 0.2 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлсэн бол барилгын салбарт борлогдоогүй орон сууцны тоо өссөн тул үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар буурчээ. Харин нийт эдийн засаг идэвхжсэний нөлөөгөөр бүтээгдэхүүний цэвэр татвар 26.1 хувиар өссөн байна.

Дүрслэл 1.30

Бодит ДНБ, нийт зээлийн өсөлт, нийт зээлийн чанар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Өрхийн хэрэглээ

Өрхийн хэрэглээ (иргэдийн зээл банкны салбарын зээлийн багцын 47.8 хувь¹⁸, нийт чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн 10.6 хувь) тайлант улиралд өмнөх үеийн мөн үеэс 1.8 хувиар өсч, эрэлтэд 0.9 нэгж хувийн эерэг нөлөө үзүүллээ. Хэрэглэгчийн итгэлийн индекс буурч¹⁹, хэрэглээний импортын өсөлт

¹⁷ Бусад үйлчилгээний салбарын өсөлтийн дийлэнх хэсгийг санхүү, даатгалын үйл ажиллагаа бүрдүүлдэг.


¹⁸ Өрхийн хэрэглээний зээлд хэрэглээ, цалин, тэтгэвэр, ипотекийн зээлийг хамруулсан.

¹⁹ Тус индексийг NRCC судалгааны байгууллагаас жил бүр тооцдог.

удааширснаар өрхийн хэрэглээний өсөлт ийнхүү саарлаа.

Дүрслэл 1.31

Өрхийн хэрэглээ, нийт хэрэглээний зээл²⁰, хэрэглээний импортын өсөлт




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт тайлант улиралд 33.5 хувиар өсч нийт эрэлтэд 11 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлээ. Гадаад болон дотоод зах зээлд оролцогчдын итгэл сэргэснээр сүүлийн улирлуудад хөрөнгө оруулалт тогтвортой нэмэгдэж байна.

Дүрслэл 1.32

Хөрөнгө оруулалт, нийт бизнесийн зээл²¹, хөрөнгө оруулалтын импортын өсөлт




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Уул уурхайн салбар

Тайлант улиралд зэсийн баяжмалаас бусад үйлдвэрлэл буурсантай холбоотойгоор уул уурхайн салбарын үйлдвэрлэл 1 хувиар агшсан. Тус салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж, олон улсын захад түүхий эдийн үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдсан нь үйлдвэрлэлийг дэмжиж, салбарын чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээг бууруулах нөлөө үзүүлж байна. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар нийт зээлийн багцын 7.3 хувь, нийт чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн 18.1 хувийг уул уурхайн салбарын зээл бүрдүүлж байгаа юм.

Дүрслэл 1.33

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Боловсруулах үйлдвэрлэлийн салбар


Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын тайлант улирлын 4 хувийн өсөлтийг хүнсний үйлдвэрлэлийн өсөлт голлон тайлбарлаж байна. Төмөрлөг бус эдлэл, тамхи, нэхмэл, кокс шахмал түлшийн үйлдвэрлэл буурсан байна.

²⁰ Нийт хэрэглээний зээлд хэрэглээ, цалин, тэтгэврийн зээлүүдийг хамруулсан.

²¹ Нийт хэрэглээний зээлээс бусад эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудад олгосон зээлүүдийг хамруулсан.

Дүрслэл 1.34

Боловсруулах салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Барилга, үл хөдлөх хөрөнгийн салбар

Барилга, үл хөдлөх хөрөнгийн салбарын өсөлт сүүлийн улирлуудад буурч, тайлант улиралд -8.9 хувьд хүрчээ. Тус салбарын үйлдвэрлэл ийнхүү буурахад борлогдоогүй орон сууцны нийлүүлэлт өндөр байгаа нь голлон нөлөөлөв.

Дүрслэл 1.35

Барилгын салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк


Худалдааны салбар

Худалдааны салбарын өсөлт 2016 оны сүүлчээс эхлэн сэргэсэн ч тайлант улиралд өсөлтийн хурд саарч 2.7 хувьд хүрсэн. Тус салбарын өсөлтийн хурд ийнхүү саарахад

нефтийн бүтээгдэхүүний борлуулалтын өсөлт саарсан нь голлон нөлөөллөө. Салбарын үйлдвэрлэлийн өсөлтийн хурд саарснаар худалдааны салбарын чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн буурах хурд удааширсан.

Дүрслэл 1.36

Худалдааны салбарын үйлчилгээ, зээлийн өсөлт, зээлийн чанар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

Бусад салбар

Бусад салбарууд (нийт зээлийн багцын 24.1 хувь, нийт чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн 18.2 хувь) тайлант улиралд 4.1 хувиар өслөө. Уг өсөлтөд санхүү, даатгалын зуучлалын үйлчилгээ, хөдөө аж ахуй, тээврийн салбаруудын идэвхжил голлон нөлөөлжээ.

Дүрслэл 1.37

Бусад салбарын үйлдвэрлэл, зээлийн өсөлт, зээлийн чанар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк


Өрхийн сектор

Санхүүгийн тогтвортой байдалд өрхүүдийн эдийн засгийн нөхцөл байдал чухал ач холбогдолтой байдаг. Өрхийн санхүүгийн байдал эрүүл, тогтвортой байх нь банкны салбар төдийгүй нийт системийн хэмжээнд чухал ач холбогдолтой юм.

Өрхийн зарлага орлогоосоо давлаа. Өрхийн бодит орлого өсөх нь өрхийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэн, амьжиргааны түвшинг өсгөх, улмаар зээлийн эргэн төлөлтийн чадавхыг сайжруулах эерэг нөлөөтэй байдаг. Улсын хэмжээнд өрхийн сарын дундаж бодит орлого²² 2018 оны 3 дугаар улиралд өнгөрсөн оны мөн үеэс 9.0 хувиар, нэрлэсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 14.7 хувиар тус тус өслөө. Өрхийн нэрлэсэн орлогын өсөлтийн 6.3 нэгж хувийг цалин хөлс, 2.8 нэгж хувийг тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговрын орлого, 2.7 нэгж хувийг ХАА-н үйлдвэрлэлийн орлогын өсөлт тус тус бүрдүүлж байна.

Дүрслэл 1.38

Өрхийн орлого, зарлагын харьцаа




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Хэдийгээр эдийн засгийн идэвхжилтэй уялдан ийнхүү өрхийн орлого ийнхүү нэмэгдсэн

дүнтэй гарсан ч өрхийн зарлага мөн тэлж, иргэд хэрэглээгээ зээлээр санхүүжүүлэх хандлагатай байна. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар өрхийн нэрлэсэн зарлага өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар өсчээ.

Дүрслэл 1.39

Өрхийн орлого зарлагын зөрүү, хэрэглээний зээлийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо.

Сүүлийн 3 жил орчмын хугацаанд өрхийн зарлага орлогоосоо давж өссөний зэрэгцээ, иргэдийн хэрэглээний зээл хурдтай өссөн нь иргэдийн өрийн түвшин хуримтлагдах гол шалтгаан боллоо²³.

Банкны салбараас иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 2018 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 24.3 хувиар нэмэгдэж, 8.1 их наяд төгрөгт хүрлээ. Тухайлбал, хэрэглээний зээлийн нөлөөгөөр 2016 оноос эхлэн иргэдийн зээл ба ДНБ-ий харьцаа өсөх хандлагатай байгаа бөгөөд 3 дугаар улирлын эцэст тус харьцаа 34.8 хувьд хүрээд байна. Түүнчлэн нэг өрхөд ногдох иргэдийн зээл 2018 оны 3 дугаар улиралд 9.1 саяд хүрч, өмнөх оны мөн үеэс 24.3 хувиар өсөв.


Орлого, зарлагын зөрүүг өрхүүд өөрийн хадгаламжаас санхүүжүүлсэн тохиолдолд хэрэглээний зээлийн эрэлтийг үүсгээгүй байх боломжтой.

²² Инфляци = 5.7 хувь

²³ Өрхийн орлого, зарлагад бусдаас мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр авсан тусламжийн дүнг оруулдаг.

Дүрслэл 1.40


Өрхийн өрийн дарамт



Нэг өрхөд ногдох иргэдийн зээл ба өрхийн жилийн дундаж орлогын харьцаагаар өрхийн өрийн дарамтыг төлөөлүүлэн хэмжихэд 2018 оны 3 дугаар улиралд өрхийн өрийн дарамт 67.9 хувь байна.

Дүрслэл 1.41

Иргэдийн зээлийн ДНБ-д эзлэх хувь



Иргэдийн зээл дотор цалин, тэтгэвэр, хэрэглээний бусад зээл хурдтай нэмэгдсэн тул иргэд орлогынхоо 50-100 хүртэлх хувийг зээлийн төлбөрт зарцуулж байгаа нь өрхийн секторын нэг эмзэг байдлыг бий болгож байна. Тухайлбал, цалингийн зээл 2018 оны 3

дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 41.2 хувиар, тэтгэврийн зээл 26 хувиар, хэрэглээний бусад зээл 95 хувиар тус тус өсчээ. Ийнхүү цалин, тэтгэвэр, хэрэглээний бусад зээл хурдтай өсөхөд нэг талаас банкнууд эдгээр төрлийн зээлийг олгохдоо өр, орлогын харьцааг өндрөөр тогтоож хоорондоо өрсөлдөж байгаа нь нөлөөлж байгаа бол нөгөө талаас иргэд өнөөдрийн хэрэглээг зээлээр нэмэгдүүлэх шийдвэр гаргахдаа ирээдүйн орлогоо хэт өөдрөгөөр төсөөлж байгаа нь мөн нөлөөлж байгаа юм.

2018 оны 10 дугаар сарын байдлаар хэрэглээний зээлтэй иргэд татварын дараах орлогынхоо дунджаар 69 хувийг зээлийн төлбөрт зарцуулж байна. Өр, орлогын энэхүү харьцааг зээлийн төрлөөр задалж үзвэл цалингийн зээлийн хувьд 64 хувь, тэтгэврийн зээлийн хувьд 84 хувь, хэрэглээний бусад зээлийн хувьд 66 хувь байна.

Хүснэгт 1.7

Иргэдийн өр, орлогын харьцаа

Зээлийн төрөл	Өр орлогын харьцааны тархалт			Дундаж өр орлогын харьцаа
	70%-аас доош	70%-90%	90%-100%	
Цалин	81%	16%	4%	64%
Тэтгэвэр	32%	0%	68%	84%
Хэрэглээ	79%	15%	6%	66%
Нийт	71%	12%	17%	69%

Эх сурвалж: Монголбанк


Ийнхүү иргэдийн зээл хурдтай өсч, иргэд орлогынхоо дийлэнх хувийг зээлийн төлбөрт төлж байгаагийн зэрэгцээ цаашид хэрэглээг дэмжсэн эдгээр төрлийн зээлийн хувьд өр, орлогын харьцаа нэмэгдэх нь иргэдийн санхүү, амжиргаа, ирээдүйн хэрэглээнд сөргөөр нөлөөлж, нийт хэрэглээний огцом хэлбэлзлээр дамжин эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм. Иймд Монголбанкнаас хэрэглээний шинж чанартай зээлийн хэт өсөлтийг хазаарлах, иргэдийн өнөөгийн болон ирээдүйн хэрэглээг тэнцвэржүүлэх зорилгоор 2019 оны 1 дүгээр

сарын 01-ний өдрөөс эхлэн банкнаас иргэдэд шинээр олгох, нөхцөлийг нь өөрчлөх цалин, тэтгэвэр, хэрэглээний зээлийн хувьд зээлдэгчийн өр, орлогын харьцааг 70 хувиас, зээлийн хугацааг 30 сараас тус тус хэтрүүлэхгүй байх хязгаарыг тогтоосон.

Иргэдийн зээлийн чанар 2009 оны 4 дүгээр улиралд хамгийн ихээр муудаж, 9.0 хувьд хүрч байсан бөгөөд 2018 оны 10 дугаар сарын байдлаар иргэдийн зээлийн 3.1 хувь буюу 257 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд бүртгэгдэж байна.

Дүрслэл 1.42

Иргэдийн зээлийн үлдэгдэл, чанар



Эх сурвалж: Монголбанк, Тэнхлэг зууч ХХК.


Иргэдэд гадаад валютаар олгосон зээлийн чанаргүй болох магадлал харьцангуй өндөр байна. Нийт иргэдийн зээлийн 98.3 хувийг төгрөгийн зээл, үлдсэн хувийг гадаад валютын зээл бүрдүүлж байна. 2018 оны 10 дугаар сард иргэдийн гадаад валютын чанаргүй зээлийн хувь огцом өсч, өмнөх сараас 10.5 нэгж хувиар нэмэгдэн 19.8 хувьд хүрээд байна. Түүнчлэн төгрөгийн чанаргүй зээл 228.4 тэрбум, гадаад валютын чанаргүй зээл 28.6 тэрбум төгрөгт хүрлээ.

Иймд Монголбанкнаас гадаад валютын зээл олголтыг сааруулах, санхүүгийн системд үүсэх сөрөг үр дагаврыг бууруулах зорилгоор ханшийн эрсдэлтэй иргэд, ААН-д олгох гадаад валютын зээлийн эрсдэлийн жинг

нэмэгдүүлэх макро зохистой бодлогын арга хэмжээг авсан.

Дүрслэл 1.43

Иргэдийн чанаргүй зээлийн хувь, валютын төрлөөр




Эх сурвалж: Монголбанк

ҮСХ-ноос мэдээлснээр орон сууцны үнэ 2018 оны 3 дугаар улиралд тогтвортой хадгалагдсан бол, Тэнхлэг зууч ХХК-ийн мэдээлснээр шинэ орон сууцны үнэ өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар, хуучин орон сууцны үнэ 3.0 хувиар тус тус өсч, нийт дүнгээрээ орон сууцны үнэ өмнөх улирлаас 1.9 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.8 хувиар тус тус өсөөд байна.

Дүрслэл 1.44

Орон сууцны үнэ, ипотекийн зээлдэгчдийн тооны жилийн өөрчлөлт




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 3 дугаар улирлын статистик болно.

2018 оны 3 дугаар улиралд нийт 2120 иргэн ипотекийн зээлд шинээр хамрагдсан нь өмнөх улирлаас 25.6 хувиар, өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар буурсан үзүүлэлт болсон.

Дүрслэл 1.45

Орон сууцны үнэ, ипотекийн зээлдэгчдийн жилийн өөрчлөлт




Нэгж орлогод ногдох орон сууцны ипотекийн зээлийн төлбөрийн хувь хэмжээ буюу өр/орлогын харьцаа 2017 оны 3 дугаар улиралд 52 хувьд хүрч өсөөд байсан бол 2018

оны 3 дугаар улиралд 47.6 хувьтай байна. Энэхүү харьцаа нь дундаж өрх орон сууцны ипотекийн зээл авсан бол өр, төлбөрийн дарамт (орлоготой харьцуулсан) ямар байхыг илтгэнэ.

Дүрслэл 1.46

Өрхийн өр, орлогын харьцаа*



Шигтгээ 2: Монгол Улсын өрхийн секторын микро стресс тест

2008 оны санхүү, эдийн засгийн хямралаас хойш дэлхийн улс орнууд санхүүгийн тогтвортой байдлыг хангах асуудлыг чухалчлах болсон. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндэс суурь нь нийт санхүүгийн системд тогтворгүй байдал үүсгэж болзошгүй системийн шинжтэй эрсдэлийг илрүүлж, эрсдэлийг бууруулах чиглэлд бодлогын оновчтой, үр дүнтэй арга хэмжээг авах явдал юм. Системийн эрсдэлийг илрүүлэх, хянах үйл ажиллагаа нь зөвхөн санхүүгийн салбарын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд (санхүүгийн байгууллагууд, санхүүгийн зах зээл, дэд бүтэц)-д чиглэсэн эрсдэлийн үнэлгээгээр хязгаарлагдахгүй бөгөөд мөн банк, санхүүгийн байгууллагуудын гол харилцагчид болох өрхийн сектор, хувийн сектор болон улсын секторт чиглэсэн эрсдэлийн үнэлгээ, шинжилгээг гүйцэтгэх шаардлагатай байдаг.

Монгол Улсын иргэдийн зээлийн хэмжээ сүүлийн жилүүдэд тасралтгүй нэмэгдэж байгаатай холбоотойгоор макро эдийн засгийн өөрчлөлтийн өрхийн зээлийн чанар, санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөө нэмэгдэх хандлагатай байна. Иймд макро эдийн засгийн болзошгүй өөрчлөлтүүдийн иргэдийн зээлийн чанарт үзүүлэх нөлөөг 2017 оны өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгааны тоон өгөгдөлд үндэслэн микро стресс тестийн аргачлал ашиглан тооцлоо²⁴.

Өрхүүдийн микро түвшний тоон өгөгдөлд суурилан микро стресс тест хийхэд ашигладаг гол аргачлал нь санхүүжилтийн зөрүү (financial margin) аргачлал юм. Энэхүү аргачлалаар өрх тус бүрийн татварын дараах нийт орлогоос зээлийн төлбөр, амжиргааны доод түвшинг хангах хэрэглээний зардлыг хасч санхүүжилтийн зөрүүг тооцдог.

$$FM_i = Y_i - (P_i + r_i) - MC_i$$

Энд FM_i - i дугаар өрхийн санхүүжилтийн зөрүү, MC_i - i дугаар өрхийн амжиргааны доод түвшинг хангах хэрэглээний түвшин, P_i - i дугаар өрхийн зээлийн үндсэн төлбөр, r_i - i дугаар өрхийн зээлийн хүүгийн төлбөр болно.

Ийнхүү өрх тус бүрийн санхүүжилтийн зөрүүг тооцсоны дараа дараах байдлаар өрхийн зээлийн дефолт болох магадлалуудыг тооцоолно.

$$PD_i = \begin{cases} 1 & \text{хэрэв } FM_i < 0 \\ 0 & \text{хэрэв } FM_i \geq 0 \end{cases}$$

Энд PD_i - i дугаар өрхийн зээлийн дефолт болох магадлал юм. Өөрөөр хэлбэл сөрөг санхүүжилтийн зөрүүтэй өрхүүдийн дефолт болох магадлал 1 байна.

Үүний дараа эрсдэлтэй зээлийн хувь хэмжээ (exposure at risk)-г дараах томъёог ашиглан тооцно.

$$EAR = \frac{\sum_i^N PD_i * D_i}{\sum_i^N D_i}$$


²⁴ Үндэсний статистикийн хорооноос 2007 оноос эхлэн жилд 1 удаа өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгааг зохион байгуулж байгаа бөгөөд хамгийн сүүлд зохиогдсон 2017 оны түүвэр судалгаанд Монгол улсын хэмжээнд нийт 11193 өрхүүдийг хамруулсан байна.

Энд EAR – эрсдэлтэй зээлийн хувь хэмжээ, N – нийт өрхийн тоо, D_i – i дугаар өрхийн нийт зээлийн өрийн үлдэгдэл²⁵.

Дээрх аргачлалын дагуу өрхүүдийн санхүүжилтийн зөрүү, эрсдэлтэй зээлийн хувь хэмжээг тооцоолоход нийт өрхүүдийн 8.5 хувь нь сөрөг санхүүжилтийн зөрүүтэй, эрсдэлтэй зээл нь өрхийн нийт зээлийн 10.5 хувийг эзэлж байна.

Дүрслэл 1.47

Шокуудын нөлөөлөх суваг




Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Улмаар зээлийн хүү, ажилгүйдэл, хэрэглээний зардалд гарсан сөрөг шокууд нь /зээлийн хүү 1 хувь, 3 хувь, 5 хувиар өсөх, ажиллах хүчний оролцооны түвшин 1 хувь, 3 хувь, 5 хувиар буурах, амьжиргааны доод түвшинг хангах зардал 5 хувь, 10 хувь, 15 хувиар тус тус нэмэгдэхэд/ эрсдэлтэй зээлийн хувь хэмжээнд хэрхэн нөлөөлөхийг үнэлж үр дүнг дүрслэлт 1.48-1.51-т харууллаа.


Дүрслэл 1.48

Зээлийн хүүний шокийн нөлөө



Дүрслэл 1.49

Хэрэглээний зардлын шокийн нөлөө




Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

²⁵ Өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгаанд зөвхөн сүүлийн 12 сард авсан зээлийн үлдэгдэл байдаг бөгөөд харин 12 сараас өмнө нь авсан зээлийн сарын төлбөрийн мэдээлэл байдаг учраас тус зээлийн үлдэгдлийг тухайн төрлийн зээлийн сарын нийт төлбөр, зээлийн дундаж хугацаа, хүүгийн мэдээлэлд үндэслэн тооцоолсон.


Дүрслэл 1.50

Ажилгүйдлийн шокийн нөлөө



Дүрслэл 1.51

Нийлмэл шокийн нөлөө



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Тэмдэглэл: Сул сценари нь зээлийн хүү 1 нэгж хувиар нэмэгдэх, хэрэглээний зардал 5 хувиар өсөх, ажиллах хүчний оролцооны түвшин 1 нэгж хувиар буурах, хүчтэй сценари нь зээлийн хүү 5 нэгж хувиар нэмэгдэх, хэрэглээний зардал 15 хувиар өсөх, ажиллах хүчний оролцооны түвшин 5 нэгж хувиар буурах тохиолдлууд болно.


Стресс тестийн зарим үр дүнгүүдээс дурдвал зээлийн хүү 3 нэгж хувиар өсөхөд эрсдэлтэй зээлийн харьцаа 1.7 нэгж хувиар, сөрөг санхүүжилтийн зөрүү бүхий өрхийн нийт өрхөд эзлэх хувь 0.3 нэгж хувиар, харин амьжиргааны доод түвшин хангах хэрэглээний зардал 10 нэгж хувиар нэмэгдэхэд эрсдэлтэй зээлийн харьцаа 1.6 нэгж хувиар, сөрөг санхүүжилтийн зөрүү бүхий өрхийн нийт өрхөд эзлэх хувь 1.2 нэгж хувиар тус тус өсөхөөр байна. Түүнчлэн хамгийн хүчтэй нийлмэл сөрөг шок учрах буюу зээлийн хүү 5 нэгж хувиар нэмэгдэх, амьжиргааны доод түвшинг хангах хэрэглээний зардал 15 хувиар өсөх, ажиллах хүчний оролцооны түвшин 5 нэгж хувиар буурахад эрсдэлтэй зээлийн харьцаа 12.8 нэгж хувиар, сөрөг санхүүжилтийн зөрүү бүхий өрхийн нийт өрхөд эзлэх хувь 4.4 нэгж хувиар тус тус өсөх үр дүн гарсан.

Хувийн сектор

2017 оны эцэст 201.0 хувьд хүрээнд байсан хувийн секторын нийт өр болон ДНБ-ий харьцаа эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагаа, төлбөрийн чадвар сайжирснаар 2018 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 183.0 хувь болж буураад байна.

Дүрслэл 1.52

Аж ахуйн нэгж байгууллагын нийт өр төлбөр ба ДНБ-ий харьцаа*




Эх сурвалж: Сангийн яам

Тэмдэглэл: *Жил бүрийн 2 дугаар улирлын эцсийн байдлаар.

2016 оны 4 дүгээр улиралд 2.2 хувь байсан өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа 2018 оны 2 дугаар улиралд 1.2 хувь болж буурчээ.

Дүрслэл 1.53

Өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа



Эх сурвалж: Сангийн яам


Тус хугацаанд нийт өр төлбөрийн хэмжээ харьцангуй тогтвортой байсан ч эздийн өмчийн дүн өссөн нь өр төлбөр ба эздийн

өмчийн харьцаа ийнхүү буурах үндсэн шалтгаан болсон.

2014 оны 2 дугаар улирлын байдлаар -469 тэрбум төгрөг байсан аж ахуй нэгж байгууллагуудын татварын өмнөх цэвэр ашиг 2014 оны 4 дүгээр улиралд огцом нэмэгдэж 10 их наяд төгрөгт хүрч, улмаар активын өгөөжийн үзүүлэлт -0.8 хувиас 11.9 хувь болж өссөн юм. Харин активын өгөөжийн үзүүлэлт 2018 оны 2 дугаар улиралд 2.2 хувьтай байна.

Дүрслэл 1.54

Активын өгөөж




Эх сурвалж: Сангийн яам.

Хүү төлөх чадварын харьцаа (interest coverage ratio) нь аж ахуй нэгж байгууллагуудын санхүүгийн чадавхыг илэрхийлэх чухал үзүүлэлт юм. Аж ахуй нэгж байгууллагуудын хүү төлөх чадварын харьцаа нь 2016 онд -1.65 хувь байсан бол 2017 оноос тасралтгүй өсч, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 4.6 хувьд хүрээд байна. Ийнхүү өсөхөд эдийн засгийн идэвхжлийг дагаж аж ахуй нэгж байгууллагуудын ашиг нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

2018 оны 10 дугаар сарын эцэст санхүүгийн байгууллагуудаас авсан хувийн хэвшлийн зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар өсч, 7.9 их наяд төгрөгт хүрлээ.

Дүрслэл 1.55

Хүү төлөх чадварын харьцаа




Эх сурвалж: Сангийн яам.

Нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувийн хэвшлийн зээлийн хэмжээ 2010 оноос хойш буурсаар байгаа бөгөөд 2018 оны 10 сарын эцсийн байдлаар 41.3 хувьтай байна.

Дүрслэл 1.56

Хувийн хэвшлийн зээл, зээлийн чанар



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн статистик нь 2018 оны 10 дугаар сарын статистик болно.

Харин хувийн хэвшлийн чанаргүй зээл болон хувийн хэвшлийн нийт зээлийн харьцаа энэ оны 10 сарын байдлаар 21.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 7.6 нэгж хувиар эрс өсчээ.


Хувийн салбарын өрийн дарамтыг хувийн секторын дотоод зээл (арилжааны банкнуудаас авсан) ба гадаад өр төлбөрийн ДНБ-д эзлэх хувиар төлөөлүүлэн хэмжиж болно. 2005 оноос хойш гадаад өрийн дарамт хурдтай өссөөр байгаа бөгөөд 2016 оны 2

дугаар улиралд хувийн салбарын гадаад өр ДНБ-ий 70.7 хувь хувьд хүрч огцом өссөн юм.

Үүнд 2016 оны 2 дугаар улиралд томоохон компаниуд хөрөнгө оруулагчаас авсан зээлээ эргэн төлөх зорилгоор олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас зээл авсан болон төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларсан нь нөлөөлсөн. Харин 2018 оны 3 дугаар улирлын байдлаар хувийн салбарын гадаад өр ба ДНБ-ий харьцаа 62.0 хувьд хүрээд байна.

Дүрслэл 1.57

Хувийн салбарын өрийн дарамт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Тэмдэглэл: *Хувийн секторын зээлийн өрийн үлдэгдэл ба нэрлэсэн ДНБ-ий харьцаа (жилийн ДНБ);

**Хувийн салбарын гадаад өрийг Монголбанкны гадаад өрийн статистик дахь бусад салбаруудын гадаад өрийн дүнгээр төлөөлүүлэн авсан (хадгаламжийн байгууллагын өрийг оруулаагүй болно).

Хувийн салбарын дотоод өр (арилжааны банкнуудаас авсан зээл) ба ДНБ-ий харьцаа сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой байгаа бөгөөд 2018 оны 3 дугаар улирлын байдлаар тус харьцаа 25.8 хувь байна.

Шигтгээ 3: Монгол Улсын аж ахуй нэгжүүдийн бизнес хүлээлтийн түүвэр судалгаа

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд “Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах бөгөөд уг зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ” гэж заасан байдаг. Иймд Монголбанк нь банк, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахтай холбогдуулан банк, санхүүгийн системд тулгарч буй эрсдэлийг тухай бүр тодорхойлж, үнэлж, эрсдэлийг бууруулах чиглэлд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

2018 оны 12 дугаар сард Монголбанкнаас аж ахуй нэгжүүд нь нийт эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал, эдгээрийн цаашдын чиг хандлагыг хэрхэн үнэлж байгаа болон макро-санхүүгийн орчинд гарч болзошгүй өөрчлөлтүүд нь аж ахуй нэгжүүдийн санхүүгийн чадавхад хэрхэн нөлөөлөх хүлээлттэй байгааг үнэн зөв тодорхойлж, үүнд үндэслэн санхүүгийн системд учирч болзошгүй эрсдэлийг үнэлж, цаашид авах бодлого, зохицуулалтын арга хэмжээг тодорхойлох зорилгоор “Монгол Улсын аж ахуй нэгжүүдийн бизнес хүлээлтийн түүвэр судалгаа”-г “Эс Ай Си Эй” ХХК-тай хамтран зохион байгууллаа.

Түүвэр судалгааг аж үйлдвэр, барилга, үйлчилгээ, худалдаа, хөдөө аж ахуй гэсэн 5 салбарын нийт 250 аж ахуй нэгж (ААН)-ийн санхүү, төлөвлөлт хариуцсан удирдах албан тушаалтнуудаас асуулга хэлбэрээр авсан. Судалгааны голлох үр дүнгүүдээс товч дурдвал:

Монгол Улсын эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал сайжирна гэсэн хүлээлттэй байна.

- ◆ Судалгаанд оролцогчид Монгол Улсын эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал сайжирна гэсэн эерэг хүлээлттэй байгаа бөгөөд гол шалтгаан нь сонгууль болохын өмнөх жил улс төрийн байдал тогтвортой, эдийн засаг сэргэдэг гэсэн хүлээлттэй холбоотой байна. Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 38.4 хувь нь Монгол Улсын эдийн засгийн ерөнхий нөхцөл байдлын хүлээгдэж буй өөрчлөлт байгууллагын үйл ажиллагаанд сайнаар нөлөөлнө гэж үзсэн бол 35.6 хувь нь нөлөө үзүүлэхгүй, 24.4 хувь нь муугаар нөлөөлнө гэсэн гутрангуй хүлээлттэй байна.

Салбарын нөхцөл байдал ирэх онд сайжирна гэсэн хүлээлттэй байна.

- ◆ Судалгаанд хамрагдсан нийт ААН-үүдийн 52.0 хувь нь өөрийн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй салбарын нөхцөл байдал ирэх онд сайжирна гэсэн өөдрөг хүлээлттэй байна.
- ◆ ААН-үүдийн 37.6 хувь нь 2018 онд салбарын нөхцөл байдал 2017 онтой харьцуулахад өөрчлөгдөөгүй хэмээн үзжээ. Судалгаанд хамрагдсан нийт ААН-үүд 2018 онд нийт хүчин чадлынхаа дунджаар 75.3 хувийг ашигласан байна.
- ◆ Байгууллагын дотоод орчны үзүүлэлтүүдийн хүлээлтийг задлан харвал борлуулалтын орлогыг сайжирна гэсэн хүлээлттэй ААН-үүдийн эзлэх хувь 56.0% байгаа бол байгууллагын санхүүгийн чадавхыг сайжирна гэсэн хүлээлттэй ААН-үүдийн эзлэх хувь 48.0% байна.

ААН-үүдэд тулгамдаж буй эрсдэлүүд.

- ◆ Судалгаанд оролцогчид 2019 онд ажилгүйдлийн түвшин, төлбөрийн тэнцэл, ГШХО, гадаад худалдааны тэнцэл зэрэг макро орчны үзүүлэлтүүдэд төдийлөн өөрчлөлт орохгүй гэж үзсэн.


- ◆ ААН-үүд бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд гадаад валютын ханшийн тогтворгүй байдал, татварын тогтолцоо, зээлийн хүү, шимтгэл, хураамж гэсэн үзүүлэлт хамгийн их саад болж байна гэж хариулсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 67.2 хувь нь төгрөгийн ам.доллартой харьцах ханш, 60.4 хувь нь зээлийн хүүгийн түвшин ААН-үүдийн үйл ажиллагаанд ихээр нөлөөлдөг гэж хариулжээ. Бусад салбартай харьцуулахад аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарын ААН-үүд төгрөгийн ам.доллартой харьцах ханшид илүү мэдрэг байдаг бол ХАА, барилгын салбарын ААН-үүд зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтөд илүү мэдрэг байдаг байна.
- ◆ Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн хувьд санхүүгийн орчны үзүүлэлтүүдийн өөрчлөлтүүдээс байгууллагын үйл ажиллагаанд хамгийн хүчтэй нөлөөлж байгаа үзүүлэлтээр зээлийн хүүг нэрлэсэн бөгөөд ААН-үүдийн 61.1 хувь нь зээлийн хүүгийн түвшний өөрчлөлт нь байгууллагын үйл ажиллагаанд муугаар нөлөөлнө гэсэн хүлээлттэй байна.
- ◆ Судалгаанд хамрагдсан нийт ААН-үүдийн 60.0 хувь нь одоогийн байдлаар зээлтэй бөгөөд 68.8 хувь нь ирэх онд банк санхүүгийн байгууллагаас авах зээлийн хэрэгцээ байгаа гэж хариулжээ. Бусад салбартай харьцуулахад худалдаа (76.0%) болон аж үйлдвэр (62.0%)-ийн салбарын зээлтэй ААН-үүдийн хувь хэмжээ харьцангуй өндөр байна. Түүнчлэн ХАА (76.0%) болон худалдаа (76.0%)-ны салбарын санхүүжилтийн хэрэгцээтэй байгаа ААН-үүдийн хувь хэмжээ бусад салбарынхтай харьцуулахад өндөр гарсан байна.

МӨНГӨ САНХҮҮГИЙН СЕКТОР

M2 мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2016 оны 1 дүгээр улирлаас эхлэн эерэг дүнтэй болж өссөөр 2018 оны 10 дугаар сарын байдлаар 26.3 хувь байна. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 20.6 нэгж хувийг бусад хадгаламжийн өсөлт, 4.5 нэгж хувийг M1 мөнгөний өсөлт бүрдүүлж байна.

Дүрслэл 1.58

Мөнгөний үзүүлэлтүүд (жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 10 дугаар сарын статистик болно.


M1 мөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.1 хувиар буюу 817.7 тэрбум төгрөгөөр өсч, нийт мөнгөний нийлүүлэлтийн 18.8 хувь буюу 3.4 их наяд төгрөгтэй тэнцэж байна. M1 мөнгийг бүрдүүлж буй төгрөгийн харилцах өмнөх оны мөн үеэс 774.3 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 43.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. M1 мөнгөний жилийн өсөлтийг төгрөгийн харилцах бүрдүүлжээ.

Бусад хадгаламж өмнөх оны мөн үеэс 25.2 хувиар буюу 3.0 их наяд төгрөгөөр нэмэгдэж, мөнгөний нийлүүлэлтийн 81.2 хувь буюу 14.9 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Энэхүү бусад хадгаламжийн жилийн өсөлтийн 14.8 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 8.3 нэгж хувийг валютын харилцах, 2.0 нэгж хувийг валютын хадгаламжийн өсөлт тус тус бүрдүүлж байна.

M2 мөнгийг байршуулалт талаас нь харвал 2018 оны 10 дугаар сарын байдлаар дотоод цэвэр зээлийн жилийн өөрчлөлт 3.9 хувьтай байна.

Дүрслэл 1.59

M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 10 дугаар сарын статистик болно.

Үүний 10.3 нэгж хувийг иргэдийн зээл, 6.1 нэгж хувийг хувийн байгууллагуудын зээл, 1.8 нэгж хувийг бусад санхүүгийн байгууллагуудын зээл, 0.1 нэгж хувийг улсын байгууллагуудын зээлийн өсөлт болон 14.3 нэгж хувийг Засгийн газрын зээлийн бууралт бүрдүүлж байна.

Дүрслэл 1.60

Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц ба хандлага (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Монголбанк.

Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт болон бусад төрлийн шууд хөрөнгө оруулалт, “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд хандивлагч байгууллагуудаас орж ирсэн санхүүжилт, Хөгжлийн банк гадаад зах зээлээс 500 сая ам.долларын бондын эх үүсвэр татсан нь гадаад валютын цэвэр нөөц болон мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг нэмэгдүүлжээ. 2018 оны 10 дугаар сарын байдлаар гадаад цэвэр актив өмнөх оны мөн үеэс 3728.3 тэрбум төгрөгөөр өсч 115.3 тэрбум төгрөгт хүрчээ.

Гадаад валютын харилцах, хадгаламжийн M2 мөнгөнд эзлэх хувь 2016 оны эцсээс эхлэн буурах хандлагатай байсан бол 2018 онд нэмэгдэж эхэлсэн байна. Тодруулбал 2016 оны эцсийн байдлаар 34.7 хувь байсан бол 2017 оны эцсийн байдлаар 27.8 хувь, 2018 оны 10 дугаар сард 29.7 хувьтай болжээ. Төгрөгийн харилцах, хадгаламж M2 мөнгөний 70.3 хувийг эзэлж байна.

Дүрслэл 1.61

Мөнгөний нийлүүлэлт ба мөнгөний үржүүлэгч



Эх сурвалж: Монголбанк.


Тэмдэглэл: *Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 10 дугаар сарын статистик болно.

Мөнгөний үржүүлэгч²⁶ сүүлийн 4 жилийн дунджаар 4.2 нэгж байгаа бөгөөд 2018 оны 10 дугаар сарын байдлаар 4.2 нэгжтэй тэнцүү байна.

²⁶ Нөөц мөнгөний нэгж өсөлт нь хэдий хэмжээний нийт мөнгө (M2)-ний өсөлт бий болгосныг харуулах бөгөөд M2 мөнгө ба нөөц мөнгөний харьцаагаар тодорхойлогдоно.

Дүрслэл 1.62

Банкнудын хадгаламж болон зээлийн хүү




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *Ипотекийн зээлийн хүүг оруулж тооцсон. Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 10 дугаар сарын статистик болно.

2018 оны 10 дугаар сарын байдлаар Монголбанкны бодлогын хүү 10.0 хувь, овернайт хүү 10.0 хувь, репо хүү мөн 10.0 хувь байна.

Дүрслэл 1.63

Банк хоорондын захын хүү




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2018 оны 10 дугаар сарын статистик болно.

Банкнудын төгрөгийн зээлийн жинлэсэн дундаж хүү²⁷ 2018 оны 10 дугаар сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 2.5 нэгж хувиар буурч жилийн 17.6 хувьд хүрэв.

Дүрслэл 1.64

Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх интервал*



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *Хүүний жил бүр хэлбэлзэх интервалыг тухайн жилийн хамгийн их утгаас хамгийн бага утгыг хасч тооцов.

Харин хадгаламжийн жинлэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурч 10 дугаар сарын байдлаар 12.3 хувь байна. Зээл, хадгаламжийн хүүний зөрүү 5.3 хувьтай тэнцэж байна.

²⁷ Банкнудын зээлийн жинлэсэн дундаж хүү нь Монголбанкны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зээлийг оруулан тооцсон хүү болно. Харин хөтөлбөрийн зээлийг хасч тооцвол төгрөгийн зээлийн жинлэсэн дундаж хүү 2018 оны 10 дугаар сарын байдлаар 17.4 хувь байна.

УЛСЫН ТӨСӨВ

Нэгдсэн төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэл

2018 оны 10 дугаар сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 8268.1 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн хэмжээнээс 25.0 хувь буюу 1656.0 тэрбум төгрөгөөр өссөн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 7519.5 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн хэмжээнээс 23.5 хувиар буюу 1431.8 тэрбум төгрөгөөр давж биелжээ.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого төлөвлөгөөнөөс ийнхүү давахад ААН-ийн орлогын албан татвар 556.3 тэрбум төгрөг, НӨАТ 528.1 тэрбум төгрөг, импортын гаалийн албан татвар 103.2 тэрбум төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 100.6 тэрбум төгрөгөөр тус тус давсан нь голлон нөлөөллөө.

Хүснэгт 1.8

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн орлого	Эцсийн төлөвлөгөө	2018 оны эхний 10 сар		
		г	г	%/г
Нийт орлого ба тусламжийн дүн	8022	6612	8 268	125.0%
Тогтворжуулалтын сан	122.7	104	189.2	181.8%
Ирээдүйн өв сан	508.7	420.3	559.3	133.1%
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	7 389	6087.6	7519.4	123.5%
I. Татварын орлого	6 350	5 201	6718.5	129.2%
1. Орлогын албан татвар	1 444	1181.2	1754.8	148.6%
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	691	596.6	1125.9	197.7%
1.2. Хувь хүний орлогын албан татвар	797	656.4	667.9	101.8%
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1 422	1154.9	1284.7	111.2%
3. Хөрөнгийн албан татвар	122	107.1	113.9	106.4%
4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1 517	1227.7	1755.8	143.0%
5. Онцгой албан татвар	684	560.3	620.9	110.8%
6. Тусгай зориулалтын орлого	12	10	11	101.9%
7. Гадаад үйл ажиллагааны орлого	537	451.0	554.2	122.9%
8. Бусад татвар, төлбөр, хураамж	612	508.6	623.1	122.5%
II. Татварын бус орлого	1 039	886.1	800.9	90.4%
1. Нийтлэг татварын бус орлого	927.4	784.3	777.3	99.1%
2. Хөрөнгийн орлого	1075.9	742.7	400.5	53.9%
3. Тусламжийн орлого	110.0	101.0	23.1	23.0%

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: *Төлөвлөгөө,

**Урьдчилсан гүйцэтгэл

Харин татварын бус орлого тайлант хугацаанд 85.2 тэрбум төгрөгөөр тасарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын өсөлтөд сөргөөр нөлөөлжээ.

Хүснэгт 1.9

2018 оны эхний 10 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл, үндсэн бүрэлдэхүүнээр (тэрбум төгрөг)

Төсвийн орлого	УТ*	ОНТ*	НДС	ЭМДС
Нийт орлого ба тусламжийн дүн	6 306	2 200	1 666	337
Тогтворжуулалтын сан	189	0	0	0
Ирээдүйн өв сан	560	0	0	0
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	5 558	2 200	1 666	337
I. Татварын орлого	4 528	905	1 152	337
1. Орлогын албан татвар	1 126	629	0	0
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1 126	0	0	0
1.2. Хувь хүний орлогын албан татвар	0	668	0	0
1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар	0	0	0	0
2. Нийгмийн даатгалын шимтгэл хураамж	0	0	1 152	337
3. Хөрөнгийн албан татвар	0	114	0	0
4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1 756	0	0	0
5. Онцгой албан татвар	621	0	0	0
6. Тусгай үйл ажиллагааны орлого	11	0	0	0
5. Гадаад худалдааны орлого	554	0	0	0
6. Бусад татвар	461	163	0	0
II. Татварын бус орлого	1 029	1 294	515	0

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: *УТ- Улсын төсөв, ОНТ- Орон нутгийн төсөв, НДС- Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан.

Улсын төсөв

Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 5557.7 тэрбум төгрөгт хүрч 28.9 хувиар буюу 1246.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс давжээ. Үүнд ААН-ийн орлогын албан татвар 556.3 тэрбум төгрөгөөр, НӨАТ 528.1 тэрбум төгрөгөөр, импортын гаалийн татвар 103.2 тэрбум төгрөгөөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 100.6 тэрбум төгрөгөөр өссөн нь голчлон нөлөөлсөн бол татварын бус орлого 130.1 тэрбум төгрөгөөр тасарсан нь төсөвт байгууллагуудын өөрийн орлого болон гадаад тусламжийн орлогын гүйцэтгэлээс шалтгаалжээ.

Орон нутгийн төсөв

Орон нутгийн төсвийн орлого 2199.8 тэрбум төгрөгт хүрч 0.9 хувиар буюу 19.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс илүү төвлөрөв. Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлтийг орлогын ангиллаар авч үзвэл татварын орлого 10.6 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого

9.0 тэрбум төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого

Нийгмийн даатгалын санд 1666.4 тэрбум төгрөг төвлөрсний 1151.7 тэрбум төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн орлого байгаа бол дотоод хандив тусламжийн орлогоор 514.7 тэрбум төгрөгийг бүрдүүлжээ.

Төсвийн зарлагын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2018 оны 10 дугаар сарын байдлаар 8707.4 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 7177.6 тэрбум төгрөгийн буюу 82.4 хувийн, улсын төсвийн зарлага 6703.8 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 5637.6 тэрбум төгрөгийн буюу 84.1 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Хүснэгт 1.10

Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн зарлага	Жилийн төлөвлөгөө	2018 он 1-10 сар		
		*	**	**/*
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	9 975	8 707	7 177	82%
Урсгал зардал	7 641	6 476	5 842	90%
1. Бараа, үйлчилгээний зардал	3 427	2 924	2 526	86%
1.1. Цалин хөлс	1 876	1 558	1 501	96%
1.2. Нийгмийн даатгал	0	0	0	0%
1.3. Бараа, үйлчилгээний бусад	313	282	199	71%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	1 151	971	897	92%
3. Татаас	244	208	166	80%
4. Урсгал шилжүүлэг	2 819	2 371	2 251	95%
Хөрөнгийн зардал	2 048	1 905	1 045	55%
Эргэж төлөгдөх цэвэр зээл	287	326	289	89%
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-2 586	-2 619	-341	13%

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: *Төлөвлөгөө,

**Урьдчилсан гүйцэтгэл.

Үүнээс урсгал зардал 633.9 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 859.3 тэрбум төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Урсгал зардлын бараа үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд багтах цалин хөлс 57.4 тэрбум төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 83.5 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна. Бараа үйлчилгээний бусад зардлын дэлгэрэнгүй ангиллыг авч үзвэл бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 174.1 тэрбум, байр ашиглалттай холбоотой

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн орлого төлөвлөгөөнөөс 6 хувиар буюу 94 тэрбум төгрөгөөр илүү төвлөрчээ.

Эрүүл мэндийн даатгалын сан


Эрүүл мэндийн даатгалын санд 337.1 тэрбум төгрөг төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 9.2 хувиар буюу 28.5 тэрбум төгрөгөөр биелсэн үзүүлэлт боллоо.

зардал 27.9 тэрбум төгрөг, норматив зардал 26.3 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь энэхүү дутуу гүйцэтгэлийн дийлэнх хувийг эзэлж байна.

Бусад голлох зарлагын хувьд зээлийн үйлчилгээний төлбөр 73.6 тэрбум төгрөг, татаас 41.7 тэрбум төгрөг, урсгал шилжүүлэг 120.2 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна.

Дүрслэл 1.65

Нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: 2018 оны эхний 10 сарын орлого, зарлагын гүйцэтгэлийн жилийн өөрчлөлт болно.

Улсын болон орон нутгийн төсвийн зарлага


Улсын төсвийн зарлага 5364.4 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгийн 83.7 хувьтай тэнцүү гарлаа. Харин орон нутгийн төсвийн зарлага 2025.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 82.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн тэнцэл

2018 оны эхний 10 сард гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 228.2 тэрбум, гадаад бондын үндсэн төлбөрт 667.0 тэрбум төгрөгийг тус тус төлж, 574.9 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл авч, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 1670.8 тэрбум, гадаад бондын үндсэн төлбөрт 667.0 тэрбум төгрөгийг тус тус төлсөн байна. Тайлант хугацаанд Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцэл 1090.5 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 314.9 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Дүрслэл 1.66

Нэгдсэн төсвийн тэнцлийн гүйцэтгэл (жил бүрийн эхний 10 сарын байдлаар, тэрбум төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам.

Төсвийн эрсдэл, эмзэг байдал

Манай улс зэсийн баяжмал, нүүрс, цайрын баяжмал, төмрийн хүдэр, жоншны баяжмал зэрэг уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний экспортолж байна. Эдгээр бүтээгдэхүүний олборлолт, экспортоос улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого сүүлийн 5 жилд дунджаар авч үзвэл нэгдсэн төсвийн орлогын 20 гаруй хувийг бүрдүүлсэн байна. Дэлхийн зах зээл дээрх алт, зэс, нүүрсний үнийн хэлбэлзэл, экспортын бүтээгдэхүүний биет хэмжээнээс шалтгаалж, төсөвт төвлөрөх төсвийн орлого буурах, төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх эрсдэлийг үүсгэхээр байна.

Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл 2018 оны 3 дугаар улирлын эцэст 21,437.5 тэрбум төгрөгт хүрсэн ба үүнээс гадаад өр 17,497.7 тэрбум төгрөг буюу 81.6 хувь, дотоод өр 2,478.1 тэрбум төгрөг буюу 11.6 хувь, Засгийн газрын баталгаатай зээллэг 1,461.7 тэрбум төгрөг буюу 6.8 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 1.11

Засгийн газрын өр (тэрбум төгрөг)

Өрийн бүтэц, өрийн хэргэсэл	2015	2016	2017	2018Q3
I. Засгийн газрын дотоод өр	3 800	6 465	4 230	2 478
1.1 Үнэт цаас	3 333	5 489	3 462	1 826
1.2 Өрийн бичиг/вексель	164	307	0	0
1.3 Концесс	261	669	768	652
II. Засгийн газрын гадаад өр	7 881	12 364	16 858	17 498
2.1 Үнэт цаас	3 316	5 381	7 701.6	7 401.2
2.2 Зээл	4 565	6 983	9 156	10 097
III. Засгийн газрын өрийн баталгаа	2 744	3 452	1 664	1 462
3.1 Засгийн газрын өрийн баталгаа	2 744	3 452	1 664	1 462
Засгийн газрын нийт өр (I+II+III)	14 424.70	22 280.10	22 751.60	21 437.50
Засгийн газрын өр (ӨҮЦ)	12 124.20	18 861.00	20 212.10	18 373.70
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	58.3%	88.0%	85.0%	80.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	52.4%	78.8%	74.4%	60.0%*

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: *ДНБ-ий 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг ашигласан болно.

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 10,096.7 тэрбум төгрөг буюу 3,956.2 сая ам.доллар байгаа бөгөөд нийт гадаад зээлийн үлдэгдлийн 85.0 хувийг Япон, Бүгд Найрамдах Хятад ард улс, Азийн Хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг 4 том зээлдүүлэгчээс авсан хөнгөлөлттэй зээл эзэлж байна.

Хүснэгт 1.12**Гадаад зээлийн өрийн үлдэгдэл (тэрбум төгрөг)**

№	Зээлдүүлэгч	Дүн (тэрбум төгрөг)
1	Азийн хөгжлийн банк	2,897.40
2	Япон улс	2,694.30
3	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	1,530.50
4	Дэлхийн банк	1,463.80
5	Кредит свисс	551.30
6	Бусад	959.50
НИЙТ		10,096.70

Эх сурвалж: Сангийн яам.


Засгийн газрын зүгээс 2017 оны 3 дугаар сард Монгол Улсын Хөгжлийн банкны 580 сая ам.долларын бондын 82.07 хувь буюу 476 сая ам.долларыг Засгийн газрын 7 жилийн хугацаатай, 8.75 хувийн хүүтэй Хуралдай бондоор сольж, үлдэгдэл 124 сая ам.долларыг 7.625 хувийн зах зээлийн өгөөжтэйгөөр босгон хугацаанд нь төлж дуусгасан.

Мөн 2017 оны 10 дугаар сард гаргасан 800 сая ам.долларын 5.5 жилийн хугацаатай, 5.625 хувийн хүүтэй Гэрэгэ бондоор 2018 оны 1 дүгээр сард төлөгдөх хуваарьтай 500.0 сая ам.долларын Чингис бондын 74.5 хувь буюу 372.8 сая ам.доллар, 2018 оны 6 дугаар сард төлөгдөх хуваарьтай 1.0 тэрбум юанийн Дим сам бондын 9.5 хувийг тус тус буцаан худалдан авсан бөгөөд Чингис бондын үлдэгдэл 127.2 сая ам.доллар, Дим сам бондын үлдэгдэл 905.0 сая юанийн төлбөрийг 2018 онд төлж барагдуулсан.

Ингэснээр Засгийн газрын гадаад бондын үлдэгдэл 2017 оны жилийн эцэст 3,173.1 сая ам.доллар буюу 7,701.6 тэрбум төгрөг байсан бол 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 2,900.0 сая ам.доллар буюу 7,401.2 тэрбум төгрөг болж буурсан.

Засгийн газрын гадаад өртэй холбоотой дараах эрсдэлүүд тулгарч болзошгүй байна. Үүнд:

- ♦ **Гадаад валютын ханшийн эрсдэл:** Засгийн газрын гадаад өр болон Засгийн газрын баталгааны үлдэгдэл 2017 оны жилийн эцэст нийт өрийн багцын 81.4 хувь, 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 85.0 хувийг тус тус эзэлж байна. Энэ нь гадаад валютын ханшийн эрсдэлийг энэ хэмжээгээр нэмэгдүүлж, гадаад валютын ханшийн өсөлтөөс үүдэн төгрөгөөр илэрхийлсэн гадаад өрийн үлдэгдэл өсөх, гадаад өрийн үйлчилгээний зардлыг нэмэгдүүлж болзошгүй байна.
- ♦ **Өрийн дахин санхүүжилтийн эрсдэл:** Засгийн газрын зүгээс 2017 оны 3 дугаар сард төлөгдөх хуваарьтай байсан Монгол Улсын Хөгжлийн банкны 580.0 сая ам.долларын Евро бонд, 2018 онд төлөгдөх хуваарьтай Чингис бонд, Дим сам бондуудын төлбөрийг эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр амжилттай дахин санхүүжүүлсэн. Засгийн газрын зүгээс 2020 оныг хүртэл гадаад бондын томоохон төлбөргүй боловч 2021-2024 оны хооронд нийт 2,900.0 сая ам.долларын бондын төлбөр төлөгдөхөөр байгаа нь өрийн дахин санхүүжилтийн эрсдэл эдгээр онуудад өндөр байгааг харуулж байна.

Дүрслэл 1.67**Бондын эргэн төлөлт**

Эх сурвалж: Сангийн яам.

2018 оны 10 дугаар сарын байдлаар Засгийн газрын дотоод бондын үндсэн төлбөрт 1,670.8 тэрбум төгрөг, гадаад бондын үндсэн төлбөрт 667.0 тэрбум төгрөг (Чингис бонд, Дим сам бонд), гадаад зээлийн үндсэн төлбөрт 228.2 тэрбум төгрөг, нийт 2,566.1 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг төлөөд байна. Гадаад зээл, бондын хүүгийн төлбөрт 2018 оны 10 дугаар сарын байдлаар 592.8 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасны хүүгийн төлбөрт 304.7 тэрбум төгрөг, нийт 897.4 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөрийг төлөөд байгаа бөгөөд энэ нь нэгдсэн төсвийн урсгал зарлагын 15.4 хувийг эзэлж байна.

САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ДАРХЛАА

2.1 БАНКНЫ САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ


БАНКНЫ САЛБАР

Ерөнхий төлөв байдал

Банкны салбарт 2018 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар 14 банк 1509 салбар нэгж, 15925 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо давхардсан тоогоор 8.9 сая, зээлдэгчдийн тоо 1.2 саяд хүрлээ.

Дүрслэл 2.1

Банкны салбарын активын бүтэц (жил бүрийн 10 сарын байдлаар)




Эх сурвалж: Монголбанк.

Банкны салбарын нийт активын хэмжээ 2018 оны 10 дугаар сарын эцэст 31.0 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 11.7 хувиар буюу 3.3 их наяд төгрөгөөр нэмэгджээ. Нийт активын бүтцийг авч үзвэл 46.7 хувийг зээл, 21.0 хувийг мөнгөн хөрөнгө, 13.4 хувийг Төв банкны үнэт цаас, 4.9 хувийг Засгийн газрын үнэт цаас үлдэх 14.0 хувийг бусад хөрөнгө бүрдүүлж байна. Банкны салбарын активын бүтцийн гол өөрчлөлтийг харвал зээлийн өсөлт сүүлийн саруудад эргэн сэргэх хандлагатай байна.

Түүнчлэн Засгийн газрын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.9 их наяд төгрөгөөр буурсан нь Засгийн газраас хэрэгжүүлж буй өрийн тэнцвэртэй байдлыг хангах бодлоготой холбоотой. Үүнтэй зэрэгцэн банкууд Төв банкны үнэт цаасанд оруулах нь нэмэгдэж ТБҮЦ-ны хэмжээ 2.2 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дүрслэл 2.2

Банкны салбарын пассивын бүтэц (жил бүрийн 10 сарын байдлаар)




Эх сурвалж: Монголбанк.

Банкны салбарын нийт эх үүсвэрийн хэмжээ 2018 оны 10 дугаар сарын эцэст 28.1 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 15.3 хувиар өсжээ. Эх үүсвэрийн өсөлтөд банкнуудын иргэдээс татан төвлөрүүлсэн харилцах 39.4 хувиар, хадгаламж 20.3 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Дүрслэл 2.3

Банкны салбарын актив, пассивт гарсан өөрчлөлт (2017.10-2018.10)



Эх сурвалж: Монголбанк.


Эх үүсвэр

Банкны салбарын нийт эх үүсвэрийн 65.8 хувийг иргэд аж ахуй нэгж, төрийн байгууллагуудаас татсан харилцах, хадгаламж, 18.6 хувийг банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, үлдэх 15.6 хувийг төслийн санхүүжилт, банкнаас гаргасан үнэт цаас зэрэг бусад төрлийн эх үүсвэрүүд бүрдүүлж байна.

Монголбанкнаас мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн санхүүжилт болон харилцах хадгаламжийн тогтвортой өсөлттэй холбоотойгоор эх үүсвэрийн хэмжээ 2013 онд өсч байсан хэдий ч 2014 оноос хойш өсөлтийн хурд эргэн буурч, 2015 оны 1 дүгээр сард сөрөг утгатай болсон. Харин 2016 оноос эхлэн өсөлтийн хурд сэргэж, 2018 оны 4 дүгээр сарын байдлаар нийт пассивын жилийн өсөлт 15.2 хувьтай байна.

Дүрслэл 2.4

Банкны салбарын эх үүсвэрийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк.


Нийт хадгаламжийн хэмжээ 12.9 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд хадгаламжийн 66.5 хувийг хугацаагүй хадгаламж, 26.2 хувийг 1 жил хүртэлх хугацаатай хадгаламж, 14.2 хувийг 1 жилээс дээших хугацаатай хадгаламж бүрдүүлж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн 93.5 хувь нь 5 сая төгрөг хүртэлх дүнтэй хадгаламж эзэмшдэг байна.

Зээл

Зээлийн өсөлт эргэн сэргэх хандлагатай байна. Банкны салбарын зээлийн өсөлт тайлант сард 21.4 хувь хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13.7 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. Зээлийн өсөлт ийнхүү сайжрахад нэг талаас эдийн засгийн идэвхжил сэргэсэн, нөгөө талаас 2017 онд зээл олголт бууралттай байсан зэргээс шалтгаалжээ. Түүнчлэн 2017 оны II хагасаас банкуудын зээлийн өсөлтийн ихэнх хэсгийг иргэдэд олгосон зээл бүрдүүлж байна. Тухайлбал, тайлант сард зээлийн өсөлт 23.5 хувь хүрсний 14.2 нэгж хувийг иргэдэд олгосон зээлийн өсөлт, 9.3 хувийг аж ахуй нэгж, байгууллагад олгосон зээлийн өсөлт бүрдүүлж байна. Дээрх статистикаас харахад банкнууд бизнесийн зээлээс илүүтэйгээр цалин, тэтгэвэр, бусад хэрэглээний шинж чанартай зээлийг илүү түлхүү олгож байна.

Дүрслэл 2.5

Зээлийн өсөлтөд иргэдийн болон байгууллагын зээлийн өсөлтийн эзлэх хувь




Эх сурвалж: Монголбанк.

Санхүүгийн салбарын зээлийн багцын дийлэнх хувийг бүрдүүлдэг банкны салбарын зээлийн өсөлт эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн, санхүүгийн зах зээлийн нөхцөл чангарсан, эдийн засгийн идэвхжил удааширснаар банкнууд шинээр зээл олгох нь эрсдэлтэй гэж үзэн зээлээ хумьсан зэргээс шалтгаалан 2014 оны 2 дугаар сараас тасралтгүй буурч эхэлсэн.

Дүрслэл 2.6

Банкны салбарын актив, зээлийн жилийн өсөлт




Эх сурвалж: Монголбанк.

Улмаар 2015 оны 5 дугаар сараас 2016 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд банкны салбарын зээлийн жилийн өөрчлөлт сөрөг утгатай байсан бол 2016 оны 6 дугаар сараас эхлэн өсч, 2018 оны 10 дугаар сарын байдлаар 22.8 хувьд хүрээд байна.

Дүрслэл 2.7

Олгосон зээлийн жилийн өсөлт (салбараар)




Эх сурвалж: Монголбанк.

Нийт зээлийг салбарын ангиллаар авч үзвэл уул уурхай олборлолтын салбарт олгосон зээлийн өсөлт 2018 оны эхний 3 улирлын байдлаар өмнөх оны дүнгээс буурсан бол бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл, болон бусад салбарт олгосон зээлийн өсөлт нэмэгджээ.

Дүрслэл 2.8

Салбаруудын зээлийн төвлөрөл



Голлох салбарууд	Зээлийн өрийн үлдэгдэл (2018M10)	Оны эхнээс гарсан өөрчлөлт
Бөөний/жижиглэн худалдаа	14.8%	1.0%
Үл хөдлөх хөрөнгө	11.5%	-2.6%
Барилга	9.3%	-0.1%
Боловсруулах үйлдвэрлэл	8.9%	-1.3%
Уул уурхай, олборлолт	7.4%	-0.2%
Бусад	48.0%	3.1%

Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *Зээлийн багцад хамгийн өндөр жин эзэлж буй 4 салбарын зээлийн нийт дүнд эзлэх хувь.


Банкны салбарын зээлийн төвлөрөл харьцангуй буурч байна. Зээлийн бүтцийг харвал нийт зээлийн 52.0 хувийг иргэдэд олгосон хэрэглээний болон орон сууцны

ипотекийн зээл бүрдүүлж байгаа бол уул уурхай, боловсруулах үйлдвэр, бөөний болон жижиглэнгийн худалдаа, барилга зэрэг эдийн засгийн голлох салбаруудад олгосон зээл 40.6 хувийг бүрдүүлж байгаа нь эдийн засгийн идэвхжлийн үетэй харьцуулахад буурсан байна.

Түүнчлэн банкны салбарын зээл олголтын статистикаас харахад шинээр олгосон зээлийн 44.4 хувийг хэрэглээний, 24.9 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээл бүрдүүлж байна. Эдгээр төрлийн зээл олголтын хэмжээ харьцангуй өндөр байгаад нэг талаас уг салбаруудад олгосон зээлийн эргэн төлөлт сайн, нөгөө талаас зээлийн эрэлт хэрэгцээ өндөр байгаа нь голлон нөлөөлсөн гэж үзэж байна.

Дүрслэл 2.9

Зээлийн чанарын үзүүлэлт, салбараар



Голлох салбарууд	Тухайн салбарын чанаргүй зээл/Нийт чанаргүй зээл (2018M10)
Боловсруулах үйлдвэрлэл	23.3%
Уул уурхай, олборлолт	17.8%
Барилга	14.7%
Бөөний болон жижиглэн худалдаа	11.3%
Үл хөдлөх хөрөнгө	7.8%
Бусад	25.1%

Эх сурвалж: Монголбанк.

2018 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ 2.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.1


²⁸ 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Активыг ангилх,

дахин, өмнөх улирлаас 85.4 хувиар өслөө. Ингэснээр зээлийн чанарын гол үзүүлэлтүүд болох чанаргүй зээл, нийт зээлийн харьцаа (чанаргүй зээлийн хувь) 12.8 хувьд хүрчээ. Түүнчлэн тайлант сарын эцсийн байдлаар анхаарал хандуулах²⁸ зээлийн хэмжээ 1.0 их наяд төгрөгт хүрч 11.1 хувиар буурч, анхаарал хандуулах зээлийн хувь 6.1 хувьд хүрээд байна. Анхаарал хандуулах зээлийн хэмжээ ийнхүү буурсан нь эдгээр зээлүүдээс ангилал буурч чанаргүй ангилалд шилжсэн нь нөлөөлжээ.

Зээлийн чанар ийнхүү муудахад эдийн засгийн голлох салбарууд болох барилга, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олгосон зээлийн чанар муудсан нь голлон нөлөөлжээ. Зээл олгосон салбаруудаас барилгын салбарт олгосон нийт зээлийн 28.3 хувь нь анхаарал хандуулах ангилалд байгаа нь цаашид уг салбарын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх эрсдэлтэй байгааг харуулж байна.

Дүрслэл 2.10

Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн жилийн өсөлт



Голлох салбарууд	Нийт чанаргүй зээл ба анхаарал хандуулах зээлд эзлэх хувь (2018M10)
Барилга	24.6%
Уул уурхай, олборлолт	17.4%
Боловсруулах үйлдвэрлэл	14.7%
Бөөний болон жижиглэн худалдаа	10.2%
Үл хөдлөх хөрөнгө	6.9%

Эх сурвалж: Монголбанк.


активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах шинэчилсэн журмаар “хугацаа хэтэрсэн” зээлийн нэршил “анхаарал хандуулах” болж өөрчлөгдсөн.

Харин иргэдэд олгосон хэрэглээний болон орон сууцны ипотекийн зээл, бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлийн эргэн төлөлт харьцангуй сайн, зээлийн чанарын үзүүлэлт системийн дундаж (12.8 хувь)-аас харьцангуй сайн байна.

Зээлийн чанарыг олгосон валютаар нь зэрэгцүүлэн авч үзвэл үндэсний валют болох төгрөгөөр олгосон чанаргүй зээлийн нийт төгрөгийн зээлд эзлэх хувь 11.5 хувь байхад гадаад валютаар олгосон зээлийн нийт валютын зээлд эзлэх хувь 18.1 хувь буюу 6.6 нэгж хувиар өндөр байна.

Дүрслэл 2.11

Чанаргүй зээлийн харьцаа (валютын төрлөөр)




Эх сурвалж: Монголбанк.

Өөрийн хөрөнгө

Банкны салбарын зээлийн чанар муудсантай холбоотойгоор өөрийн хөрөнгийн хэмжээ буурч, эрсдэл даах чадварыг харуулдаг өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүд буурч байна. 2018 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2.8 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 их наяд төгрөгөөр буурсан байна. Зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тооцоход суурь болдог эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ 18.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Дүрслэл 2.12

Өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд



Эх сурвалж: Монголбанк.

Өөрөөр хэлбэл, банкнуудын эрсдэл бүхий актив хөрөнгө нэмэгдсэн хэдий ч эрсдэлийг даах чадвар бүхий өөрийн хөрөнгийн хэмжээ нь буурсан байна. Ингэснээр банкны салбарын нэгдүгээр зэрэглэлийн болон нийт өөрийн хөрөнгийн харьцаа 9.3 хувь, 13 хувьд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 3.9 хувь, 4.5 хувиар буурсан байна.


Ашигт ажиллагаа

2018 оны эхний 11 сарын байдлаар банкны салбарын цэвэр алдагдлын хэмжээ 359.8 тэрбум төгрөгт хүрээд байна. Тайлант оны эхний 6 сард банкны салбар ашигтай (126.5 тэрбум төгрөг) ажиллаж байсан хэдий ч зээлийн чанар муудсанаас шалтгаалан зээлийн эрсдэлийн сангийн зардал нэмэгдсэн нь ашигт ажиллагаа муудахад нөлөөлжээ.

Тайлант сарын эцэст зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 1.6 их наяд төгрөгт хүрч, оны эхнээс нийт 747.9 тэрбум төгрөгийн сан байгуулжээ. Улмаар ашигт ажиллагааны голлох үзүүлэлтүүд болох активын болон өөрийн хөрөнгийн өгөөж -1.4, -18.0 хувьд хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 2.3, 26.2 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Дүрслэл 2.13

Банкны салбарын ашигт ажиллагаа




Эх сурвалж: Монголбанк.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа тогтвортой байна. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нь банкны салбарын тогтвортой байдлыг илтгэдэг чухал үзүүлэлтүүдийн нэг бөгөөд харилцагчийн анхны шаардлагаар төлбөрийг түргэн гүйцэтгэх чадварыг илэрхийлдэг.

Дүрслэл 2.14

Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар




Эх сурвалж: Монголбанк.

Банкны системийн хэмжээгээр уг харьцаа 41.0 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон доод хязгаарлалтаас 16.0 нэгж хувиар өндөр, өмнөх жилийн мөн үетэй (42.2 хувь) харьцуулахад харьцангуй тогтвортой байна.

Дүрслэл 2.15

Хөрвөх чадварын үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: * (Банкны нөөц+ТБҮЦ)/(Харилцах+Хадгаламж).

** (Банкны нөөц+ТБҮЦ+ЗГ-ын богино хугацаатай үнэт цаас)/(Харилцах+Хадгаламж).

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар хэвийн байхад банкнууд татан төвлөрүүлсэн эх үүсвэрээ харьцангуй эрсдэл багатай Төв банкны болон Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулж байгаа нь голлон нөлөөлжээ. Түүнчлэн банкнуудын нийт гадаад валютын позицод тавигддаг зохистой харьцааны үзүүлэлт -12.6 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон хязгаарлалт (+/-40.0 хувь) дотор байна.

2018 оны 10 дугаар сарын байдлаар банкнуудын Засгийн газрын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.9 их наяд төгрөгөөр буурсан бол ТБҮЦ-ны хэмжээ 2.2 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна.

МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Монголбанк санхүүгийн системийн эрсдэлийг бууруулах, гадаад нөлөөнөөс хамаарсан эдийн засгийн мөчлөгийн далайцыг багасгах зорилгоор санхүүгийн системийн эмзэг байдлыг шинжилж, шаардлагатай тохиолдолд макро зохистой бодлогын хэрэгслүүдийг мөнгөний бодлоготой хослуулан ашиглаж байна.

Хэрэглээний зээл сүүлийн жилүүдэд хурдтай өсч, өрхийн өрийн дарамт нэмэгдэх гол эх сурвалж болж байна. Ажлын байр нэмэгдэж, өрхийн орлого төдийлөн хурдтай нэмэгдээгүй үед өрхийн зээл, өр эрчимтэй нэмэгдэх нь хэрэглээгээр дамжин богино хугацаанд эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх боловч дунд, урт хугацаанд эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, өсөлтөд сөрөг нөлөө үзүүлдэг нь цөөнгүй улс орнуудын туршлагаас харагддаг. 2017 оны эцэст банкнуудад хийсэн газар дээрх шалгалтын үр дүнд цалин, тэтгэвэр, бусад хэрэглээний зээлд тогтоосон тодорхой зохицуулалт байхгүй тул банкнууд зээлдэгчийн өр, орлогын харьцааг өндрөөр тогтоож, зээлийн хугацааг сунгах замаар зах зээлд өрсөлдөх тохиолдол олон байна. Цаашид эдийн засгийн идэвхжил нэмэгдэж иргэдийн орлого өсөхөд банкнууд цалин, тэтгэвэр, хэрэглээний бусад зээл олгохдоо орлогын 100 хувь хүртэл өсгөж, улмаар өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг хөөрөгдөх, эдийн засгийн мөчлөгийн далайцыг нэмэгдүүлж, зээлийн хэт өсөлт, эдийн засгийн хэт халалтын эрсдэлийг бий болгож, инфляци, төлбөрийн тэнцлийн дарамтыг үүсгэх эрсдэлтэй байна. Иймд мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, санхүүгийн секторын дархлааг сайжруулах, макро тогтвортой байдлыг хангах, өрхийн санхүү, хэрэглээний тогтвортой байдлыг хамгаалах зорилгоор 2019

оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн банкнаас иргэдэд шинээр олгох, нөхцөлийг нь өөрчлөх цалин, тэтгэвэр, хэрэглээний бусад зээлийн хувьд өр, орлогын харьцааг 70 хувиар хязгаарлах шийдвэрийг Мөнгөний бодлогын хороо 2018 оны 6 дугаар сард гаргасан. Энэхүү бодлогын арга хэмжээний үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор 9 дүгээр сарын Мөнгөний бодлогын хорооны хурлаар эдгээр зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байхаар тогтоолоо.

Түүнчлэн, зээлийн долларжилт түүхэн дундажтай харьцуулахад нам түвшинд байгаа боловч гадаад валютын орлогогүй иргэд, ААН-үүдэд олгосон валютын зээлийн хэмжээ өндөр дүнтэй байна. Гадаад орчны нөлөөгөөр төгрөгийн ханш сулрахад эдгээр зээлдэгчдийн өрийн дарамт нэмэгдэж, зээл чанаргүйдэх, улмаар банкны системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Иймд зээлийн долларжилтыг бууруулах, гадаад валютын орлогогүй иргэн, ААН-д гадаад валютаар зээл олгох сэдлийг бууруулах зорилгоор ханшийн эрсдэлтэй зээлдэгчдэд олгосон гадаад валютын зээлийн эрсдэлийн жинг 120 хувиас 150 хувь болгон нэмэгдүүлж, 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхээр 2018 оны 9 дүгээр сарын Мөнгөний бодлогын хорооны хурлаар шийдвэрлэсэн. Энэхүү арга хэмжээний үр дүнд банкнуудын зээлийн долларжилт буурч, санхүүгийн систем дэх ханшийн эрсдэл буурах нэг нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛ

Ерөнхий төлөв байдал

Хадгаламжийн даатгалын тогтолцоо нь олон улсад шалгарсан, түгээмэл хэрэглэж байгаа даатгалын тогтолцоо бөгөөд банк, санхүүгийн салбарыг системийн хямралаас тодорхой хэмжээгээр сэргийлэх, жижиг хэмжээний хадгаламж эзэмшигчдийг хамгаалахад чиглэгддэг.

УИХ-аас 2013 онд банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоох зорилгоор “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийг баталсан бөгөөд 2018 онд тус хуулинд нэмэлт өөрчлөлт оруулаад байна.

Хүснэгт 2.1

Нийт харилцах, хадгаламжийн даатгагдсан байдал

	Данс эзэмшигчид		Дансны үлдэгдэл	
	Мян.ш	Хувь	Тэрбум төг	Хувь
Даатгалд хамрагдсан	6 029	99.8%	4 854	24%
Даатгалд хамрагдаагүй	9	0.2%	15 570	76.0%
Нийт	6 038	100.0%	20 424	100%

Эх сурвалж: Хадгаламжийн даатгалын корпораци.


2018 оны 10 дугаар сарын байдлаар банкны систем дэх нийт 6.0 сая харилцах, хадгаламжийн данс эзэмшигч, 20.4 их наяд төгрөгийн дансны үлдэгдэл байгаа ба эдгээрийн харгалзан 99.8 хувь, 24 хувь нь хадгаламжийн даатгалд хамрагдаж байна.

Хадгаламжийн даатгалын хураамжийн орлого

Хадгаламжийн даатгал нь банкнуудын хадгаламжаас тогтмол хувь хэмжээгээр хураамж авч хуримтлуулан банкинд хүндрэл үүссэн үед тус хуримтлалаас харилцагчдын мөнгийг олгодог тогтолцоо юм.

Дүрслэл 2.16

Даатгалын хураамжийн орлого



Эх сурвалж: Хадгаламжийн даатгалын корпораци.

Хадгаламжийн даатгалын хураамж нь эхлэлтийн, улирлын болон онцгой гэсэн 3 төрөлтэй байдаг. Хуульд зааснаар эхлэлтийн хураамж нь тухайн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний нэг хувьтай тэнцүү, онцгой хураамжийн дүн нь даатгагдах харилцах, хадгаламжийн 0.5 хувиас хэтэрдэггүй бөгөөд харин улирлын хураамжийн хувийг тухайн банкны эрсдэлийн түвшингээс хамааруулан тогтсон аргачлалын дагуу тооцдог.

ХДК 2013 оноос хойш 2018 оны 11 дүгээр сар хүртэлх хугацаанд банкны системийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны 14 банкнаас нийт 188.4 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлогыг татан төвлөрүүлжээ.

Хадгаламжийн даатгалын сан

Хадгаламжийн даатгалын сан нь эхлэлтийн хөрөнгө, хадгаламжийн даатгалын хураамж болон хөрөнгө оруулалтын орлогоос бүрдэх бөгөөд эхлэлтийн хөрөнгийг Монголбанк, Сангийн яамнаас бүрдүүлсэн байдаг бол сангийн хөрөнгийг нэмэгдүүлдэг гол орлого нь хураамж болон хөрөнгө оруулалтын орлого юм.

Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгийн хэмжээ жил бүр өсөн нэмэгдсээр 2018 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар 397.9 тэрбум төгрөгт хүрээд байна.

Хүснэгт 2.2

Сангийн хөрөнгийн бүтэц (2018 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар)

Сангийн бүтэц	2013	2014	2015	2016	2017	2018	Нийт
Монголбанкнаас оруулсан	50.0	-	-	-	-	-	50.0
Засгийн газраас оруулсан хөрөнгө	35.0	7.2	-	-	-	-	42.2
Хөрөнгө оруулалтын орлого	1.7	14.3	23.5	30.0	40.6	22.7	135.4
Хураамжийн орлого	19.2	33.2	27.4	31.6	36.1	42.9	190.3
Хадгаламж банкны ЭХА	2.6	1.5	1.5	0.1	5.5	-	11.2
Нийт зардал	0.4	2.3	2.8	3.8	4.8	5.8	20.0
Нийт дүн	105.5	52.3	48.1	57.8	71.9	62.4	397.9

Эх сурвалж: Хадгаламжийн даатгалын корпораци.

Өнөөг хүртэл хадгаламжийн даатгалын сангийн бүрдүүлэлтийн гол хэсгийг

хураамжийн орлого бүрдүүлсэн хэвээр байгаа боловч цаашид өсөлт нь тогтворжиж, хөрөнгө оруулалтын орлогын өсөлтийн эзлэх хувь нэмэгдэх хандлагатай байна. 2015 оны эцэст хадгаламжийн даатгалын санд эзлэх хөрөнгө оруулалтын орлого 19 хувьтай байсан бол энэ харьцаа 2016 оны эцэст 26 хувь, 2017 онд 33 хувь, 2018 оны 10 дугаар сарын байдлаар 34 хувь болж өсчээ.

2.2 БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО


Банк бус санхүүгийн байгууллагын өнөөгийн байдал

Ерөнхий төлөв байдал

2018 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 540 ББСБ Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Дүрслэл 2.17

Бүртгэлтэй банк бус санхүүгийн байгууллагын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо 2013 оноос хойш эрчимтэй өсөж байсан бол сүүлийн жилүүдэд өсөлт нь харьцангуй саарах хандлагатай байна. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар өсчээ.

ББСБ-уудын 2017 оны жилийн эцэс болон 2018 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг хүснэгт 2.3-т хураангуйлан харууллаа.

Хүснэгт 2.3

Банк бус санхүүгийн байгууллагын голлох статистик үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2017	2018Q3
1	ББСБ-ын тоо	534	540
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	1 039	5 716
3	Ажиллагсдын тоо	2 473	2 642
4	Салбар нэгжийн тоо	164	206
5	Харилцагчдын тоо	1 471 099	1 510 263
6	Нийт актив	969.2	1202.0
	Банкны салбарт эзлэх хувь	3.4%	3.9%
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	638	811.6
	Банкны салбарт эзлэх хувь	4.7%	4.8%
8	Нийт эзэмшигчдийн өмч	758.2	932.0
	Банкны салбарт эзлэх хувь	24.1%	30.1%
9	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	39.2	48.8
10	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл	112.8	135.6
	Үүнээс:		
	Богино хугацаат зээл	65.1	72.1
	Урт хугацаат зээл	47.7	63.5
11	Төслийн зээлийн санхүүжилт	14.9	16.9
12	Нийт орлого	195.9	183.9
13	Нийт зардал	129.1	110.4
14	Тайлант үеийн ашиг	66.8	73.5

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт 540 ББСБ-ын 90.9 хувь нь зээл, 28.3 хувь нь гадаад валютын арилжаа, 5.7 хувь нь хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 4.3 хувь нь цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 3.9 хувь нь факторингийн үйлчилгээ, 3.3 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 5.4 хувь нь итгэлцлийн үйлчилгээ, 1.7 хувь нь богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхлэн явуулж байна.

Хүснэгт 2.4

Банк бус санхүүгийн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл

№	Үйл ажиллагааны нэр төрөл	2017	2018Q3
1	Зээл	482	491
2	Гадаад валютын арилжаа	145	153
	Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	49	49
3	Итгэлцлийн үйлчилгээ	28	29
4	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	31	31
5	Факторингийн үйлчилгээ	21	21
6	Төлбөрийн баталгаа гаргах	16	18
7	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	15	23
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	7	9
9	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	2	3
	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	0	0


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт хөрөнгө

2018 оны 3 дугаар улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 32.7 хувиар өсөж 1202.0 тэрбум төгрөгт хүрсний 1155.4 тэрбум төгрөг нь эргэлтийн хөрөнгө байна.

Дүрслэл 2.18

Банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.


Зээлийн чанар

2018 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар зээлийн багц нийт хөрөнгийн 67.5 хувь буюу 811.6 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны

жилийн эцсээс 27.2 хувиар өссөн дүнтэй байна. Энэхүү өсөлтийн 25.6 нэгж хувь нь хэвийн зээлийн өсөлт, 0.9 нэгж хувь нь хугацаа хэтэрсэн зээлийн өсөлт, 0.7 нэгж хувь нь чанаргүй зээлийн өсөлтөөр тайлбарлагдаж байна.

Дүрслэл 2.19

Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн чанар (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

2018 оны 3 дугаар улиралд чанаргүй зээлийн хэмжээ 85.7 тэрбум төгрөгт хүрэв. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2017 оны жилийн эцсээс 2.1 нэгж хувиар буурч 10.6 хувьд хүрсэн. Энэ нь банкны салбартай харьцуулахад 2.3 нэгж хувиар өндөр байгаа юм²⁹. Эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй сайжирч банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн чадавх нэмэгдсэн, зах зээл дэх банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн нийлүүлэлт өссөн, зээлийн жигнэсэн дундаж хүүгийн түвшин буурсан зэрэг эерэг өөрчлөлтүүд чанаргүй зээлийн хэмжээ буурахад нөлөөллөө.

Зээлийн хүү


2018 оны 3 дугаар улиралд ББСБ-уудын зээлийн жигнэсэн дундаж хүү 3.3 хувьтай байсан бол ББСБ-ын зээлийн хүүг банкны

²⁹ Банкны салбарын чанаргүй зээл болон нийт зээлийн харьцаа 2018 оны 9 дүгээр сард 8.3 хувь байсан.

зээлийн хүүтэй харьцуулахад хүүний зөрүү сарын 1.8 хувь байв.

Дүрслэл 2.20

Банк ба ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү (%)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт эх үүсвэр ба Эзэмшигчдийн өмчийн бүтэц

Эзэмшигчдийн өмчийн 2018 оны 3 дугаар улирлын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.0 хувиар өссөн байна. 2017 оны эцсийн байдлаар нийт эх үүсвэрийн 21.8 хувийг өр төлбөр, 78.2 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2018 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар нийт өр төлбөр 22.5 хувь, эзэмшигчийн өмч 77.5 хувь болж өөрчлөгдсөн.

Хүснэгт 2.5

Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн голлох үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2013	2014	2015	2017	2018Q3
Нийт актив	381.1	508.0	623.2	969.2	1 202.0
Нийт зээлийн өрийн үлдэгдэл	223.7	303.1	391.2	638.0	811.6
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	381.1	508.0	623.2	969.2	1 202.0
Нийт өр төлбөр	146.8	175.9	198.0	211.0	270.0
Эзэмшигчдийн өмч	234.3	332.1	424.2	758.2	932.0
Үүнээс:					
Хувьцаат капитал	183.7	258.2	308.4	595.4	725.6
Бусад өмч	7.2	7.2	12.0	6.6	9.2
Сангууд	0.2	0.2	0.3	0.4	0.6
Хуримтлагдсан ашиг/алдагдал	41.7	64.0	102.1	155.1	195.6
Хоёрдогч өглөг	1.6	2.4	1.4	0.7	1.0
Нийт орлого	106.6	132.9	156.1	195.9	183.9
Нийт зарлага	76.8	96.5	109.7	129.1	110.4
Татварын дараах цэвэр ашиг	29.8	36.36	46.4	66.8	73.5

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Санхүүгийн зохицуулах хорооноос ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг

нэмэгдүүлэх шийдвэр гарган хэрэгжүүлж байгаа ба 2018 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар хувь нийлүүлсэн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 149.7 тэрбум төгрөгөөр буюу 26.0 хувиар өссөн байна.

Орлого, зарлага, ашигт ажиллагаа

Тайлант хугацаанд ББСБ-ын салбар нийт 183.9 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 32.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт орлогын 84.6 хувийг хүүгийн орлого, 12.2 хувийг хүүгийн бус орлого тус тус эзэлж байна. Харин ашигт ажиллагааны гол үзүүлэлт болох активын өгөөж (ROA) 2018 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар 8.9 хувь байна.

Хүснэгт 2.6

Орлого, зарлага, ашигт ажиллагаа (тэрбум төгрөг)

№	Үзүүлэлтүүд	2018Q3
1	Нийт орлого	183.9
	Хүүгийн орлого	155.5
	Хүүгийн бус орлого	22.4
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	6.0
2	Нийт зардал	110.4
	Хүүгийн зардал	14.4
	Хүүгийн бус зардал	67.1
	Болзошгүй эрсдэлийн зардал	17.8
3	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	2.3
	Орлогын татварын зардал	8.9
4	Татварын дараах цэвэр ашиг	73.5

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлт

Тусгай зөвшөөрөл эзэмшигч ББСБ-ын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 147 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын дагуу системийн түвшинд тооцож, үр дүнг хүснэгт 2.7-д харууллаа.

Хүснэгт 2.7**ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлтүүд**

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	470	87%
2	Нэг зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	51	9.4%
3	Хоёр зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	13	2.4%
4	Гурван зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	4	0.7%
5	Дөрвөн зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	1	0.2%
6	Тав ба түүнээс дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	1	0.2%
нийт		540	100%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

2018 оны 3 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 540 ББСБ-ын 87.0 хувь нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан бол 9.4 хувь нь 1 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 2.4 хувь нь 2 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 0.7 хувь нь 3 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 0.2 хувь нь 4 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 0.2 хувь нь 5-аас дээш харьцаа үзүүлэлтийг хангаагүй ажилласан байна.


ББСБ-ын эмзэг байдал

ББСБ-ын эрсдэл, тогтворгүй байдлыг чанаргүй зээлийн харьцаа ба Z индекс гэсэн 2 аргаар голчлон тооцдог.

ББСБ нь олгосон зээлийг хугацаа, чанар, эргэж төлөгдөх магадлалыг нь харгалзан ангилах замаар зээлийн эрсдэлийн санг тооцож байгуулдаг. Санхүүгийн зохицуулах хорооноос зээлийн эрсдэлийн санг байгуулах хувь хэмжээг зээлийн ангилал тус бүр дээр тогтоож өгсөн байдаг. Тухайн ББСБ байгуулбал зохих эрсдэлийн сангаа байгуулсан эсэхээс нь хамааран ББСБ чанаргүй зээлээ нөхөх, эрсдэлээс хамгаалах чадвартай эсэхийг нь тодорхойлдог.


ББСБ-ын салбарын хувьд 2018 оны 3 дугаар улиралд уг харьцаа 98.6 хувь гарсан буюу байгуулбал зохих эрсдэлийн санг бүрэн

байгуулж чадаагүй, эрсдэлийг 98.6 хувиар нөхөх чадамжтай байна.

Дүрслэл 2.21**Байгуулбал зохих болон байгуулсан эрсдэлийн сан /хувиар/**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Z индекс нь банк бус санхүүгийн байгууллагын дампуурах магадлалыг харуулдаг ба активын өгөөж болон өөрийн хөрөнгийн харьцааны нийлбэрийг активын өгөөжийн хэлбэлзэлд харьцуулж тооцдог.

Дүрслэл 2.22**Z индекс ба өгөөжийн стандарт хазайлт**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Z индексийн утга ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хөшүүрэг өндөр байх үед их гарах ба өгөөжийн хэлбэлзэл ихтэй үед буюу орлогын тодорхойгүй байдал их үед бага гарна. Өөрөөр хэлбэл индексийн их утга нь эрсдэл багатай, тогтвортой байдлыг илэрхийлдэг. ББСБ-ын салбарын Z индекс өмнөх оны жилийн эцсээс буурсан үзүүлэлттэй байна.


Хадгаламж, зээлийн хоршооны өнөөгийн байдал

Ерөнхий төлөв байдал

2018 оны 3 дугаар улирлын байдлаар 288 Хадгаламж, зээлийн хоршоо СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Дүрслэл 2.23

Хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Хадгаламж, зээлийн хоршоодын активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.8 хувиар өсөж 192.3 тэрбум төгрөгт хүрэв.

Хүснэгт 2.8

Хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2018Q3
1	ХЗХ-дын тоо	288
2	Гишүүдийн тоо	61 881
3	Нийт актив	192.3
	Банкны салбарт эзлэх хувь	0.6%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	142.2
	Банкны салбарт эзлэх хувь	0.8%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	6.2
	Банкны салбарт эзлэх хувь	0.5%
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	134.5
	Банкны салбарт эзлэх хувь	1.2%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл	15.2
	Банкны салбарт эзлэх хувь	0.5%
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	16.8
9	Бусад өр төлбөр	11.5
10	Нийт орлого	29.8
11	Нийт зардал	25.6
12	Тухайн үеийн ашиг, алдагдал	4.1


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Зээлийн чанар

Тайлант хугацаанд нийт зээлийн багцын 91.8 хувийг хэвийн, 3.8 хувийг хугацаа хэтэрсэн, 4.4 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өсөж 4.4 хувьд хүрчээ.

Дүрслэл 2.24

Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Өр төлбөр ба өөрийн хөрөнгө

ХЗХ-дын өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.4 тэрбум төгрөг буюу 15.9 хувиар өссөн бол өр төлбөрийн хэмжээ 45.1 тэрбум төгрөг буюу 39.2 хувиар өсчээ.

Дүрслэл 2.25

Хадгаламж, зээлийн хоршоодын өр төлбөр ба өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 134.5 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 69.9 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 132.1 тэрбум төгрөг буюу 98.3 хувь нь хугацаатай хадгаламж бол 2.3 тэрбум төгрөг буюу 1.7 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

Ашигт ажиллагаа


2018 оны 3 дугаар улиралд ХЗХ-дын нийт орлого 29.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 7.5 тэрбум төгрөг буюу 33.9 хувиар өссөн бол нийт зардал 25.6 тэрбум төгрөгт хүрч, 7.0 тэрбум төгрөг буюу 37.7 хувиар өссөн дүнтэй гарсан. Ингэснээр тайлант хугацаанд нийт цэвэр ашгийн хэмжээ 4.1 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 0.51 тэрбум төгрөг буюу 14.1 хувиар өсөв.

ХЗХ-дын эрсдэл ба эмзэг байдал

ХЗХ-дын эрсдэл, эмзэг байдлыг үнэлэхдээ тэдгээрийн тогтвортой байдлыг тодорхойлох үзүүлэлтүүдийг шинжлэх шаардлагатай.

Дүрслэл 2.26

Нийт хөрөнгө болон зээлийн эрсдэлд орох үзүүлэлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь 2010 онд хамгийн дээд цэг буюу 7.8 хувьд хүрч байсан бол 2012 онд хамгийн бага буюу 1.4


хувьд хүрч байсан. Харин энэхүү үзүүлэлт 2016 он хүртэл өссөөр 3.5 хувьд хүрч байсан бол тайлант улиралд өмнөх улирлын дүнгээс 0.6 нэгж хувиар буурч 2.3 хувь болсон байна.

Харин байгууллагын хөрвөх чадварыг илэрхийлэх үзүүлэлтүүд болох мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа, богино хугацаат хөрөнгө оруулалтын зээл болон нийт хөрөнгийн харьцааг тооцон дүрслэл 2.27-д үзүүлээ.

Эдгээр үзүүлэлтүүд нь хадгаламж эзэмшигч болон хөрөнгө оруулагч хөрөнгөө татах үед тухайн санхүүгийн байгууллага өөрийн хөрөнгөө мөнгөн хөрөнгөд хэр түргэн хөрвүүлэх боломжтойг харуулдаг. ХЗХ-ны хувьд сүүлийн 5 жилийн хугацаанд нийт мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа дунджаар 22.1 хувийг эзэлж байгаа ба тайлант улиралд 20.7 хувьтай байна.

Дүрслэл 2.27

Хөрвөх чадварын харьцаа



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Харин богино хугацаат хөрөнгө оруулалт болон нийт зээлийн нийлбэрийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 73.5 хувьтай байгаа бол тайлант улиралд 73.9 хувь байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Ерөнхий төлөв байдал


Үнэт цаасны зах зээлийн хөгжлийг зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадварын түвшин, зах зээлийн үнэлгээг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа, нийт арилжааны хэмжээ зэрэг үзүүлэлтүүдээр голчлон хэмждэг бөгөөд дээрх үзүүлэлтүүдийн ерөнхий төлөв, хандлагаас зах зээлийн бодит нөхцөл, байдлыг тодорхойлох боломжтой байдаг.

Зах зээлийн үнэлгээ

Үнэт цаасны зах зээлийн эдийн засагт эзлэх хувийг зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-гээр илэрхийлэх ба 2018 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар ЗЗҮ 2 их наяд 350.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.8 хувиар буюу 267.4 тэрбум төгрөгөөр өссөн, харин өмнөх оны эцсээс 3.7 хувиар буюу 89.7 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлт боллоо.

Дүрслэл 2.28

ТОП-20 индекс болон зах зээлийн үнэлгээ



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үеийнхээс өсөхөд эдийн засаг өсөлттэй, уул уурхайн болон аж үйлдвэрийн салбарын компанийн хувьцааны үнэ ханш дотоодын хөрөнгийн бирж дээр өссөн, гадаадын хөрөнгө оруулагчдын үнэт цаасны зах зээлд хөрөнгө

оруулах сонирхол нэмэгдсэн зэрэг нь голчлон нөлөө үзүүлжээ.


Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дундаж утга өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар өсч 20,034.66 нэгжид хүрсэн бол 2017 оны жилийн эцсээс 9.4 хувиар буурсан байна.

Зах зээлийн хөрвөх чадвар

Хөрвөх чадварын түвшин нь хувьцааны зах зээлийн эргэц, хурдыг илэрхийлэх бөгөөд хөгжингүй зах зээлтэй орнуудад дээрх харьцааны түвшин 70-90 хувьтай байх бөгөөд хөрвөх чадварын түвшинг нэмэгдүүлэх чиглэлээр хөрөнгийн биржүүд итгэмжлэгдсэн дилер (маркет мэйкер), үнэт цаас зээлээр худалдах, худалдан авах арга хэрэгслүүдийг ихээр ашиглаж гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг тухайн зах зээлд татаж байна.

Дүрслэл 2.29

Хувьцааны арилжааны дүн болон хөрвөх чадвар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын тухайн зах зээлд хөрөнгө оруулах сонирхол нь хөрвөх чадварын түвшин, ханшийн эрсдэлээс хамгаалах тогтолцоо буюу бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөлжилтөөс хамаардаг. Үнэт цаасны зах зээлийн арилжаанд эзлэх гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын бүтцийг 2018 оны 3 дугаар улирлын байдлаар харвал дотоодын иргэн 37.3 хувь, гадаадын иргэн 6.1

хувь, дотоодын аж ахуй нэгж 53.7 хувь, гадаадын аж ахуй нэгж 2.9 хувийг тус тус эзэлж байна. Түүнчлэн нийт арилжааны 9.0 хувийг гадаадын хөрөнгө оруулагчид бүрдүүлж байгаа бөгөөд үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.4 нэгж хувиар, 2017 оны жилийн эцэстэй харьцуулахад 4.9 нэгж хувиар тус тус өсчээ.

2018 оны 3 дугаар улирлын байдлаар зах зээлийн хөрвөх чадварын үзүүлэлт 3.2 хувь болж өмнөх оны мөн үеийнхээс даруй 2.3 нэгжээр өслөө. Хөрвөх чадварын түвшин ийнхүү өсөхөд хувьцааны арилжаа өмнөх оны мөн үеэс 3.1 дахин өссөн, компаниудын арилжаа эрхлэгч байгууллагад бүртгүүлэх, анхдагч зах зээлээс хөрөнгө татах сонирхол нэмэгдсэн, үнэт цаасны арилжааны идэвх

нэмэгдэж байгаа зэрэг хүчин зүйлс суурь нөлөө үзүүлжээ.

Мөн түүнчлэн мэргэжлийн зуучлагч байгууллагууд хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэн санхүүгийн чадавхаа сайжруулж байгаа бөгөөд иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл нэмэгдэж, хувьцаа худалдан авах хандлага өсөж байгаа зэрэг нь хөрвөх чадварын түвшинг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.

Үнэт цаасны арилжааны үзүүлэлтүүд

2018 оны 3 дугаар улиралд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй байна. Харин хувьцааны арилжаагаар 220 компанийн 209.2 сая ширхэг хувьцааг 75.4 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 70.9 хувийг эзэлжээ.

Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн үзүүлэлтүүд

Бүртгэлтэй компани

2018 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар СЗХ-нд 304 хувьцаат компани бүртгэлтэй байгаагаас, төрийн өмчийн оролцоотой 19, төрийн өмчит 31, хувийн өмчит 254 компани байна.

Дүрслэл 2.30

Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувийн өмчит компаниудын дийлэнх нь өмч хувьчлалаар үүсэн бий болсноос үүдэн компанийн хувьцааны хяналтын багц цөөн тооны нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрсөн нь зах зээл дэх нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлдөг.

Хувьцаат компанийн хяналтын багц цөөн тооны хөрөнгө оруулагчдын гарт төвлөрсөн нь компанийн засаглалыг доройтуулж, дотоод мэдээлэл эзэмшигч этгээд үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж, улмаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг бууруулж байна. Энэ нь зах зээлийн хөрвөх чадварыг бууруулах үндсэн шалтгаан болж байна.

Олон улсын туршлагаас үзэхэд компанийн засаглалыг хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан, хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээ сонгосон болон санхүүгийн тайлангаа төрийн эрх бүхий

байгууллага, олон нийтэд мэдээлсэн байдал, ногдол ашиг тараалт, нийгмийн хариуцлага гэсэн үзүүлэлтүүдээр голчлон авч үздэг.

2018 оны 1 дүгээр улирлын байдлаар 18 компани 2017 оны жилийн эцсийн ашгаасаа нийт 18.8 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэр гаргасан бөгөөд үүнээс 3 компанийн 77.8 сая төгрөгийн ногдол ашиг тараагдаад байна.

Зах зээлийн дэд бүтэц

Үнэт цаасны зах зээлийн төлбөр, тооцооны үзүүлэлтүүд

“Арилжааны төлбөр тооцоо” ХХК 2018 оны 3 дугаар улирлын байдлаар анхдагч зах зээлийн арилжааны 12.499 хэлцлээр 30.4 тэрбум төгрөгний үнэ бүхий хувьцааны төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн. Хоёрдогч зах зээлд Засгийн газрын үнэт цаасны 31.1 тэрбум, хувьцааны 44.7 тэрбум арилжааны тооцоог хийж гүйцэтгэв.

Мөн үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөрөөс “ХААН банк” ХХК 14.7 тэрбум, “Хас банк” ХХК 15.5 тэрбум, “Худалдаа хөгжлийн банк” ХХК 8.2 тэрбум, “Голомт банк” ХХК 7.1 тэрбум төгрөгийн гүйлгээг тус тус хийжээ.


Тайлант хугацаанд төвлөрсөн хадгаламжид шинээр нийт 61,526 данс нээгдсэнээс, дотоодын иргэн 61,363, гадаадын иргэн 88, дотоодын аж ахуй нэгж 70, гадаадын аж ахуй нэгж 5 данс нээлгэсэн байна. 2012 оноос үнэт

2018 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар Монголын хөрөнгийн зах зээл дээр үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны 1, төвлөрсөн хадгаламжийн 1, брокер дилер 54, кастодиан банкны 3, андеррайтер /давхардсан тоогоор/ 24, хөрөнгө оруулалтын зөвлөх /давхардсан тоогоор/ 14, хөрөнгө оруулалтын менежментийн 17, аудитын 56, үнэлгээний 23, хуулийн 25 компани тус тус үйл ажиллагаа явуулж байна.

цаасны төвлөрсөн хадгаламжид нээгдсэн дансны тоо эрс өссөн нь төрөөс “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх шийдвэр гаргасан нь голлон нөлөөлсөн.

Дүрслэл 2.31

Арилжааны төлбөр тооцоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

ДААТГАЛЫН САЛБАР

Даатгалын салбарын ерөнхий мэдээлэл

Ерөнхий төлөв байдал

2018 оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацаат даатгалын 1, давхар даатгалын 2 компани нийт 18 даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын зах

зээлд нийт 2513 мэргэжлийн оролцогч оролцож байгаагаас зуучлагч 47, хохирол үнэлэгч 27, 2421 төлөөлөгч Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 2.9**Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо**

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018Q3
Даатгагч	18	17	17	17	17	17	18
Даатгалын төлөөлөгч	2 357	3 178	3 260	3 340	3 091	2 893	2 421
Даатгалын зуучлагч	17	20	30	37	40	42	47
Даатгалын хохирол үнэлэгч	9	14	20	27	31	29	27
Дүн	2 401	3 229	3 327	3 421	3 179	2 981	2 513

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.**Даатгагчийн хөрөнгө**

2018 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 327.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 75.9 тэрбум төгрөгөөр буюу 30.2 хувиар өссөн.

Хүснэгт 2.10**Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ (2018 оны III улирлын байдлаар, тэрбум төгрөг)**

№	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	Хөдөө аж ахуйн давхар даатгал	48.2	14.7%
2	Монгол даатгал	41.7	12.7%
3	Мандал генерал даатгал	34.1	10.4%
4	Бодь даатгал	26.2	8.0%
5	Тэнгэр даатгал	23.1	7.1%
6	Анд давхар даатгал	20.9	6.4%
7	Ард даатгал	19.3	5.9%
8	Миг даатгал	17.4	5.3%
9	Практикал даатгал	15.6	4.7%
10	Номин даатгал	15.1	4.6%
11	Хаан даатгал	11.0	3.4%
12	Соёмбо даатгал	10.2	3.1%
13	Монре даатгал	9.1	2.8%
14	Нэйшнл лайф даатгал	8.7	2.7%
15	Улаанбаатар хотын даатгал	7.4	2.2%
16	Ган зам даатгал	7.2	2.2%
17	Гэр даатгал	6.7	2.0%
18	Мөнх даатгал	5.9	1.8%
	Дүн	327.6	100.0%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Сүүлийн 5 жилд даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт компаниудын хөрөнгийн хэмжээ 2.4 дахин нэмэгдсэн бол урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн хөрөнгийн хэмжээ 1.5 дахин тус тус нэмэгдсэн дүнтэй байна. 2018 оны 3 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн, урт хугацааны болон давхар

даатгалын компаниудыг нийт хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад нэг компани 14.7 хувийн, эхний дөрвөн компани нийлээд 45.8 хувийн тус тус төвлөрөлтэй байв.

Нийт даатгалын компаниудын хөрөнгийн 52.1 хувийг хөрөнгө оруулалтын дүн, 18.1 хувийг мөнгөн хөрөнгийн дүн, 9.3 хувийг үндсэн хөрөнгө, 7.1 хувийг даатгалын авлагын дүн, 13.6 хувийг бусад хөрөнгө, эх үүсвэрийн 50.6 хувийг нийт өр төлбөр, 49.4 хувийг эзэмшигчдийн өмч тус тус эзэлж байна.

Хүснэгт 2.11**Даатгалын компаниудын хөрөнгө балансын зүйлээр (хувиар)**

№	Үзүүлэлтүүд	Ердийн даатгал	Урт хугацаат даатгал	ХАА-н давхар даатгал
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	15%	2%	31%
2	Даатгалын авлагын дүн	8%	0%	4%
3	Бусад санхүүгийн хөрөнгийн дүн	5%	1%	0%
4	Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн	1%	1%	0%
5	Хөрөнгө оруулалтын дүн	48%	66%	64%
6	Даатгалын хөрөнгийн дүн	0%	0%	0%
7	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	11%	29%	1%
8	Биет бус хөрөнгө /Цэвэр/	0%	1%	1%
9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0%	0%	0%
10	Өр төлбөр	55%	21%	38%
11	Нөөц сан	46%	21%	36%
12	Эзэмшигчдийн өмч	45%	79%	62%
13	Хувь нийлүүлсэн хөрөнгө	30%	69%	43%
14	Хуримтлагдсан ашиг	7%	-3%	18%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Ердийн даатгалын компанийн эх үүсвэрийн 46 хувь буюу 114.3 тэрбум төгрөгийг нөөц сан (нөөц сангийн дүн болон орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн нийлбэр дүн) бүрдүүлж байгаа бол нийт хөрөнгийн 48 хувь буюу 120.8 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын дүн эзэлж байна.


Даатгагчийн өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч дэх даатгалын нөөц сан 2015 оны 4 дүгээр улиралд 42.1 хувь, 2016 оны 4 дүгээр улиралд 44.6 хувь, 2017 оны 4 дүгээр улиралд 48.2 хувьд

хүрч тогтвортой өссөн бол 2018 оны 3 дугаар улиралд 43.2 хувь болж буураад байна.

Дүрслэл 2.32

Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Даатгалын хураамжийн орлого ба нөхөн төлбөр

Даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 126.4 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнээс ердийн даатгалын компаниуд 123.7 тэрбум төгрөгийн, урт хугацааны даатгалын компани 1 тэрбум төгрөгийн, давхар даатгалын компани 1.7 тэрбум төгрөгийн хураамжийн орлого тус тус төвлөрүүлсэн байна.

2005 оноос 2014 он хүртэлх хугацаанд нийт хураамжийн орлого 99.2 тэрбум төгрөгөөр ялангуяа 2012 оноос эхлэн огцом өссөн байна. Үүнд 2012 онд “Жолоочийн албан журмын даатгалын тухай хууль” батлагдаж, хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор албан журмаар даатгуулах даатгуулагчдын тоо нэмэгдэж, мөн түүнчлэн албан журмын даатгалын өсөлтийг дагаж авто тээврийн хэрэгслийн даатгал өндөр өсөлттэй гарсан нь голлон нөлөөлжээ. Харин 2018 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 42.2 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгожээ.

Хүснэгт 2.12

Даатгалын хураамжийн орлого ба нөхөн төлбөр, бүтээгдэхүүнээр (тэрбум төгрөг)

№	Бүтээгдэхүүний хэлбэр	Нийт хураамжийн орлого	Нийт нөхөн төлбөр
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	17.1	5.4
2	Хөрөнгийн даатгал	24.6	1.9
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	20.4	9.2
4	Ачааны даатгал	1.8	0.1
5	Барилга угсралтын даатгал	7.9	7.6
6	Газар тариалангийн даатгал	0.1	0.0
7	Мал амьтдын даатгал	2.5	0.6
8	Агаарын хөлгийн даатгал	1.3	0.0
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	0.3	0.1
10	Хариуцлагын даатгал	9.3	2.3
11	Санхүүгийн даатгал	2.5	0.8
12	Зээлийн даатгал	2.4	0.8
13	Итгэлцлийн даатгал	0.4	0.0
14	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	0.1	0.0
15	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	0.00	0.0
16	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	7.0	0.5
17	Жолоочийн хариуцлагын албан журмын	26.0	12.6
18	Амьдралын даатгал	1.0	0.5
19	Давхар даатгал	1.7	0.0
Дүн		126.4	42.2

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Даатгалын салбарын ашигт ажиллагаа

2018 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын компаниудын ашигт ажиллагааг тооцоход, нийт хөрөнгийн өгөөжийн дүн салбарын хэмжээнд 4.74 хувь, үүнээс урт хугацаат даатгалын компанийн өгөөжийн дүн 1.27 хувь, ердийн даатгал 4.02 хувь, давхар даатгалын компани 8.22 хувь гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 0.65 пунктээр өссөн үзүүлэлт юм. Харин өөрийн хөрөнгийн өгөөжийн салбарын дундаж 10.01 хувь байгаа бөгөөд үүнээс урт хугацаат даатгалын өөрийн хөрөнгийн өгөөж 1.6 хувь, ердийн даатгал 9.26 хувь, давхар даатгал 13.95 хувь гарсан нь өмнөх оны мөн үеэс 0.78 нэгж хувиар өссөн үзүүлэлт боллоо.

Нийт даатгалын салбарын татварын дараах цэвэр ашиг тайлант улиралд 14.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 4.2 тэрбум төгрөг буюу 41 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс давхар даатгалын нэг компани нэмэгдсэнтэй холбоотойгоор давхар даатгалын компаниудын татварын дараах цэвэр ашиг хамгийн их дүнгээр буюу

1.7 тэрбум төгрөгөөр өсөж 4.8 тэрбум төгрөг болсон байна. Харин урт хугацаат даатгалын компани 109.3 сая төгрөгийн, ердийн даатгалын компаниуд нийт 9.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Даатгалын салбарын тогтвортой байдал

2018 оны 3 дугаар улирлын байдлаар хураамжийн орлогоос гадаадын давхар даатгалын компанид төлж байгаа төлбөр 35.9 тэрбум төгрөг буюу нийт хураамжийн орлогын 28.4 хувийг эзэлсэн бол өмнөх 5 жилийн 3 дугаар улирлуудын дундаж 32.3 хувьтай байв. Нийт давхар даатгалын төлбөрийн 97.7 хувийг ердийн даатгал, 0.05 хувийг урт хугацаат даатгалын компани, 2.3 хувийг давхар даатгалын компани шилжүүлсэн ба ердийн даатгалын компани хураамжийн орлогын 28.3 хувийг, урт хугацааны даатгалын компани 1.7 хувийг, хөдөө аж ахуйн давхар даатгалын компани 53.5 хувийг давхар даатгалд тус тус төлжээ.

Давхар даатгалын үндэсний компани байхгүй байгаа нь даатгалын салбар дахь гадаад валютын гадагшлах урсгалыг нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болж, цаашид салбарын тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлал бий болгож байна. Даатгалын салбар нь нийгэм, эдийн засагт учрах хүлээгдээгүй эрсдэлийг бууруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг хэдий ч, даатгалын салбарын өөрийн тогтворгүй байдал, системийн эрсдэлийн түвшин нь эргээд санхүүгийн тогтвортой байдалд томоохон нөлөө үзүүлдэг.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл /Financial stability board/ болон Олон улсын даатгалын хяналт, зохицуулалтын байгууллагуудын хороо /IAIS/-ноос даатгалын

салбарт учирч буй системийн эрсдэлийг үндсэн гурван чиглэлийн хүрээнд тодорхойлжээ. Үүнд:

- ♦ Санхүүгийн зах зээлийн бусад оролцогчид /банк, үнэт цаасны компаниуд/-оос үүдэлтэй эрсдэлийн нөлөөлөл;
- ♦ Даатгалын компани уг нөлөөлөлд хариу үйлдэл үзүүлснээр эрсдэл бууруулах чадвар;
- ♦ Системийн хэмжээнд нөлөөтэй даатгалын компанийн эрсдэл.

Тиймээс Олон улсын даатгалын хяналт, зохицуулалтын хорооноос даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах, системийн хэмжээнд нөлөөлөхүйц даатгалын компанийг тодорхойлох, түүнд хяналт тавих, системийн эрсдэлийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2010 оноос анхаарч, системийн хэмжээнд нөлөөлөхүйц даатгалын компанийг тодорхойлох үнэлгээний аргачлал, макро болон микро зохистой үзүүлэлтийн аргачлалыг боловсруулж, хөрөнгийн болон төлбөрийн чадварын шинэ стандарт, шаардлагуудыг бий болгоод байна.

Энэ хүрээнд тус байгууллагаас даатгалын салбар болон компаниудад учирч болох эрсдэлийг бууруулахын тулд макро болон микро зохистой үзүүлэлтийн хүрээнд хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэхийг гишүүн орнуудын зохицуулах байгууллагуудад зөвлөсөн бөгөөд уг зөвлөмжийг хэрэгжүүлснээр даатгалын салбарт нөлөөлөхүйц макро эдийн засгийн хувьсагчдын нөлөөллийг зөв тодорхойлох, тулгарч болзошгүй системийн эрсдэлийг эрт илрүүлэх тогтолцоо бүрдэх, ирээдүйд бий болж болохуйц эрсдэлд хариу үйлдэл үзүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байгаа юм.


ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

Зээлийн батлан даалтын сан нь эргэлтийн хөрөнгийн, хөрөнгө оруулалтын, бичил зээлийн гэсэн 3 төрлөөр батлан даалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд нэг удаа гаргах батлан даалтын дээд хэмжээ нь 250.0 сая төгрөг байна. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 13.0 тэрбум төгрөгийн зээлийн багцад 7.7 тэрбум төгрөгийн батлан даалтыг гаргасан бол хуримтлагдсан дүнгээр 97.4 тэрбум төгрөгийн зээлийн багцад 48.4 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна.

Зээлийн батлан даалтын сан нь 2018 оны 3 дугаар улиралд гаргасан батлан даалтын 46.0 хувийг Төрийн банк, 8.8 хувийг Хас банк, 38.7 хувийг Худалдаа хөгжлийн банк, 6.5 хувийг Капитрон банкны зээлэнд тус тус гаргасан байна.

Дүрслэл 2.33

Батлан даалт гаргасан байдал болон санхүүжилтийн эх үүсвэр



№	Үзүүлэлтүүд /Хуримтлагдсан дүнгээр/	2018Q3
1	Батлан даалтын хэмжээ	48 460.2
1.1	Үүнээс: Хугацаа хэтэрсэн	4 639.8
1.2	Чанаргүй	6 206.3
2	Батлан даалт гаргасан зээлийн дүн	97 479.4
2.1	Үүнээс: Хугацаа хэтэрсэн	11 738.2
2.2	Чанаргүй	13 755.2

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ БА ТҮҮХИЙ ЭДИЙН АРИЛЖАА

ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн арилжаа: 2013 оны 4 дүгээр сард биржээр дамжин зөвхөн нэг төрлийн түүхий эд буюу ямааны ноолуур арилжаалагддаг байсан бол 2018 оны 3 дугаар улирлын байдлаар бараа бүтээгдэхүүний төрөл нэмэгдэж 8 төрлийн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалагддаг болсон. Үүнд: ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, завод ноос, бодын хөөвөр, мал бэлтгэл, хүнсний буудай болон тосны ургамал зэрэг багтдаг. Завод ноос нь адуу болон үхрийн, хонины, ямааны, сарлагийн, тэмээний гэж 5 ангилалд багтдаг бол бодын хөөвөр нь сарлагийн, адууны, үхрийн гэсэн 3 ангилалд хуваагддаг.

Тайлант улиралд Хөдөө аж ахуйн биржээр нийт 657.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос,

завод ноос, бодын хөөвөр арилжаалагдсан бөгөөд нийт арилжааг бүтцээр ангилан үзвэл 84 хувийг ямааны ноолуур, 9 хувийг хонины ноос, 7 хувийг завод ноос, 0.4 хувийг тэмээний ноос, 0.1 хувийг бодын хөөвөр тус тус эзэлж байна.

Хүснэгт 2.13

Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн арилжааны үнийн дүн

Барааны нэр	Арилжааны дүн, тэрбум төгрөгөөр /2018Q3/
Ямааны ноолуур	554.2
Хонины ноос	56.0
Тэмээний ноос	2.8
Бодын хөөвөр	0.6
Завод ноос	44.0
Нийт	657.6

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИ

3.1 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийг 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр УИХ-аас баталлаа: Банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг дэмжих зорилгоор хийгдэж буй банкны салбар дахь бүтцийн өөрчлөлтийн бодлогын арга хэмжээ болон Олон Улсын Валютын сантай хамтран хэрэгжүүлж байгаа “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Банкны дахин хөрөнгөжүүлэх тухай хуулийн төслийг Засгийн газраас өргөн мэдүүлснийг УИХ-аас хэлэлцэж, “Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль” болгон нэрийг өөрчилж, 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр баталсан байна.

Монгол Улсын банкны салбарын нийт активын 86.3 хувийг эзэлдэг, 2.5 сая хадгаламж эзэмшигчийн 9.9 их наяд төгрөг татан төвлөрүүлсэн, 4.7 сая харилцагчийн 3.9 их наяд төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй, 984 мянган зээлдэгчид олгосон 12.3 их наяд төгрөгийн зээлийн актив бүхий, банкны салбарын тогтвортой байдалд нөлөөлөхүйц үйл ажиллагаа эрхэлж байгаа системийн нөлөө бүхий банкнуудын санхүүгийн байдлыг бэхжүүлж, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх нь Монгол Улсын санхүү, эдийн засгийн бодлогын тэргүүлэх зорилт юм.

Тус хуулийг баталснаар активын чанарын үнэлгээ болон бусад хяналт шалгалтын үр дүнд тодорхойлсон өөрийн хөрөнгийн шаардлагыг банкны хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдаар тэргүүн ээлжинд хангуулах, хангаж чадахгүй тохиолдолд дунд хугацаанд ашигтай ажиллах боломжтой системийн нөлөө бүхий банкнуудын өөрийн хөрөнгийн дутагдсан хэсэгт төрөөс хөрөнгө оруулах замаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг уг хуулиар бүрдүүллээ.

Хууль хэрэгжсэнээр банкнуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ сайжран, олон нийтээс банкинд итгэх итгэл хадгалагдах бөгөөд банкны тогтолцооны хэвийн, найдвартай байдал бэхжин улмаар банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангахад дэмжлэг болно гэж үзэж байгаа юм.

Актив удирдлагын тухай хуулийн төслийн саналыг боловсрууллаа: Банк, санхүүгийн салбарын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх нь банкнаас олгох зээлийн хэмжээг бууруулах, санхүүгийн зуучлалыг зогсонги байдал оруулах, улмаар бодит секторын өсөлтийг хязгаарлах, ажилгүйдлийг нэмэгдүүлэх, халамжийн зардлыг өсгөх, татварын орлогыг

бууруулах зэргээр нийт эдийн засгийн өсөлт, хөгжилд сөргөөр нөлөөлдөг.

Манай улсад 2015 оноос эхлэн банк, санхүүгийн салбарт хуримтлагдсан чанаргүй активыг бууруулах, тус салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор актив удирдлагын мэргэшсэн институци байгуулах асуудлыг анхаарч, төрийн бодлогын баримт бичгүүдэд тусгаж ирсэн байна. Тодруулбал:

- ♦ Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр” -ийн 2.2 дахь заалтад “Банкны салбарт эрсдэл хуримтлагдах, зээлийн тасалдал үүсэх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болохоос сэргийлэх арга хэмжээ авахаар тусгасан.
- ♦ Улсын Их Хурлын 2015 оны 93 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл"-ийн 3.1-д санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийг хөгжүүлж, эрх зүйн орчныг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд даалгасан.
- ♦ Улсын Их Хурлын 2016 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл"-ийн 3.2-д санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийн эрх зүйн орчныг бүрдүүлэх" арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд даалгасан.
- ♦ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн “Эдийн

засгийг сэргээх хөтөлбөр” батлах тухай 71 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан тэргүүн ээлжинд боловсруулж, батлуулах шаардлагатай хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн жагсаалтад Активын удирдлагын институцийн тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тусгасан байна.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагын хүрээнд хийгдсэн ажлууд болон Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хийгдсэн судалгаа, үнэлгээ, олон улсын сайн туршлагад үндэслэн хувийн хөрөнгө оруулалт давамгайлсан төрийн өмчийн оролцоотой Актив удирдлагын компанийг байгуулах, үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг бүрдүүлэхээр Актив удирдлагын тухай хуулийн төслийн саналыг боловсруулж, хууль санаачлагчид уламжлаад байна.

Хуулийн төслийн санал нь банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Актив удирдлагын компанийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож, зохицуулах бөгөөд бүтцийн хувьд нийт 10 бүлэг, 53 зүйлтэй юм.

Төсөлд актив удирдлагатай холбоотой нэр томъёог холбогдох олон улсын стандарт, Монгол Улсын бусад хууль тогтоомжид нийцүүлэн тодорхойлсноос гадна Актив удирдлагын компанийг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа явуулах, бие даасан хараат бус байдлыг хангах, түүний үйл ажиллагаанд хяналт тавих, чанаргүй зээл, активыг шийдвэрлэх, тус үйл ажиллагаанд холбогдох нэмэмжлэлийг шийдвэрлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах, Актив удирдлагын сангийн талаарх зохицуулалт болон Актив удирдлагын компанийн үйл

ажиллагааг зогсоох талаарх зохицуулалтыг тусгасан болно.

Хуулийн төсөлд тусгагдсан чанаргүй зээл, активыг шийдвэрлэх ажиллагаанд холбогдох нэмэмжлэлийг шийдвэрлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах зохицуулалтыг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн зохицуулалтаас өөр журмаар тогтоосон байна. Энэ нь төлбөр төлөгч, төлбөр авагч нарын хооронд өр төлбөртэй холбоотой маргаан байхгүй тул төлбөрийг төлөх эсэх талаарх маргааныг төсөлд заасны дагуу шүүхийн онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх, шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг түргэн шуурхай явуулснаар чанаргүй зээл, активыг түргэн хугацаанд шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ. Актив удирдлагын компани 10 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулахаар хуулийн төсөлд тусгагдсан бөгөөд түүний үйл ажиллагааны гол зорилго нь чанаргүй активыг түргэн хугацаанд шийдвэрлэх явдал юм. Иймд шүүхийн онцгой ажиллагааны тухай болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай тус хуулийн төслийн зохицуулалт нь Актив удирдлагын компани чанаргүй активыг түргэн хугацаанд шийдвэрлэх үндэслэл, боломжийг олгох юм.

Актив удирдлагын тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар бий болно гэж үзсэн:

- ♦ Зах зээл дэх зээлийн нийлүүлэлт нэмэгдэж, бизнес эрхлэгчдэд эдийн засгийн бодит дэмжлэг хүрнэ;
- ♦ Зээлийн эргэн төлөлтийн явц хурдасч, чанаргүй активыг удирдах, хөрвөх чадвартай хоёрдогч захын үйл ажиллагаа хөгжинө;
- ♦ Улсын төсөвт ирээдүйд учирч болзошгүй их хэмжээний зардлыг бууруулж, тодорхой хэмжээнд хэмнэлт бий болох зэрэг болно.

Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-аар хэлэлцэгдэж байна. Монгол улсын нийгэм, эдийн засагт тулгарч буй хүндрэлийг даван туулах, санхүүгийн тогтвортой байдал, үнийн тогтвортой байдлыг хангахад валютын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Судалгаагаар дотоодын зах зээл хөгжихөд тулгамдаж буй гол асуудлууд нь суурь эдийн засгийн бүтэцтэй холбоотойгоор гадаад валютын эрэлт, нийлүүлэлтэд улирлын шинжтэй огцом зөрүү үүсдэг, санхүүгийн зах зээлийн бүтэцтэй холбоотойгоор зах зээлд оролцогч хоорондын итгэлцэл бага, төлбөр тооцооны эрсдэл өндөр явдал байна.

Иймд дотоодын зах зээлийн өрсөлдөөнт байдал болон мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг сайжруулахын тулд санхүүгийн зах зээлийн тодорхой шаардлагыг хангасан оролцогчид тэгш эрхтэйгээр оролцох боломжтой арилжааны нэгдсэн платформ буюу валютын биржийг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Валютын зохицуулалтын тухай хууль нь 1994 оны 5 дугаар сарын 12-ны өдөр УИХ-аар батлагдсанаас хойш 24 жилийн хугацаанд 19 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд Хууль зүйн яамнаас “Валютын зохицуулалтын тухай” хуульд 2009 онд шинжилгээ хийн давхардал 3, зөрчил 18, хийдэл 30 байгааг тогтоож, уг хуулийг нэн даруй шинэчлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гаргаж байсан билээ. Иймээс энэхүү давхардал, зөрчил, хийдлийг бүрэн арилгаж “Валютын зохицуулалтын тухай”, “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулиудыг нэгтгэж, валютын нэгдсэн зохицуулалтыг бий болгон, Валютын харилцааг бүрэн зохицуулсан, хөрөнгийн болон санхүүгийн зах зээлийн

хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчинг бий болгох шаардлага зүй ёсоор үүсчээ.

Дээрх хэрэгцээ шаардлагын үүднээс Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, Монгол Улсын 2016 оны УИХ-ын 71-р тогтоолоор батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны хөтөлбөр зэргийг үндэслэн хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа, төслийн үр нөлөөг үнэлсэн судалгаа, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын судалгааг хийж, бусад улсын хууль тогтоомжийг судлан өөрийн орны онцлогийг харгалзан Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, төслийг боловсруулсан байна.

Хуулийн зорилт харилцаа, агуулга ихээхэн өөрчлөгдөж, хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байгаа учраас шинэчилсэн найруулгаар оруулж байгаа бөгөөд хуулийн төсөл дараах байдлаар томъёологдсон. Үүнд:

- ♦ Хуулийн төслийн макро эдийн засгийн бодлогын суурь нь хөрөнгийн чөлөөтэй урсгал, зохицуулалттай хөвөгч ханшийн дэглэм болон төрийн мөнгөний бодлогын бие даасан байдал бөгөөд зохицуулах харилцаа нь эдийн засгийн харьяат

хоорондын болон тэдгээрээс харьяат бустай хийх валютын гүйлгээ, валютын дотоодын захын зохицуулалт төдийгүй Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэхтэй холбоотой харилцаа байхаар;

- ♦ Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг энэ хуультай нэгтгэж валютын нэгдсэн бодлого явуулахаар;
- ♦ Валютын захыг тодорхойлж, биржийн болон биржийн бус хэлбэрээр валютын арилжааг явуулах, арилжаа эрхлэх болон оролцох этгээдийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгохоор;
- ♦ Валютын захын дотоод мэдээлэл эзэмшигчийг тодорхойлж, тэдгээрт хориглох үйл ажиллагаа болон валютын захыг урвуулан ашиглахыг хориглосон зохицуулалтыг тусгахаар;
- ♦ Төрийн байгууллагуудын бүрэн эрх үүргийг тодорхой болгож шинэчлэн найруулсан болно.

Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монголбанк, Сангийн Яам, Санхүүгийн зохицуулах хорооны бүрэлдэхүүнтэй ажлын хэсгээс боловсруулж, УИХ-ын гишүүн М.Оюунчимэг нарын гишүүд 2018 оны 6 дугаар сард УИХ-д өргөн барьсан.

3.2 ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМ

Их дүнтэй төлбөр тооцооны систем

Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцоог Монголбанкны “Банксүлжээ” системээр бодит цагийн горимоор гүйцэтгэж байгаа нь төлбөрийн системийн эрсдэлийг бууруулах, мөнгөн урсгалыг бодит цагаар хянах, мөнгөний бодлогын хэрэгжилтийг сайжруулах, заавал

байлгах нөөцийг хангуулах боломжийг бүрдүүлдэг.

Их дүнтэй төлбөрийн системээр банк хоорондын төлбөр тооцоо, Сангийн яамны Төрийн сангийн газрын төлбөр тооцоо, Үнэт цаасны төлбөр тооцоог бодит цагийн горимоор гүйцэтгэж, бага дүнтэй төлбөрийн


систем болон төлбөрийн картын системээс илгээсэн үр дүнгийн тооцооллыг оролцогч бүрийн харилцах дансанд тусгаж байгаа юм.

Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн хүрээнд RTGS системийн 2 дугаар үеийн шинэчлэлтийн ажлыг “CMA small business systems AB” компанитай хамтран гүйцэтгэж, 2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр амжилттай нэвтрүүлээд байна.

Тайлант хугацаанд Банксүлжээ системээр нэг өдөрт дунджаар 200.3 тэрбум төгрөгийн 6.8 мянган ширхэг их дүнтэй гүйлгээ хийгдсэн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 3.1

Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт




Эх сурвалж: Монголбанк

Бага дүнтэй төлбөр тооцооны систем

Үндэсний цахим гүйлгээний төв нь бага дүнтэй төлбөрийн системийн болон төлбөрийн картын системийн гүйлгээг бодит цагийн горимоор дамжуулж, үр дүнгийн тооцооллыг Банксүлжээ систем рүү дамжуулж байна.

Дүрслэл 3.2

Бага дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк

Сүүлийн долоон жилийн байдлаар бага дүнтэй гүйлгээ нь төлбөрийн системийн нийт гүйлгээний дүнгийн 2-6 орчим хувийг, харин

гүйлгээний тооны 92-95 хувийг тус тус эзэлж байгаа юм. Олон тооны хэрэглэгч, өргөн хүрээг хамарч байдаг тул энэ системийн найдвартай, тасралтгүй ажиллагаа нь харилцагчдын банкинд итгэх итгэлд ихээхэн нөлөө үзүүлдэг.


ҮЦГТ нь 2018 оны 3 дугаар улирлын байдлаар нэг өдөрт дунджаар 15.6 тэрбум төгрөгийн 112.4 мянган ширхэг бага дүнтэй гүйлгээ, 15.3 тэрбум төгрөгийн 418.0 мянган ширхэг картын гүйлгээг тус тус дамжуулжээ.

Үндэсний төлбөрийн систем

Монголбанк нь Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийн тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлыг ханган, бэлэн бус төлбөр тооцоог дэмжих бодлого баримтлан ажилладаг.

Дүрслэл 3.3

Картын гүйлгээний нэг өдрийн дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк

Монголбанк нь Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийн тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлыг ханган, бэлэн бус төлбөр тооцоог дэмжих бодлогын хүрээнд “Үндэсний төлбөрийн системийн хууль”-ийг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр батлуулж, улмаар төлбөрийн системийн эрх зүйн нарийвчилсан зохицуулалтыг хийх зорилгоор холбогдох журам, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, шаардлагатай баримт

бичгийг шинээр боловсруулж байна. Тухайлбал, “Цахим мөнгөний журам”, “Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам”-ыг шинээр батлуулж, мөн “Төлбөрийн картын журам” болон “Бага дүнтэй гүйлгээний системийн журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

Түүнчлэн “Үндэсний төлбөрийн системийн тухай хууль”-д заасны дагуу “Үндэсний төлбөрийн системийн зөвлөл”-ийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2018 оны 10 дугаар сарын 29-ны өдөр байгуулж, 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зөвлөлийн анхны хурлыг Монголбанкнаас зохион байгуулсан. Энэ нь Монголбанк, санхүүгийн байгууллагыг хянан зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл, үндэсний төлбөрийн системийн оролцогчийн төлөөллөөс бүрдсэн, орон тооны бус, хараат бус зөвлөл юм. Зөвлөл нь төлбөрийн системийн оролцогч, хэрэглэгчийн эрх ашиг, сонирхол, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамгаалах, нэгтгэх, үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратегийн бодлогыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх зорилготой байна.

Төлбөрийн системийн хяналт

Үндэсний төлбөрийн системийн нэгдмэл байдлыг хангах, тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, оролцогчдын тэгш, тэнцвэртэй оролцоог дэмжих, системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зарчмыг

баримтлан төлбөрийн системд тавих хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу үндэсний мөнгөн тэмдэгтийг орлон төлбөр тооцоонд хэрэглэгдэх төлбөрийн хэрэгслийн зөвшөөрлийг олгон, хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд 2018 оны 3 дугаар улирлын байдлаар Чингис хаан банкинд

Юнион Пэй байгууллагын карт гаргах зөвшөөрөл, Монгол Улсын мөнгөн тэмдэгт - төгрөгтэй адилтгах үнэ цэнэ бүхий бэлэн бус төлбөрийн хэрэгслээр тооцогдох Candy “Цахим мөнгө гаргах” тусгай зөвшөөрлийн гэрчилгээг “Мобифинанс” ББСБ-д 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр тус тус олгоод байна.

Төлбөр тооцооны “Банксүлжээ” систем, олон улсын санхүүгийн мэдээний СВИФТ сүлжээний үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт, төлбөрийн системийн оролцогч 14 банк (Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хас банк, Улаанбаатар хотын банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Капитрон банк, Тээвэр хөгжлийн банк, Капитал банк, ХААН банк, Ариг банк, Кредит банк, Чингис хаан банк, Төрийн банк, Богд банк)-ны их болон бага дүнтэй төлбөр тооцоо, картын төлбөр тооцоо, хөдөлгөөнт банкны үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаа, мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай

ажиллагаанд иж бүрэн шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг баталгаажуулж, төлбөр тооцооны болон клирингийн системүүдийн үйл ажиллагааны тайланг 7 хоногийн давтамжтайгаар гаргуулан, хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна. Ингэхдээ төлбөр тооцооны “Банксүлжээ” систем, олон улсын санхүүгийн мэдээний СВИФТ сүлжээ, Үндэсний цахим гүйлгээний төвийн хариуцан ажиллуулж буй Төлбөрийн картын нэгдсэн сүлжээ, бага дүнтэй төлбөрийн систем, Худалдаа хөгжлийн банкны картын свитчийн үйл ажиллагаанд мониторинг хийж, хяналтын тайланг сар бүрээр нэгтгэн удирдлагад танилцуулан, зохих үзүүлэлтийг хангаагүй зөрчил гаргасан оролцогчид цаг тухайд нь арга хэмжээ авч ажиллалаа.

3.3 САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27² дугаар зүйлд зааснаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн үндсэн чиг үүрэг нь Монгол Улсын санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахтай холбоотойгоор тогтолцооны шинжтэй эрсдэлийг илрүүлэх, хянах, бууруулах талаар хэлэлцэж, гишүүдийн үйл ажиллагааг уялдуулах явдал бөгөөд СТБЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь түүний ээлжит болон ээлжит бус хуралдаан байна гэж заасан байдаг.

СТБЗ 2018 оны 2 дугаар сарын 09 болон 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд ээлжит хуралдаанаа зохион байгуулж, санхүүгийн салбарт тулгамдаж буй цаг үеийн асуудлуудыг авч хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гарган ажиллаа. Тухайлбал, 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар (i) СТБЗ-ийн ажиллах дүрмийг шинэчлэн батлах тухай; (ii) Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журмын шинэчилсэн төсөл; (iii) Зоос банкны жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах асуудлын талаар; (iv) Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх тухай; (v) СТБЗ-ийн 2019 оны ээлжит хуралдааны товыг тогтоох тухай асуудлуудыг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргасан.

Түүнчлэн 2018 онд СТБЗ нь шаардлагатай асуудлуудыг ээлжит хуралдаанаараа авч хэлэлцэхээс гадна эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, гишүүн байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг сайжруулахад чиглэсэн дараах томоохон асуудлуудыг ажлын журмаар баталж, шийдвэрлэлээ. Үүнд: (i) 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдөр “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”, ОУВС-гийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд заавал

биелүүлэх шалгууруудын нэг болох “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг”-ийг, түүнчлэн 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус СТБЗ-ийн гишүүд хамтарсан тушаалаар баталсан; (ii) СТБЗ-ийн гишүүн байгууллагуудаас хэрэгжүүлж буй макро эдийн засаг, санхүүгийн салбарын бодлогын уялдааг дээшлүүлэх, СТБЗ-өөс санхүүгийн салбарын эрсдэлийн хамтарсан дүн шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай тоон мэдээллийн цар хүрээг өргөтгөх зорилгоор холбогдох байгууллагуудын дунд статистик, мэдээллийн цахим санг бий болгох ажлыг эхлүүлээд байна. Энэ хүрээнд СТБЗ-ийн гишүүд “Макро эдийн засаг болон санхүүгийн статистик мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, ашиглах журам”-ыг хамтарсан тушаалаар батлаад байна.

2013 онд СТБЗ-өөс Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам бэлтгэн, олон нийтэд хүргэх үүрэгтэй, байнгын үйл ажиллагаатай нэгж бий болгохоор шийдвэрлэсний дагуу СТБЗ-ийн Ажлын албыг Монголбанкинд төвлөрүүлэн ажиллуулж байна.

СТБЗ-ийн Ажлын алба нь Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох газруудтай хамтран ажиллаж, тайлан мэдээллийг хүлээн авч, “Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн эхний 11 дугаарыг нэгтгэн боловсруулж, хэвлүүлэн, Монголбанкны цахим хуудаст байршуулж, олон нийтийн хүртээл болгосон бөгөөд ийнхүү 12 дахь дугаарыг Та бүхэнд хүргэж байна.